

**Монгол Улсын Боловсрол,
Шинжлэх Ухааны Яам**

**Монгол Улсын
“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн
дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”**

**Төслийн үйл ажиллагааны эцсийн
тайлан**


2013 оны 9 дүгээр сар

**Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны
Байгууллага
(JICA)**

“Кооэй” судалгааны хүрээлэн

MG
JR
13-002

Төслийн үйл ажиллагаа ба Монгол Улсын газрын зураг



Төслийн үйл ажиллагааны фото зураг



Сургалтын багц Материал боловсуулах эхний хурал
2010 оны 5сар



Загвар аймгийн багтай уулзалт
2010 оны 9 сар



Арга зүйн сургалт
2010 оны 11 сар



Хичээлийн судалгааны мониторинг
2011 оны 3 сар



Анхны Хамтарсан зөвлөлийн хурал
2011 оны 5 сар



Хичээлийн судалгааны тайлангийн хурал
2011 оны 6 сар



Багш бэлтгэдэг их сургуулиудад сургалтын багц материалыг танилцуулав
2011 оны 8 сар



Японд сургалт
2011 оны 9-10 сар



Архангай аймагт зориулсан сургалт
2012 оны 3 сар



Гуравдагч оронтой туршлага солилцов
2012 оны 5 сар



Хичээлийн судалгаа видео бүтээв
2012 оны 9 сар



Хичээлийн судалгааны мониторинг
2012 оны 9-10 сар



Хичээлийн судалгааны мониторинг
2013 оны 3-4 сар



Японд сургалт
2013 оны 5-6 сар



Сургалтын багц материалыг боловсруулж дуусгав
2013 оны 7 сар



Хичээлийн судалгаа сэдэвт үндэсний анхдугаар
эрдэм шинжилгээний бага хурал
2013 оны 8 сар

Төслийн хураангуй

Төслийн нэр: (Монгол) “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”

(Англи) Project for Strengthening Systems for Improving and Disseminating Child-Centered Teaching Methods

Зорилтот улс: Монгол

Хэрэгжсэн газар: Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Булган аймаг, Завхан аймаг

Гэрээнд гарын үсэг зурсан өдөр: 2009 оны 12 сарын 8 (2013 оны 1 сарын 31: Төслийг 6 сарын хугацаагаар сунгах тухай)

Хугацаа: 2010 оны 3 сарын 1-нээс 2013 оны 8 сарын 31 (2013 оны 3 сарын 1-нээс хойш сунгасан хугацааг тооцно)

Хэрэгжүүлэгч байгууллага: Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (Монголоор)
Ministry of Education and Science (Англиар)

Танилцуулга: Саяхныг хүртэл Монголын сургуулиуд уламжлалт цээжлүүлэх аргаар хичээлээ зохион байгуулж иржээ. Энэхүү асуудлыг шийдвэрлэх үүднээс Монгол Улсын Засгийн газар 2005 оны 9 сард боловсролын шинэ стандарт (Энэ нь үндэсний хөтөлбөр, Японы боловсролын стандарттай дүйцнэ) боловсруулан, тэр дундаа хүүхдийн сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй” (хойшид суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэх) нэвтрүүлсэн юм. Гэвч, уг стандарт нь хэт академик агуулгатай байсан нь багш нарт ойлгоход хүндрэлтэй, уламжлалт цээжлүүлэх арга хэт хэвшчихсэн байсны улмаас заах арга зүйгээ өөрчлөхөд амаргүй байх зэрэг асуудлууд тулгамджээ.

Энэ байдалтай холбогдуулан, 2006-2009 онд ЖАЙКА нь “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил төсөл”-ийг хэрэгжүүлэн, боловсролын шинэ стандартад нийцүүлсэн багшид зориулсан зөвлөмж (Физик, Хими, Хүн орчин, Хүн байгаль, Математик /бага/, Математик /суурь/, Мэдээлэл зүй, Төсөлт ажил), зөвлөмж боловсруулах гарын авлага, хичээлд мониторинг хийх гарын авлага зэргийг боловсруулсан. Уг зөвлөмжүүдийг Монгол Улсын БСШУЯ өндөр үнэлсэн ба зөвлөмжийг түгээх ажилд сайдын тушаал гаргах зэргээр дэмжлэг үзүүлж, нийт сургуулиудад хэвлүүлэн тараасан. Цаашид, ЕБС-ийн багш нар суралцахуйд суурилсан багшлах арга зүйг зөв ойлгон хүлээн авч, хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Төслийн хүрээнд, бага дунд боловсролын салбар дахь суралцагчдын суралцах чадварыг дээшлүүлэх явдлыг алс хэтийн зорилгоо болгон, төслийн загвар болон бусад аймагт суралцахуйд суурилсан багшлах арга зүйг хэрэгжүүлэх явдлыг эрхэм зорилго болгон тодорхойлсон юм. Үндэсний түвшинд суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх “Мэргэжлийн баг”¹-ийг бүрдүүлэн, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх ажлыг гардан хийх бүх аймаг, дүүргийн БСГ/БХ-ийн мэргэжилтнүүд болон бүх сургуулийн удирдлага, багш нарын төлөөллөөс бүрдсэн

¹ Төслийн үйл ажиллагааны гол цөм нь бөгөөд сургалтын багц материал боловсруулах, засан сайжруулах, загвар аймаг, дүүргийн сургалт болон хичээлийн судалгааны мониторинг зохион байгуулах. Боловсролын хүрээлэнгийн судлаачид, бүх дидактикийн төвийн гишүүд (МУИС, МУБИС), ЕБС-ийн багш нараас бүрдэнэ.

“Аймаг, дүүргийн баг”²-ийн ур чадварыг бэхжүүлэхэд (Үр дүн 1) бүх аймаг, дүүргийн БСГ/БХ нь багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоог ашигласнаар багш нарт суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэхийг зорьсон (Төслийн зорилго). Бүх аймгийн холбогдох хүмүүсийн ур чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулахын өмнө загвар аймаг, дүүрэг дэх сургалтыг туршилтын журмаар зохион байгуулж, үр дүнг нь сургалтын материалд тусгана (Үр дүн 3). Мөн, шинэ арга зүйг хэрэгжүүлэхэд зөвхөн арга зүйн сургалт зохион байгуулах бус өдөр тутмын хичээл сургалтын үйл ажиллагаагаа шинэчлэх нь чухал гэж үзсэн тул, сургуулидад тохирсон хичээлийн судалгааны загварыг буй болгон, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх арга хэрэгсэл болгон ашиглана (Үр дүн 2). Улмаар, багш бэлтгэдэг их дээд сургуулиудад танилцуулах, хичээлийн судалгааг тогтмолжуулахад чиглэсэн судалгааны үйл ажиллагаа, бодлогын зөвлөмж зэргээр дамжуулан, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх орчинг боловсронгуй болгоно (Үр дүн 4).

Энэхүү төсөл нь 2013 оны 2 сард дуусгавар болох ёстой байсан боловч, 2012 оны 9 сард БМДИ нь төслийн гол хамтран ажиллагч байгууллага болсон зэргээр Монголын талын тогтолцоонд өөрчлөлт гарч, төслийн хугацааг 2013 оны 8 сар хүртэл сунгасан.

Төслийн биелэлт:

2012 оны 9 сарын 30-наас 10 сарын 19-нд зохион байгуулагдсан төслийн эцсийн шатны үнэлгээгээр, төслийн зорилгыг “Их төлөв биелэгдсэн” гэж үзсэний зэрэгцээ төслийн зорилтот бус судлагдахуунаар ч (Монгол хэл, Түүх г.м) хичээлийн судалгаа хийгдэж байгаа, төслийн үйл ажиллагаа хязгаарлагдмал загвар бус аймаг, дүүргүүдэд ч бие даасан суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалт, хичээлийн судалгаа зохион байгуулагдаж байгаа зэрэг “Тооцоолсноос илүү их үр нөлөө үр нөлөө гарсан” гэж үнэлэгдсэн.

2012 оны 9 сард БМДИ (Institute of Teacher’s Professional Development) байгуулагдан³, төслийн гол хамтран ажиллагч байгууллагаболсон зэргээс төслийн хугацааг сунгасан бөгөөд энэ хугацаанд БМДИ-д зориулан суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүллээ.

Төслийн биелэлтийг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт S-1: Төслийн биелэлт

Төслийн товч	Шалгуур үзүүлэлт	Биелэлт	
		Төслийн эцсийн шатны үнэлгээний үед гарсан үр дүн (2012 оны 9 сар)	Төслийн эцсийн шатны үнэлгээнээс хойш гарсан үр дүн
Хэтийн зорилго: Бага, дунд сургуулийн сурагчдын суралцах чадварыг	Суралцах чадварын шалгалт	2011 онд Завхан аймгийн БСГ-ээс зохион байгуулсан түвшин тогтоох шалгалтын дүнг загвар бус 25 сургууль, загвар 6 сургуулиар хуваан харьцуулсан. Шалгалтын үнэлгээг А, В, С, D, F гэж 5	

² Мэргэжлийн багийн зохион байгуулах сургалтад хамрагдах аймаг, дүүргийн төлөөлөл. Бүх аймаг, дүүргийн СӨБ-оос бусад судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд, сургуулийн удирдлага, багш нараас бүрдэнэ. Нэг баг 10-11 гишүүнтэй. (Удирдлага 2-3 хүн, төслийн зорилтот 8 судлагдахуун хариуцсан мэргэжилтэн, эсвэл багш тус бүр нэг хүн)

³ Социализмын үед багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулдаг мэргэжлийн байгууллага байсан боловч, ардчилалд шилжсэнээс хойш татан буугдсан.

дээшлүүлнэ.		хуваан үзэж, А-аас D хүртэлхийг тэнцсэнд тооцсон. Загвар бус сургуулийн хувьд А үнэлгээ 6.7%, АВ үнэлгээ 15.1%, ABCD үнэлгээ 43.8%, Загвар сургуулийн хувьд А үнэлгээ 6.3%, АВ үнэлгээ 15.1%, ABCD үнэлгээ 46% байв. Загвар бус болон загвар аймгийн дүнгийн тухайд, түвшин тогтоох шалгалт авсан ч статистик үзүүлэлтээр тодорхой ялгаа ажиглагдаагүй.	
Эрхэм зорилго: Загвар болон бусад аймаг дүүргийн багш нар суралцахуйд суурилсан багшлах арга зүйг туршин хэрэгжүүлнэ.	1) Загвар бус аймаг, дүүргийн сургуулиудын 60-иас доошгүй хувь нь жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулах.	2011-2012 оны хичээлийн жилд нэгээс дээш хичээлийн судалгаа хийсэн сургууль үндэсний хэмжээний 747 сургуулиас 476 байв.	2012-2013 оны хичээлийн жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа хийсэн сургууль нийт 752 сургуулиас 487 байв. (Ойролцоогоор 65%)
	2) Бүх аймаг, дүүрэгт суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалт зохион байгуулах.	<ul style="list-style-type: none"> • 2011-2012 оны хичээлийн жил⁴-д Улаанбаатар хот болон 21 аймгийн 19-д нь суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны сургалт зохион байгуулсан. • Улаанбаатар хотын хувьд НБГ судлагдахуун тус бүрээр 32 удаа сургалт явуулж, 1800 хүн хамрагдсан. 	<ul style="list-style-type: none"> • 2012-2013 оны хичээлийн жилд суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны сургалтыг Улаанбаатар хот болон 21 аймгаас 16 аймаг зохион байгуулсан. • Эдгээр сургалтад давхардсан тоогоор 14932 багш оролцсон. (Нийт багшийн тоо 26492)
Төслийн зорилго: Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлнэ.	1) Загвар сургуулиудын зорилтот 8 судлагдахуунд суралцахуйд суурилсан багшлах арга зүйгээр дамжуулан чанарын өндөр түвшинд хичээл зохион байгуулж хэвших.	Хавсралт 4-ийг үзнэ үү.	
	2) Загвар аймаг, дүүргийн сургуулиудын 70-аас доошгүй	2011-2012 оны хичээлийн жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа хийсэн сургуулийн тоог доор	2012-2013 оны хичээлийн жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа хийсэн сургуулийн тоог доор

⁴ Монголд хичээлийн шинэ жил 9 сард эхлэн, дараа жилийнх нь 6 сард дуусдаг.

	хувь нь жилд 2 удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан байх.	үзүүлэв. • СХД: 13 сургууль (100%) • Булган: 23 сургуулиас 18 (Ойролцоогоор 78%) • Завхан: 29 сургууль (100%)	үзүүлэв. • СХД: 13 сургууль (100%) • Булган: 23 сургуулиас 16 (Ойролцоогоор 70%) • Завхан: 29 сургууль жилд 2-оос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан (100%)
	3) Бүх аймаг, дүүргийн БГ/БХ нь хичээлийн судалгааны сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан байх.	21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг хичээлийн судалгааны сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан.	
	4) Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бий болгох зорилготой бодлого, төсөв, хүний нөөцийн асуудлыг БСШУЯ шийдвэрлэх. (Шинэ арга зүй түгээн дэлгэрүүлэхтэй тухай БШУ-ны Сайдын тушаал гаргах)	БСШУЯ нь төсөлтэй холбоотойгоор олон тооны сайдын тушаал, газрын даргын тушаал шийдвэрүүд гаргасан. Суралцахуйд суурилсан багшлах арга зүй түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бий болгоход шууд хувь нэмэр оруулсан тушаал шийдвэрийг доор дурьдав. • БСШУЯ-ны ЕБГ-ын даргын 2011 оны 9 сарын 9-ний 3/4973 тоот тушаал (Мэргэжлийн багийн гишүүдийн үндсэн ажлын ачааллыг багасгах тухай хүсэлт) • БШУ-ны Сайдын 2012 оны 1 сарын 18-ны 24 тоот тушаал (Төслийн холбогдох байгууллагуудад багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах тухай) • БСШУЯ-ны ЕБГ-ын даргын 2012 оны 1 сарын 31-ний 3/427 тоот тушаал (Багш бэлтгэдэг их дээд сургуулиудад багш нарын мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалт зохион байгуулах тухай) • БШУ-ны Сайдын 2012 оны 9 сарын 10-ны А-13 тоот тушаал (Загвар бус аймагт сургалт зохион байгуулах тухай)	
Үр дүн 1: Бүх аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх багийн ур чадвар дээшилнэ.	1) Сургалтад оролцогчдын сэтгэл ханамж болон суралцахуйд суурилсан багшлах арга зүйн талаарх ойлголтыг дээшлүүлэх.	2011 оны 11 сард 6 газарт зохион байгуулсан бүх аймаг, дүүргийн багт зориулсан сургалтаар тодорхой болсон оролцогчдын сэтгэл ханамж, ойлголтыг доор үзүүлэв. • Сэтгэл ханамж ⁵ : 6 сургалтын бүх үзүүлэлт 5 шатны үнэлгээгээр 4-өөс дээш оноо авсан. • Ойлголт: Сургалтын сүүлийн өдөр сургуулийн удирдлагаас	2012 оны 11 сард 6 газарт зохион байгуулсан бүх аймаг, дүүргийн багт зориулсан сургалтаар тодорхой болсон оролцогчдын сэтгэл ханамж, ойлголтыг доор үзүүлэв. • Сэтгэл ханамж: 6 сургалтын бүх үзүүлэлт 5 шатны үнэлгээгээр 3.9-өөс дээш оноо авчээ. Мөн, сэтгэл ханамж сургалтын төгсгөл рүү улам дээшилжээ. • Ойлголт: Сургалтын эхний

⁵ Дараах 5 үзүүлэлтээр оролцогчдын сэтгэл ханамжийг судалсан. (1) Сургалтын зорилго ба агуулга нийцэж байна уу? (2) Сургагч багшийн яриа ойлгомжтой байсан уу? (3) Цаг ашиглалт үр дүнтэй байсан уу? (4) Лекц дадлагын харьцаа тохиромжтой байсан уу? (5) Тараах материал болон сургалтын байр тохиромжтой байсан уу?

		“Суралцахууд суурилсан багшлах арга зүй гэж юу вэ?” багш нараас “Хичээлийн бэлтгэл судалгаа гэж юу вэ?” гэсэн асуулга явуулсан. Эхний асуултад 74 хүнээс 11 (15%) нь зөв хариулж, 2 дахь асуултад 217 хүнээс 86 (40%) нь зөв хариулжээ.	болон сүүлийн өдөр “Суралцахууд суурилсан багшлах арга зүй гэж юу вэ?”, “Хичээлийн судалгаа гэж юу вэ?”, “Хичээлийн бэлтгэл судалгаа гэж юу вэ?” гэсэн асуулга явуулсан бөгөөд оролцогчдын ойлголт их төлөв дээшилсэн болох нь батлагдсан.
	2) Сургалтад оролцогчдын үйл ажиллагаанд эерэг өөрчлөлт гаргах.	<ul style="list-style-type: none"> • 2011-2012 оны хичээлийн жилд үндэсний хэмжээний нийт 747 сургуулийн 476 (Ойролцоогоор 64%) нь нэгээс дээш удаа хичээлийн судалгаа хийсэн. • 2011-2012 оны хичээлийн жилд Улаанбаатар хот болон 21 аймгаас 19 аймагт хичээлийн судалгааны сургалт зохион байгуулагдсан. • Бүх аймагт “Аймгийн баг” бүрдсэн. 	<ul style="list-style-type: none"> • 2012-2013 оны хичээлийн жилд үндэсний хэмжээний 752 сургуулийн 487 нь (Ойролцоогоор 65%) хоёроос дээш удаа хичээлийн судалгаа хийсэн. • 2012-2013 оны хичээлийн жилд Улаанбаатар хот болон 21 аймгаас 16 аймагт хичээлийн судалгааны сургалт зохион байгуулагдсан.
	3) Бүх аймаг, дүүргийн багийн гишүүд сургалтын багц материалд үндэслэсэн сургалтад хамрагдсан байх (Доод тал нь 8 хүн)	• 2011 оны 11 сард зохион байгуулсан бүх аймаг, дүүргийн багт зориулсан сургалтад Архангай аймгийн багийг тооцохгүйгээр 9 дүүрэг, 20 аймгийн тус бүр 11 хүнтэй баг оролцсон.	<ul style="list-style-type: none"> • 2012 оны 3 сард Архангай аймагт зориулсан сургалтыг жич зохион байгуулсан. • 2012 оны 11 сард зохион байгуулсан бүх аймаг, дүүргийн багт зориулсан сургалтад Архангай аймгийн багийг тооцохгүйгээр 9 дүүрэг, 20 аймгийн тус бүр 10 хүнтэй баг оролцсон.
Үр дүн 2: Загвар аймаг, дүүрэгт хичээлийн судалгааны загвар бий болно.	1) Загвар сургуулиуд хичээлийн судалгааны төлөвлөгөө боловсруулах.	2010-2011 оны хичээлийн жил (2010 оны 11 сараас хойших), 2011-2012 оны хичээлийн жилд бүх загвар сургууль (14) төлөвлөгөө боловсруулсан.	2012-2013 оны хичээлийн жилд, бүх загвар сургуулиуд (14) төлөвлөгөө боловсруулсан.
	2) Загвар сургуулиуд хичээлийн судалгааг 8 судлагдахуунаар нэг хичээлийн жилд 2 удаа зохион байгуулах.	14 сургуулийн 8-д нь 2011-2012 оны хичээлийн жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа хийгдсэн.	14 сургуулийн 13-т нь 2012-2013 оны хичээлийн жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа хийгдсэн.
	3) Загвар сургуулийн хичээлийн	Хавсралт 5-ыг үзнэ үү.	

	судалгааны чанарыг дээшлүүлэх.		
	4) Загвар сургуулиудын хичээлийн судалгаанд оролцогчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх.	<ul style="list-style-type: none"> СХД-ийн загвар сургуулиуд: 2010 онд хичээлийн судалгаанд оролцсон 81 хүнээс “Хичээлийн судалгаанд маш их сэтгэл ханамжтай” гэж хариулсан хүн 20% -ийг эзэлсэн бол 2012 онд энэ тоо 53% болжээ. Булган аймгийн загвар сургуулиуд: Хичээлийн судалгаанд оролцсон 73 хүнээс 2010 онд хичээлийн судалгаанд маш их сэтгэл ханамжтай” гэж хариулсан хүн 25% байсан бол энэ тоо 2012 онд 58% болсон. Завхан аймгийн загвар сургуулиуд: Хичээлийн судалгаанд оролцсон 129 хүнээс 2010 онд “Хичээлийн судалгаанд маш их сэтгэл ханамжтай” гэж хариулсан хүн 26% байсан бол 2012 онд энэ тоо 67% болжээ. 	
Үр дүн 3: Загвар аймаг, дүүргийн багш нарын суралцахуйд суурилсан багшлах ур чадвар дээшилнэ.	1) Загвар аймаг, дүүргийн загвар бус сургуулиудын 70-аас доошгүй хувийн төлөөлөл модульг сургалтад хамрагдсан байх.	<p>2011-2012 оны хичээлийн жилд суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалтад хамрагдсан хүний тоо доор дурьдав.</p> <ul style="list-style-type: none"> СХД: Удирдлага 74, багш 1493, үүнээс 1080 хүн (72%) Булган: 724 хүнээс 550 (76%) Завхан: Удирдлага 72 хүнээс 58 (81%), 885 багшаас 639 (72%) 	<p>2012-2013 оны хичээлийн жилд суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалтад хамрагдсан хүний тоо доор дурьдав.</p> <ul style="list-style-type: none"> СХД: Тодорхойгүй Булган: 541 хүнээс давхардсан тоогоор 889 хүн Завхан: Удирдлага болон багш давхардсан тоогоор 2339
	2) Загвар аймаг, дүүргийн загвар бус сургуулиудын 80-иас доошгүй хувь нь хичээлийн судалгаа хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах.	<p>2011-2012 оны хичээлийн жилд хичээлийн судалгааны төлөвлөгөө боловсруулсан сургуулийн тоог доор үзүүлэв.</p> <ul style="list-style-type: none"> СХД: 13 сургууль (100%) Булган: 23 сургуулиас 19 (83%) Завхан: 29 сургууль (100%) 	<p>2012-2013 оны хичээлийн жилд хичээлийн судалгааны төлөвлөгөө боловсруулсан сургуулийн тоог доор үзүүлэв.</p> <ul style="list-style-type: none"> СХД: 13 сургууль (100%) Булган: 23 сургууль (100%) Завхан: 29 сургууль (100%)
	3) Загвар аймаг, дүүргээс суралцахуйд суурилсан багшлах ур чадварыг дээшлүүлэх туршлага сургамж, зөвлөгөөг цуглуулах.	<p>“Багшлахуйн арга зүйн хөгжил: Хичээлийн судалгаанд удирдлагын үүрэг оролцоо” модуль, “Багшлахуйн арга зүйн хөгжил: Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент” гарын авлагыг боловсруулахаар төлөвлөсөн.</p>	<p>“Багшлахуйн арга зүйн хөгжил: Хичээлийн судалгаанд удирдлагын үүрэг оролцоо” модуль болон “Багшлахуйн арга зүйн хөгжил: Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент” гарын авлагыг боловсруулсан.</p>
Үр дүн 4: Багш бэлтгэх шатанд суралцахуйд суурилсан	1) Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг багш бэлтгэдэг их	<ul style="list-style-type: none"> МУИС-ийн ХХИС, ФЭС дээр “Хичээлийн судалгааны арга зүй” хичээл орж байна. “Хичээлийн судалгаа: 	<ul style="list-style-type: none"> МУИС-ийн ГГС дээр “Хичээлийн судалгааны арга зүй” хичээл орж байна. “Хичээлийн судалгаа:

багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх орчин боловсронгуй болно.	дээд сургуулиудын сургалтад нэвтрүүлнэ.	Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр” модулийг боловсруулахаар төлөвлөсөн.	Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан сургалтын хөтөлбөр” боловсруулсан.
	2) БСШУЯ бодлогын зөвлөмжийг бодлого зорилтдоо тусгана.	БСШУЯ-ны 2010-2011 оны хичээлийн жилийн зорилтод “Бүх багш хичээлийн судалгааны арга зүй /багшлахуйн арга зүйг судлах, бүх сургууль хичээлийн судалгааны төлөвлөгөө боловсруулан, энэ хичээлийн жилд 2-оос доошгүй удаа хичээлийн судалгаа хийх” гэж тусгагдсан.	

Дээр дурьдсанчлан, төслийн анх төлөвлөсөн хугацаанд төслийн зорилго, үр дүн их төлөв биелэгдсэн байна. Гэхдээ, мэргэжлийн багийн зохион байгуулалт, загвар аймаг, дүүрэг, загвар сургуулийн сонголт, сургалтын багц материалыг турших тогтолцоог 2010 оны 11 сард бүрдүүлснийг харгалзан үзвэл, зөвхөн 2011-2012 оны хичээлийн жил буюу 1 жилийн хугацаанд л төсөл хангалттай хэмжээнд үйл ажиллагаа хэрэгжүүлжээ. Иймд, “Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх (Төслийн зорилго)”, “Загвар болон бусад аймаг дүүргийн багш нар суралцахуйд суурилсан багшлах арга зүйг туршин хэрэгжүүлэх (Эрхэм зорилго)” гэсэн зорилго биелэх магадлал тодорхойгүй байдалтай болсон. Төслийн хугацааг хагас жилээр сунган, 2011-2012 болон 2012-2013 оны хичээлийн жил гэсэн 2 жилийн туршид үйл ажиллагаа явуулах боломжтой болсноор төслийн зорилго, үр дүнг хэвшүүлэн, эрхэм зорилгыг биелүүлэх магадлал бий болсон юм.

Төсөл хэрэгжих хугацаанд эрхэм зорилгын индексүүд хангагдсан гэдэг үүднээс онцлон тэмдэглүүштэй зүйл нь 2013 оны 8 сарын байдлаар үндэсний хэмжээний нийт 752 сургуулийн 487 (Ойролцоогоор 65%) нь 2012-2013 оны хичээлийн жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан болон 2012-2013 оны хичээлийн жилд Улаанбаатар хот болон 21 аймгийн 16 нь хичээлийн судалгааны сургалт зохион байгуулсан явдал байлаа.

Үүний нэг хүчин зүйл болгож, Монголд үндэсний хэмжээнд багшлахуйн арга зүй хөгжлийг таньж мэдэх болсны зэрэгцээ шаардлага нь өндөрсөж байгааг дурьдаж болно. Монголд өнөөдөр боловсролын шинэчлэл эрчимтэй явагдаж байгаа бөгөөд боловсрол холбогдох хуулийг хэрэгжүүлэх шинэ дүрэм журмууд ар араасаа хөврөн гарч, шинэ зохион байгуулалтууд буй болон, боловсролын стандарт болон сурах бичиг шинэчлэлийн ажил туршигдах зэргээр өөрчлөлтийн цаг үе үргэлжилсээр байна. 2012 оны 6 сард эмхлэн байгуулагдсан шинэчлэлийн засгийн газар “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” зорилт тавин ажиллах болсноор, багшлахуйн арга зүйн хөгжлийн талаарх ойлголт, хэрэгцээ шаардлага өндөрсөн, төслийн эхний шатнаас хойш тус төслийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн багшлахуйн арга зүйн шинэчлэлийг хүлээн авах хөрс суурь түргэн хугацаанд бүрдсэн. Энэ цаг үед төсөл хэрэгжсэн явдал ч бас чухал байлаа. Түүнчлэн, 2012 оны 9 сард байгуулагдсан БМДИ нь арга зүйч нартаа төслийн сургалт болон Япон дахь сургалтад хамруулан, мэргэжлийн багтай хамт хичээлийн судалгааны мониторингт оролцуулан туршлагажуулах зэргээр багшлахуйн арга зүйн хөгжил болон хичээлийн судалгааны талаарх ойлголтыг нь гүнзгийрүүлж ирсэн. Мөн, төслийн хүрээнд тус БМДИ-ийн сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулахал нь дэмжлэг үзүүлсэн зэргээр, тус

БМДИ-ийн зохион байгуулдаг үндсэн сургалт⁶ зэрэгт хичээлийн судалгааг сургууль дээр багшлахуйн арга зүйг хөгжүүлэх арга хэрэгсэл хэмээн танилцуулах болсон.

Хоёр дахь хүчин зүйлд, Монголд хичээлийн судалгаагаар дамжуулсан багшлахуйн арга зүйн шинэчлэлийг хүлээн зөвшөөрөгддөж, үндэс суурь нь тавигдаж байгааг дурьдаж болох юм. 2011-2012, 2012-2013 оны хичээлийн жил гэсэн 2 жилийн туршид бүх загвар сургуулийн хичээлийн судалгааны хэрэгжилтийг хянах боломжтой болж, хичээлийн судалгааг төслийн үйл ажиллагаа төдийгүй өөрсдийн сургуулийн үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэх болсон. Сургалтын багц материалд багтсан “Багшлахуйн арга зүйн хөгжил: Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент” гарын авлагад, Монголд хэрэгжиж буй хичээлийн судалгааг төрөл загварт хуваан авч үзсэн байна. Мөн, “Багшлахуйн арга зүйн хөгжил: Хичээлийн судалгаанд удирдлагын үүрэг оролцоо” модульд загвар сургуулиудын сургуульд суурилсан хичээлийн судалгаа⁷-ны талаар тэмдэглэгджээ. Эдгээр нь хичээлийн судалгаагаар дамжин багшлахуйн арга зүйн шинэчлэл болон сургуулийн менежмент Монголд хэрэгжин, байгаагүй итгэл найдвар хүлээлгэж байгаагийн илрэл гэж болно.

Цаашид, арга зүйчдийг ашиглах болон багш нарыг үнэлэхэд анхаарал хандуулж, хичээлийн судалгаагаар дамжуулан багшлахуйн арга зүйг шинэчлэх тогтолцоог улам бүр бэхжүүлэхийн хамт багш нарын мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн ажлын байрны шаардлагыг өндөрсгөх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх нь чухал юм.

⁶ Шинэчлэлийн засгийн газар байгуулагдсанаас хойш шинэ багш, 5 жил ажилласан багш, 10 жил ажилласан багш нарын сургалтыг зохион байгуулагдах болсон (Орон нутгийн БГ-ууд тус тусдаа 2, 3, 4 дэх жилийн сургалтыг зохион байгуулах болсон).

⁷ Сургуулиуд хичээлийн судалгааны сэдэв сонгон, таамаглал дэвшүүлж, хичээлийн судалгааг зохион байгуулах, судалгааны үр дүнгээ хэлэлцүүлэх үйл ажиллагаа.

“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”

(Төслийн хоёр дахь шат)

Төслийн үйл ажиллагааны эцсийн тайлан

Гарчиг

Төслийн үйл ажиллагаа ба Монгол Улсын газрын зураг

Төслийн үйл ажиллагааны фото зураг

Хураангуй

БҮЛЭГ I ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ БА ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	1
1.1 Төслийн үндэслэл	1
1.2 Төслийн танилцуулга	2
1.3 Монголын боловсролын шинэчлэлийн төлөв байдал	4
БҮЛЭГ II ТӨСЛИЙН БИЕЛЭЛТ	8
2.1 Төслийн зорилго	8
2.2 Төслийн хүрэх үр дүн	12
(1) Үр дүн 1	12
(2) Үр дүн 2	16
(3) Үр дүн 3	20
(4) Үр дүн 4	22
2.3 Эрхэм зорилго	26
2.4 Хэтийн зорилго	28
БҮЛЭГ III ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ	29
3.1 ЭХНИЙ ЖИЛ (2010 оны 3 сар - 2011 оны 3 сар)	29
(1) Үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх төлөвлөгөөний талаар	29
(2) Төсөл хэрэгжүүлэх тогтолцоо буй болов	29
(3) Японд сургалт зохион байгуулав	30
(4) Үр дүн 1-тэй холбоотой үйл ажиллагаа	31
(5) Үр дүн 2-той холбоотой үйл ажиллагаа	36
(6) Үр дүн 4-тэй холбоотой үйл ажиллагаа	38
3.2 ХОЁР ДАХЬ ЖИЛ (2011 оны 4 сар - 2011 оны 12 сар)	38
(1) Японд сургалт зохион байгуулав	38
(2) Үр дүн 1-тэй холбоотой үйл ажиллагаа”	39
(3) Үр дүн 2-той холбоотой үйл ажиллагаа	43
(4) Үр дүн 3-тай холбоотой үйл ажиллагаа	45
(5) Үр дүн 4-тэй холбоотой үйл ажиллагаа	45
3.3 ГУРАВ ДАХЬ ЖИЛ (2012 оны 2 сар - 2013 оны 1 сар)	46
(1) Японд сургалт зохион байгуулав	46
(2) Гуравдагч оронтой туршлага солилцов	47
(3) Үр дүн 1-тэй холбоотой үйл ажиллагаа	48
(4) Үр дүн 2-той холбоотой үйл ажиллагаа	53
(5) Үр дүн 3-тай холбоотой үйл ажиллагаа	55
(6) Үр дүн 4-тэй холбоотой үйл ажиллагаа	57
(7) Бусад үйл ажиллагаа	58
3.4 ТӨСЛИЙН ГУРАВ ДАХЬ ЖИЛИЙН СУНГАГДСАН ХУГАЦААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (2013 оны 3 сар - 2013 оны 8 сар)	59
(1) Японд сургалт зохион байгуулав	59
(2) Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулахад үзүүлсэн дэмжлэг	61
(3) БМДИ-д үзүүлсэн дэмжлэг	61
(4) Мэдлэг, мэдээллээ хуваалцах семинар, ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулав ..	62

(5) Үр дүн 1-тэй холбоотой үйл ажиллагаа	62
(6) Үр дүн 2-той холбоотой үйл ажиллагаа	65
(7) Үр дүн 4-тэй холбоотой үйл ажиллагаа	66
БҮЛЭГ IV БУСАД	68
4.1 Хамтарсан зөвлөлийн хурлыг (JCC) зохион байгуулав.....	68
(1) Анхны Хамтарсан зөвлөлийн хурал.....	68
(2) Хоёр дахь удаагийн Хамтарсан зөвлөлийн хурал	68
(3) Гурав дахь удаагийн Хамтарсан зөвлөлийн хурал	71
(4) Дөрөв дэх удаагийн Хамтарсан зөвлөлийн хурал	72
4.2 Төслийн анхны болон эцсийн төлөв байдлын судалгаа хийв.....	73
(1) Төслийн анхны төлөв байдлын судалгаа хийв	73
(2) Төслийн эцсийн төлөв байдлын судалгаа хийв	74
4.3 Сурталчилгааны үйл ажиллагаа	76
(1) Цахим хуудас	76
(2) Төслийн мэдээлэл.....	76
(3) Сонины нийтлэл	76
4.4 ЖАЙКА-гийн бусад төсөл болон хөгжлийн бусад түнштэй уялдсан нь.....	77
(1) ЖАЙКА-гийн сайн дурын гишүүдтэй уялдсан нь.....	77
(2) ЖАЙКА-гийн бусад төсөлтэй уялдсан нь	79
(3) Хөгжлийн бусад түнштэй уялдсан нь	79
БҮЛЭГ V ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГАРСАН САНАЛ САНААЧЛАГА, ТУРШЛАГА СУРГАМЖ БА ЗӨВЛӨМЖ.....	80
5.1 Төслийн хүрээнд гарсан санал санаачлага	80
(1) Загвар аймаг, дүүрэгт түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн санал санаачлага	80
(2) Үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн санал санаачлага	82
5.2 Монголын тал өгөх зөвлөмж	84
(1) Багшийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд өгөх зөвлөмж	84
(2) Багшийн мэргэжлийн ур чадварыг (Professionalism) дээшлүүлэхэд чиглэсэн зөвлөмж.....	88
БҮЛЭГ VI ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	91
6.1 Японы мэргэжилтэн	91
6.2 Тоног төхөөрөмж.....	91
6.3 Сургалтад оролцуулсан тухай	92
6.4 Эцсийн бүтээгдэхүүн.....	95
6.5 Монгол дахь үйл ажиллагааны зардал.....	96
(1) Японы тал	96
(2) Монголын тал.....	97

Хавсралт материал:

1. Мэргэжлийн багийн гишүүдийн нэрсийн жагсаалт
2. Хичээлийн судалгааны үндэсний сургагч багш, зөвлөх, эксперт нарын нэрс
3. Хичээлийн судалгааны бүсийн сургагч багш нарын нэрс
4. Хичээлийн чанар
5. Хичээлийн судалгааны чанар
6. Төсөлтэй холбоотойгоор БСШУЯ-наас гаргасан сайдын болон газрын даргын тушаал
7. Монголын талын хариуцсан зардал төсөв
8. Төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн уулзалтын эцсийн бүтээгдэхүүн
9. БМДИ-ийн сургалтын төлөвлөгөө

10. Хамтарсан зөвлөлийн хурлын (JCC) протокол
11. Төслийн хүрэх үр дүнгийн хураангуй (2011 оны 9 сарын хувилбар)
12. Төслийн мэдээлэл
13. “Багш” сонин
14. Plan of Operation
15. Мэргэжилтэн томилон ажиллуулсан тухай
16. Дагалдах хэрэгслийн жагсаалт

Зураг:

Зураг 1-1: Төслийн үйл ажиллагааны бүдүүвч.....	3
Зураг 2-1: Сургалтын сэтгэл ханамж.....	14
Зураг 3-1: Цахим хуудсын бүтэц	52

Хүснэгт:

Хүснэгт S-1: Төслийн биелэлт	S-2
Хүснэгт 1-1: Төслийн хураангуй	2
Хүснэгт 1-2: Хуулийн нэмэлттэй уялдсан өөрчлөлтүүд	5
Хүснэгт 2-1: Загвар аймаг, дүүрэгт хоёроос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан сургуулийн тоо	9
Хүснэгт 2-2: 2011 оны сургалтын сэтгэл ханамж (5 хоногийн дундаж)	12
Хүснэгт 2-3: 2012 оны сургалтын сэтгэл ханамж (4 хоногийн дундаж)	13
Хүснэгт 2-4: Сургалтын ойлголт	14
Хүснэгт 2-5: Загвар сургуулиудын хичээлийн судалгаа зохион байгуулсан тоо.....	16
Хүснэгт 2-6: Загвар аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалтад хамрагдагсадын тоо	21
Хүснэгт 2-7: Загвар аймаг, дүүрэгт “Хичээлийн судалгаа” зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан сургууль	21
Хүснэгт 3-1: Загвар сургуулиуд	30
Хүснэгт 3-2: Эхний жилийн сургалтын багц материалын бүтэц.....	32
Хүснэгт 3-3: Нийслэлийн СХД дэх сургалт.....	33
Хүснэгт 3-4: Булган аймаг дахь сургалт	34
Хүснэгт 3-5: Завхан аймаг дахь сургалт	34
Хүснэгт 3-6: Бүх аймаг, дүүрэгт үзүүлсэн технологийн дэмжлэг	36
Хүснэгт 3-7: Хичээлийн судалгааны анхны мониторингийн товч танилцуулга /2011/	37
Хүснэгт 3-8: Сургалтын багц материалын бүтэц	39
Хүснэгт 3-9: Сургалтын товч танилцуулга /2011 он/	41
Хүснэгт 3-10: Бүх аймаг, дүүрэгт зориулсан технологийн дэмжлэг /2011/	42

Хүснэгт 3-11: Хоёр дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн товч танилцуулга /2011/	44
Хүснэгт 3-12: Хоёр дахь жилийн загвар сургуулийн сургалтын хэрэгжилт /2011/.....	45
Хүснэгт 3-13: Сургалтын товч танилцуулга /2012/	50
Хүснэгт 3-14: Загвар бус аймаг, дүүрэгт үзүүлсэн технологийн дэмжлэг /2012/	51
Хүснэгт 3-15: Загвар бус аймаг, дүүрэгт үзүүлсэн технологийн дэмжлэг /2012/	53
Хүснэгт 3-16: Гурав дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн товч танилцуулга /2012/	54
Хүснэгт 3-17: Дөрөв дэх удаагийн хичээлийн судалгааны мониторингийн товч танилцуулга /2012/	54
Хүснэгт 3-19: Булган аймаг дахь загвар бус сургуульд зориулсан сургалт /2012/	56
Хүснэгт 3-20: Завхан аймаг дахь загвар бус сургуульд зориулсан сургалт /2012/	56
Хүснэгт 3-21: Самбар олгосон сургууль болон олгосон тоо ширхэг	58
Хүснэгт 3-22: Гурав дахь жилийн хоёр дахь удаагийн Япон дахь сургалтын танилцуулга	60
Хүснэгт 3-23: Бага ангийн Математикийн хэлэлцүүлэг сургалтын товч танилцуулга	64
Хүснэгт 3-24: Багш сонин	65
Хүснэгт 3-25: Тав дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн товч танилцуулга /2013/	65
Хүснэгт 4-1: Зөвлөмжийн агуулга ба төслийн үйл ажиллагаа	69
Хүснэгт 4-2: Төслийн хүрэх үр дүнгийн хураангуйд оруулах засвар	70
Хүснэгт 4-3: Үндсэн судалгаа	73
Хүснэгт 4-4: Төслийн мэдээлэл	76
Хүснэгт 4-5: ЖАЙКА-гийн сайн дурын гишүүд хоорондын уялдаа	77
Хүснэгт 6-1: Мэргэжилтний жагсаалт	91
Хүснэгт 6-2: Эхний жилийн Япон дахь сургалтын оролцогчид	92
Хүснэгт 6-3: Хоёр дахь жилийн Япон дахь сургалтын оролцогчид	92
Хүснэгт 6-4: Гурав дахь жилийн эхний удаагийн Япон дахь сургалтын оролцогчид	93
Хүснэгт 6-5: Гурав дахь жилийн хоёр дахь удаагийн Япон дахь сургалтын оролцогчид	94
Хүснэгт 6-6: Гурав дахь жилийн гурав дахь удаагийн Япон дахь сургалтын оролцогчид	94
Хүснэгт 6-7: Индонезитэй туршлага солилцох хөтөлбөрийн оролцогчид	95
Хүснэгт 6-8: Эцсийн бүтээгдэхүүний жагсаалт	95
Хүснэгт 6-9: Үйл ажиллагааны зардал	97

БҮЛЭГ I ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ БА ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн үндэслэл

Монгол Улс 1990 оноос хойш социализмын үеийн боловсролын үзэл баримтлал, агуулга, тогтолцоогоо шинэчлэн, олон улсын стандартад нийцсэн боловсрол тогтолцоог нэвтрүүлэн, зах зээлийн эдийн засаг, ардчилсан тогтолцоот нийгмийг байгуулах шинэ боловсон хүчнийг бэлтгэхээр зорьж ирсэн. Боловсролын салбарын шинэчлэлээр, 2005 оны 9 сараас боловсролын шинэ стандартыг нэвтрүүлэн, ерөнхий боловсролыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж эхэлсэн. Үүнтэй уялдан, сургуульд элсэх насыг 8 наснаас 6 нас болгон өөрчилсний зэрэгцээ Төсөлт ажил зэрэг шинэ хичээлийг нэвтрүүлжээ. Энэхүү боловсролын стандартад, боловсролын зорилгыг “Мэдлэг чадвар, ёс суртахуун, бие бялдараа хөгжүүлэн, ёс зүйг эрхэмлэж, зах зээлийн эдийн засаг, ардчилсан тогтолцоот нийгэмд өөрийн хүчээр ажиллаж амьдарч суралцах чадвартай хүнийг хүмүүжүүлэх” гэж заан, багшийн зүгээс шууд мэдлэг дамжуулдаг хичээлээс хүүхдийн асуудал шийдвэрлэх чадварыг дээшлүүлдэг хүүхэд төвтэй хичээл, хүүхдийн хөгжлийн үе шатанд тохирсон хичээл болгон өөрчлөх, өөрөөр хэлбэл “Суралцахууд суурилсан багшлах арга зүй” рүү шилжих шаардлага тулгарсан.

Гэвч, их Сургуулийн багш голлон боловсруулсан боловсролын шинэ стандарт нь агуулгын хувьд хэт академик, багш нарт ойлгомжгүй бөгөөд уламжлалт цээжлүүлэх арга барил бүхий хичээлд бэлтгэгдэж ирсэн багш нарын ихэнх нь “Суралцахууд суурилсан багшлах арга зүй”-г хэрэгжүүлэх тодорхой аргачлалыг мэдэхгүй, хичээл заах арга зүйгээ шинэчлэхэд хүндрэлтэй тулгарах болсон зэрэг асуудлууд үүссэн юм.

Энэ үндэслэлээр Монгол Улс Засгийн газар нь Япон Улсад хандан, багшлахуйн арга зүйг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргасан. Уг хүсэлтийн дагуу Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (Цаашид, ЖАЙКА гэх) нь 2006-2009 онд “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил төсөл (Цаашид, төслийн эхний шат гэх)”-ийг хэрэгжүүлсэн. Төслийн эхний шатанд БСШУЯ (Одоогийн БШУЯ, Цаашид, шинэ хуучин засгийн газраас үл хамааран БСШУЯ гэж тэмдэглэх), Боловсролын хүрээлэн, МУИС, МУБИС-ийгхамтран ажиллагч Байгууллагаар сонгон, 4 судлагдахууны 8 хичээлийн (Физик, Хими, Хүн орчин, Хүн байгаль, Математик /бага/, Математик /суурь/, Мэдээлэл зүй, Төсөлт ажил) арга зүй, зөвлөмж боловсруулсан. Мөн, Улаанбаатар хот болон Дорнод, Сэлэнгэ аймагт тус бүр 3 сургууль, нийт 9 загвар сургууль сонгон, боловсруулж асан арга зүй, зөвлөмжөө туршиж, гарсан үр дүндээ үндэслэн сайжруулсан юм. Түүнчлэн, зөвлөмж боловсруулах ажлын явцыг тэмдэглэсэн “Зөвлөмж боловсруулах гарын авлага”, хичээл болон арга зүйгээ сайжруулах арга хэрэгсэл болгон “Хичээлд мониторинг хийх гарын авлага”, мөн 8 судлагдахуунаар дүрст хичээлийн материал ч боловсруулсан.

Боловсруулсан зөвлөмжүүдийг БСШУЯ өндөр үнэлсэн бөгөөд 2009 оны 12 сард Японы Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн эргэлтийн сангийн хөрөнгөөр

зөвлөмжүүдийг хэвлэн, үндэсний хэмжээнд тараасан.

Гэвч, зөвлөмж тараах төдийхнөөр “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй”-г багш нар өөрдсийн хичээлд ашиглах хүндрэлтэй байсан ба уг арга зүйг түгээн дэлгэрүүлэхийн тулд сургалт явуулах тогтолцоо бий болгох шаардлагатай болсон.


Энэ мэт үндэслэлээр Монгол Улсын Засгийн газраас 2008 оны 8 сард төслийн эхний шаг үргэлжлэл болох дор нэр дурьдах төслийг хэрэгжүүлэх хүсэлт гаргасан. ЖАЙКА нь 2009 оны 10 сард нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах судалгаа хийн, 12 сард протоколд гарын үсэг зурснаар 2010 оны 3 сараас “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг (Цаашид, төслийн хоёр дахь шат гэх) эхлүүлсэн. 2010 оны 4 сард Япон мэргэжилтэн Улаанбаатар хотод томилогдон ирж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

1.2 Төслийн танилцуулга

Энэхүү төслөөр бүх аймаг, дүүргийн БСГ/БХ (Одоогийн БГ/БХ. Цаашид, шинэ хуучин ялгалгүй БСГ гэх) урьдын багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоог ашиглан нийт багш нарт багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэхийг зорьсон. Төслийн хураангуйг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1-1: Төслийн хураангуй

Төслийн хураангуй	
Хэтийн зорилго	Бага болон дунд сургуулийн сурагчдын сурлагын амжилт дээшилсэн байна.
Эрхэм зорилго	Загвар болон бусад аймаг дүүргийн багш нар суралцахуйд суурилсан багшлах арга зүйг туршин хэрэгжүүлнэ.
Төслийн зорилго	Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлнэ.
Үр дүн 1	Бүх аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх багийн ур чадвар дээшилнэ.
Үр дүн 2	Загвар аймаг, дүүрэгт хичээлийн судалгааны загвар бий болно.
Үр дүн 3	Загвар аймаг, дүүргийн багш нарын суралцахуйд суурилсан багшлах ур чадвар дээшилнэ.
Үр дүн 4	Багш бэлтгэх шатанд суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх орчин боловсронгуй болно.



Зураг 1-1: Төслийн үйл ажиллагааны бүдүүвч

Төслийн хугацаа:

2010 оны 3 сар - 2013 оны 8 сар (3 жил 6 сар). Анх 2013 оны 2 сар хүртэл үйл ажиллагаагаа төлөвлөсөн байсан ч, 2012 оны 9 сард БМДИ байгуулагдан, гол хамтран ажиллагч байгууллага болсон зэргээр Монгол талын тогтолцоонд өөрчлөлт гарч, төслийн хугацааг 2013 оны 8 сар хүртэл сунгасан.

Монголын талын холбогдох хүмүүс:

2009 оны 12 сарын 8-ны өдрийн хурлын протоколын (R/D) дагуу дараах байдлаар төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой Монголын талын тогтолцоог бүрдүүлсэн.

- Төслийн удирдагч: БСШУЯ-ны Дэд сайд
- Төслийн менежер: БСШУЯ-ны Ерөнхий боловсролын газрын дарга, 2012 оны 9 сараас Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга
- Төслийн бодлогын зохицуулагч: БСШУЯ-ны Ерөнхий боловсролын газрын ахлах мэргэжилтэн, 2012 оны 9 сараас БСШУЯ-ны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын Суурь, бүрэн дунд боловсролын хэлтсийн дарга
- Төслийн санхүүгийн зохицуулагч: БСШУЯ-ны Санхүүгийн газрын мэргэжилтэн. Монголын талын төсөл хэрэгжүүлэх төсвийг тооцох, хүсэлт гаргах, гүйцэтгэх, тайлан зэргийг төслийн хэрэгжилтийн зохицуулагч хариуцаж ажилласан.
- Багийн зохицуулагч: Боловсролын хүрээлэнгийн ахлах мэргэжилтэн болон судлаач.
- Төслийн хэрэгжилтийн зохицуулагч: 2010 оны 4-8 сарын эхэн хүртэл Э.Болормаа,

мөн оны 9 сарын сүүлээс 2011 оны 2 сар хүртэл Ц.Лувсандорж, 2011 оны 6 сараас Н.Оюунцэцэг нар хариуцаж ажилласан.

- Үндэсний баг (Үндсэн баг): Дээрх төслийн удирдагч, менежер, зохицуулагчаар МУИС, МУБИС-ийн захирал декануудаас гадна 16 гишүүнтэй “Үндэсний баг” бүрдүүлсэн. Гэвч, үндэсний баг нь үйл ажиллагаа явуулаагүй ба сургалтын багц материал боловсруулах, сургалтад сургагч багшаар ажиллах зэргийг дараах мэргэжлийн багийн гишүүд гүйцэтгэсэн.

Төслийн эхний шатны туршлага бүхий МУИС, МУБИС болон ЕБС-ийн багш нараар “Мэргэжлийн баг”-ийг (2010 оны 12 сарын 15-ны өдрийн БСШУ-ны Сайдын 575 тоот тушаал, 2011 оны 11 сарын 7-ны өдрийн 428 тоот тушаал, Хавсралт 1) бүрдүүлсэн. Төслийн зорилтот 8 судлагдахууны баг болон удирдлагын сургалт хариуцах баг, нийт 9 багаас бүрдэн, сургалтын багц материал боловсруулах болон сургалтад сургагч багшаар ажилласан.

Төслийн баг:

Япон болон Монгол мэргэжилтэн, Монгол орчуулагч, ажилтан, сургалтын туслах ажилтан, жолооч зэргээс бүрдсэн.

1.3 Монголын боловсролын шинэчлэлийн төлөв байдал

Монгол Улс нь 1990 онд ардчилалд шилжсэнээсээ хойш боловсролын шинэчлэлийг эрчимтэй хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас олон тооны бодлого болон олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн. Тус төслийн хугацаанд боловсролын шинэчлэлтэй холбоотойгоор хэд хэдэн томоохон өөрчлөлтүүд гарсан. Түүний дотроос дараах 3 өөрчлөлт тус төсөлд томоохон нөлөө үзүүлжээ. Эхнийх нь 2011 оны 4 сард эхлүүлсэн Бага, дунд боловсролын стандарт болон хөтөлбөрийн шинэчлэл юм. Хоёр дахь нь 2012 оны 5 сард хийгдсэн Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, гурав дахь нь 2012 оны 8 сард шинэчлэлийн засгийн газар буй болсонтой уялдан гарсан боловсролын цоо шинэ шинэчлэлийн эхлэл юм.

(1) Бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийн шинэчлэл

Монгол Улс 5 жил тутамд боловсролын стандартаа шинэчилдэг. 2005 онд боловсруулагдсан боловсролын стандартыг шинэчлэх цаг хугацаатай золгосон 2011 оны 4 сарын 13-нд, Монгол Улс Засгийн газар Кембрижийн их сургуулийн Олон улсын үнэлгээний төвтэй “Бага дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх тухай хамтын ажиллагааны санамж бичиг” солилцон, бага дунд боловсролын стандарт, хөтөлбөрийн шинэчлэлийг эхлүүлсэн.

Кембрижийн олон улсын хөтөлбөр гэдэг нь 1988 онд гараагаа эхлүүлсэн Кембрижийн их сургуулийн ерөнхий боловсролын жишиг стандарт юм. Дараа нь

Сингапур, Австри, Шинэ Зеланд зэрэг 160 гаруй орны ойролцоогоор 9000 орчим сургуулиудад нэвтрүүлжээ. Монгол Улсын Засгийн газар нь олон улсын жишигт нийцсэн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор Кембрижийн олон улсын хөтөлбөрийн дидактик агуулга болон үнэлгээний стандартыг Монголын хөрсөнд нийцүүлэн хэрэгжүүлэх шийдвэр гаргасан. Ингээд, Англи хэл дээр сургалт явуулах 3 лаборатори сургуулийг шинээр байгуулснаас гадна, Улаанбаатар хотод 10 сургууль, бүх аймагт тус бүр 1 сургууль, нийт 31 сургуулийг лаборатори сургууль⁸ болгон сонгож, шинэчилсэн хөтөлбөр⁹-ийг туршин хэрэгжүүлж байна.

Уг хөтөлбөрийн зорилго нь хүүхдүүдэд асуудал шийдвэрлэх чадвар эзэмшүүлэх явдал бөгөөд тус төслийн бодлого чиглэлтэй зөрчилдөх зүйлгүй. Кембрижийн олон улсын хөтөлбөр нь “Дидактик агуулга, үнэлгээний стандарт”, тус төсөл нь “Багшлахуйн арга зүй” гэсэн байдлаар үүрэг функцийн ялгаатай байсан.

2012 оны 8 сард шинэчлэлийн засгийн газар байгуулагдсны дараа, 31 лаборатори сургуульд нийслэлээс 4 сургууль, сумдаас 3 сургууль нэмэгдсэн бөгөөд нийт 40 сургууль¹⁰ дээр хөтөлбөр турших ажил явагдаж байна.

(2) Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт

2012 оны 5 сарын 9-нд Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөс дараах өөрчлөлтүүд урган гарчээ.

Хүснэгт 1-2: Хуулийн нэмэлттэй уялдсан өөрчлөлтүүд

Боловсролын тухай хуулийн гол нэмэлт өөрчлөлт	Бага дунд боловсролын тухай хуулийн гол нэмэлт өөрчлөлт
<ul style="list-style-type: none"> Кембрижийн олон улсын хөтөлбөрийг нэвтрүүлэхэд чиглэсэн орчин бүрдүүлэх (Олон улсын сургууль, лаборатори сургуулийн тодорхойлолт болон шинээр байгуулахтай холбоотой зөвшөөрөл г.м) Сургалт, судалгааны үүрэг функц бүхий БМДИ-г байгуулах Сурагчдын сурлагын амжилттай холбоотой мониторинг, үнэлгээ, судалгаа, сургалт, суралцах чадвар шалгалт явуулах үнэлгээний төвийг байгуулах Багшийн үнэлгээний чиглэлийг батлах БГ-т сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч томилох эрх олгох 	<ul style="list-style-type: none"> 5, 4, 3 жилийн тогтолцоог нэвтрүүлэх Кембрижийн олон улсын хөтөлбөрийг нэвтрүүлэхэд чиглэсэн орчин бүрдүүлэх (Зохион байгуулалт, багш ажилтан, дүрэм журам зэргийг багтах)

⁸ Төслийн эхний шатны загвар сургууль болох Нийслэлийн 45-р сургууль, Сэлэнгэ аймгийн 4-р сургууль, Дорнод аймгийн Хан-Уул ЦС болон төслийн хоёр дахь шатны загвар сургууль болох Завхан аймгийн Чандмань-Эрдэнэ ЦС багтсан.

⁹ 2013-2014 оны хичээлийн жил хүртэлх хугацаанд 5 судлагдахууны 1-10 анги хүртэлх хөтөлбөрийг батлахаар төлөвлөсөн.

¹⁰ Төслийн хоёр дахь шатны загвар сургууль болох Нийслэлийн 12-р сургууль, Булган аймгийн Хишиг-Өндөр сумын сургууль, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 1-р сургууль нэмэгдсэн.

<ul style="list-style-type: none"> • Улсын төсвөөр 5 жил тутамд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах • Багшийн цалин хөлс (Урамшуулал, томилолт, тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал) • Үдийн хоолны журам батлах, хүнсний аюулгүй байдлыг хангах • Сурагчийн дүрэмт хувцасны үндсэн загварыг батлах • Сургуулийн эзэмшлийн талбайгаар хангах 	
--	--

Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2012 оны 9 сард БМДИ байгуулагдсан¹¹ явдал нь тус төслийн “Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилтыг улам баталгаажуулахад тус дөхөм үзүүлсэн. БМДИ байгуулагдсанаар тус төслийн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх Сайд тай болсон юм. Өнөөг хүртэл энэхүү төсөл нь Боловсролын хүрээлэн, МУИС, МУБИС болон БСГ/БХ-т харъяалагдах судлаач, багш, арга зүйч, мэргэжилтнүүдээс бүрдсэн мэргэжлийн багтай хамтран үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ирсэн. Гэвч, мэргэжлийн багийн гишүүд харъяалагдах байгууллагадаа тус тусын ажилтай бөгөөд төслийн үйл ажиллагаанд оролцох болон үндсэн ажлаа эрхлэх цагийн зохицуулалтыг хийхэд хүндрэл гарч байсан. Мөн, хувь хүмүүс сайн дураараа цуглан ажиллаж буй байдалтай байсан тул, төслийн үр дүн хувь хүмүүст өгөөжөө өгсөн боловч байгууллагад нь бараг үр өгөөжгүй байсан зэрэг асуудал ч тулгарч байлаа.

БМДИ байгуулагдсан цагаасаа тус төсөлтэй хамтран ажиллахад анхаарал хандуулж, арга зүйч нараа тус төслөөс хэрэгжүүлж ирсэн суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалт болон Япон дахь сургалт, хичээлийн судалгааны мониторингт оролцуулах, семинар болон “Хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал” зэрэг арга хэмжээг хамтран зохион байгуулж ирсэн. Мөн, мэргэжлийн багийн 3 гишүүн БМДИ-д арга зүйчээр ажиллах болж, төслийн багтай нягт уялдаатай ажиллаж байна.

БМДИ-ээс зохион байгуулдаг үндсэн сургалт¹² болон үндэсний түвшний бусад сургалтад ч суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгаагаар дамжуулан багшлахуйн арга зүйн шинэчлэл хэрэгжих болсон. Жишээ нь, 7 хоногийн хугацаатай хэрэгждэг байсан тав дахь жилийн сургалтыг 10 хоног болгон өөрчилж, үүний 3 хоногийг хичээлийн судалгаанд зориулах болсон.

¹¹ Социализмын үед багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт явуулдаг ижил төрлийн байгууллага байсан боловч, ардчилалын дараа татан буугдсан.

¹² Өмнөх Засгийн газрын үед эхний жилийн, 5 болон 10 дахь жилийн үндсэн сургалтуудыг зохион байгуулахаар тогтсон ч, төсөвтэй холбоотойгоор зохион байгуулахад тодорхой хүндрэлүүд учирч байжээ. Ялангуяа, эхний жилийн сургалтыг нийслэлд зохион байгуулж чадаагүй бөгөөд үүнийг орон нутгийн БСГ-уудад даалгаж байв. Шинэ Засгийн газар байгуулагдсаны дараа буюу 2013 оны 8 сарын 9-ний өдрийн БШУ-ны Сайдын А/287 тоот тушаалаар эхний жилийн болон 5, 10 дахь жилийн үндсэн сургалтуудыг нийслэлд зохион байгуулахаар тогтоож өгсөн. Түүнчлэн 2, 3, 4 дэх жилийн сургалтуудыг орон нутгийн БГ-ууд зохион байгуулахаар шийдвэрлэжээ.

Энэ мэтчилэн БМДИ байгуулагдсан явдал, төсөл сунгагдсан хугацааны хамтарсан үйл ажиллагаагаар дамжуулан технологи шилжүүлсэн явдал нь багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэн, “Загвар аймаг болон бусад аймагт суралцахуйд суурилсан багшлах арга зүйг хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилгыг биелүүлэх замыг гэрэлтүүлж өгсөн явдал болсон юм.

(3) Цоо шинэ боловсролын шинэчлэлийн эхлэл

2012 оны 8 сард шинэчлэлийн засгийн газар байгуулагдан, БСШУЯ нь Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ) болон Соёл, спорт, аялал жуулчлалын яам (ССАЖЯ) болж өөрчлөгдсөн. Шинэчлэлийн засгийн газар нь “Зөв Монгол хүүхдийг хүмүүжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд боловсролын чанарыг сайжруулахаар ажиллаж байна. “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” урианд (1) Стандарт¹³, хөтөлбөр, (2) Сурах бичиг, сургуулийн орчин, (3) Үнэлгээ, (4) Багш бэлтгэх, (5) Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, (6) Боловсролын 6 салбар дахь бага, дунд боловсролын шинэчлэл явагдаж байна¹⁴.

Тус төслийн хүрээнд танилцуулсан “Хичээлийн судалгаа” нь, ажлын байран дээр багш нарын ур чадварыг дээшлүүлэх явдлыг дэмжих, хүүхдийн өөрчлөлтийг тодорхойлох аргуудын нэг гэдэг утгаараа Монголын боловсрол бодлоготой нийцэж байна гэсэн үнэлгээ авсан. Төсөл сунгагдсан хугацаанд зохион байгуулсан Япон дахь сургалтад дээрх шинэчлэлийг гардан хэрэгжүүлж буй БШУЯ болон Боловсролын хүрээлэнгийн холбогдох хүмүүсийг хамруулсан бөгөөд шинэчлэлд Японы туршлагаас санаа авч байна.

Гэвч, шинэчлэлийн засгийн газар дараагийн парламентийн сонгууль хүртэлх 4 жилийн хугацаанд үр дүн гаргах зорилгоор янз бүрийн шинэчлэлийн арга хэмжээг дараалан зохион байгуулж байгаагийн улмаас сургуулиудын хувьд будилж төөрөлдөх явдал ч цөөнгүй гарч байна.

¹³ Стандартаа шинэчлэх үү, хөтөлбөрийг шинэчлээд зогсох уу гэдэг дээр санал зөрөлдөөнтэй байгаа.

¹⁴ Үүнтэй холбоотойгоор БШУЯ-наас “Авъяас”, “Сурах бичиг”, “Багшийн ур чадварыг дээшлүүлэх” гэсэн 3 хөтөлбөр хэрэгжүүлж байна.

БҮЛЭГ II ТӨСЛИЙН БИЕЛЭЛТ

“Бага болон дунд сургуулийн сурагчдын сурлагын амжилт дээшилсэн байна” гэсэн төслийн хэтийн зорилгын биелэлтийг тандахын хамт эрхэм зорилго, төслийн зорилго, үр дүн бүрийн биелэлтийг ч судалж үзсэн.

Төсөл хэрэгжүүлэх явцад эрхэм зорилго биелэгдэж эхэлсэн талаар онцлон тэмдэглүүштэй зүйл нь 2013 оны 8 сарын байдлаар үндэсний хэмжээний 752 сургуулийн 487 сургууль (65%) 2012-2013 оны хичээлийн жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан, 2012-2013 оны хичээлийн жилд Улаанбаатар хот болон 21 аймгийн 16-д нь хичээлийн судалгааны сургалт зохион байгуулагдсан явдал байв.

Төслийн зорилго болон үр дүн нь төслийн үндсэн хугацаанд (2010 оны 3 сар - 2012 оны 2 сар) их төлөв биелэгдсэн. Харин, төслийг хагас жил сунгаснаар “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх явдал (Төслийн зорилго)” хэвшин, эрхэм зорилго биелэх төлөв ажиглагдах болсон.

2.1 Төслийн зорилго: “Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлнэ”

Төслийн зорилгын биелэлтийг, загвар сургуулиудын хичээлийн чанар сайжирч байгаа эсэх, загвар аймаг, дүүргийн сургуулиудын 70-аас дээш хувь нь жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа хийсэн эсэх, бүх аймаг, дүүрэг хичээлийн судалгаа хийх сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан эсэх, суралцахуйд суурилсан багшлах арга зүй түгээн дэлгэрүүлэх тогтолцоог буй болгоход БСШУЯ-наас тодорхой амлалт өгсөн эсэх зэргээр тандсан.

Шалгуур 1: Загвар сургуулиудын 8 судлагдахууны багшлахуйн арга зүй сайжирснаар хичээлийн чанар дээшилсэн байх.

Дөрөв дэх удаагийн хичээлийн судалгааны мониторингоор (2012 оны 9-10 сар), хичээлийн чанарыг 2011, 2012 онуудаар харьцуулалт хийсэн. Мөн, тав дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн (2013 оны 3-4 сар) үеэр ч хичээлийн чанарыг судалж үзсэн. Хичээлийн чанарын талаар Хавсралт 4-т үзүүлэв.

Хичээлийн мониторингийг зохион байгуулахдаа, төслийн баг хичээлийн чанарыг хэмжих үзүүлэлтээр (1) Хичээлийн хэрэглэгдэхүүн тохиромжтой байсан эсэх, (2) Хичээлийн бүтэц тохиромжтой байсан эсэх, (3) Асуулт тохиромжтой байсан эсэх, (4) Багшийн чиглүүлэг, удирдамж тохиромжтой байсан эсэх, (5) Хүүхдүүдийн хандлага зэргийг танилцуусан. Эдгээр үзүүлэлтийн дагуу, мэргэжлийн баг загвар сургуулиудын судалгаат хичээлийн чанарыг судалсан.

Судлагдахуун бүх дээр хичээлийн чанар дээшилсэн нь тодорхой болсон тул, энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэн гэж болно. Гэхдээ, багшлахуйн арга зүйн шинэчлэлд

эцсийн цэг гэж байхгүй бөгөөд тасралтгүй үйл ажиллагаа явуулах шаардлагатай болдог. Цаашдын тулгамдсан асуудал болох тав дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн үед ажиглагдсан зүйлүүдийг доор дурьдав.

- Хэд хэдэн судалгаат хичээл дээр оньсого таавар зэрэг хичээлийн гол сэдэвтэй холбоогүй сэдэлжүүлэлт хийгдэж байсан. Хичээлийн сэдэлжүүлэлт нь хүүхдүүдэд хичээлийн агуулгыг эргэцүүлэн бодуулахуйц байх ёстой.
- Сорил туршилттай хичээл дээр хүүхдүүд зөвхөн зааврын дагуу л ажиллахаас өөр зүйлгүй байна. Хамгийн чухал нь, хүүхдүүд өөрсдөө юуны тулд, юуг хэрхэн судлах гээд байгаагаа ойлгох явдал юм. Хүүхдүүд таамаглал дэвшүүлэн, туршилтынхаа үр дүнг судлах хангалттай цаг гаргаж өгөх хэрэгтэй.
- Хүүхдүүдийн хэдийнэ сайн мэддэг болчихсон зүйлийг нь л заагаад байхаас бус шинэ мэдлэг бүтээлгэдэг хичээлүүд ч ажиглагдсан. Багш өдөр тутамд хүүхдүүдийнхээ талаар судлан, ээлжит хичээлийн хөтөлбөрт “Ямар байсан хүүхэд (Одоогийн төлөв)”-ийг “Ямар хүүхэд болгох вэ?” гэдгээ тодорхой тусгах нь зүйтэй.
- Хүүхдүүдийн байдлыг зүгээр л нэг ажигласнаар, хэрхэн сурч буйг нь ойлгож мэдэх аргагүй. Хүүхдүүдээр сурсан зүйлийнх нь талаарх сэтгэгдэл (Ойлгож мэдсэн зүйл, эргэлзээтэй санагдсан зүйл, бусад хүүхдүүдийнхтэй өөрийнх нь бодлыг харьцуулуулах зэрэг) бичүүлж болох юм. Хүүхэд нэг бүрийн талаар анзаарсан зүйлээ суудлын хуваарьт тэмдэглэх арга ч үр дүнтэй байдаг.

Шалгуур 2: Загвар аймаг, дүүргийн сургуулиудын 70-аас доошгүй хувь нь жилд хоёр удаа хичээлийн судалгаа зохион байгуулах.

2011-2012 онд СХД-ийн 13 сургуулийн 13, Булган аймгийн 23 сургуулийн 18, Завхан аймгийн 29 сургуулийн 29 нь хоёроос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулжээ. Мөн, 2012-2013 онд Булган аймгийн 23 сургуулийн 16, Завхан аймгийн 29 сургуулийн 29 нь хоёроос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулжээ.

Хүснэгт 2-1: Загвар аймаг, дүүрэгт хоёроос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан сургуулийн тоо

Загвар аймаг, дүүрэг	Сургуулийн тоо	2011-2012 оны хичээлийн жил 2012 оны 9 сарын байдлаар		2012-2013 оны хичээлийн жил 2013 оны 8 сарын байдлаар		Тайлбар
СХД	13	13	100%	13	13	
Булган аймаг	23	18	78%	16	70%	Хичээлийн судалгаа зохион байгуулаагүй сургуулиудын 3 нь багийн (Сум доторх засаг захиргааны нэгж) сургууль, 2 нь сумын жижиг сургууль бөгөөд хичээлийн судалгаа зохион байгуулах боломжгүй. Ийм сургуулийн багш нар зэргэлдээ сургуулийн үйл ажиллагаанд оролцдог.

Завхан аймаг	29	29	100%	29	100%	
--------------	----	----	------	----	------	--

Дээр тодорхой болсончлон, энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэн гэж болно.

Загвар аймаг, дүүргийн загвар бус сургуулиуд хичээлийн судалгаа хийх болсон үндэслэлд, БГ-ын чиглүүлгийг дурьдах мэдээжийн хэрэг бөгөө эхний жилээс бүх загвар сургуулиуд зэргэлдээ сургуулийн багш нараа урих зэргээр хичээлийн судалгааг түгээн дэлгэрүүлэх хүчин чармайл гаргасны үр дүн гэж үзэж байна.

Шалгуур 3: Бүх аймаг, дүүргийн БГ/БХ-үүд багшлах арга зүйн сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан байх.

21 аймаг болон нийслэлийн 9 дүүрэг бүгд хичээлийн судалгаа зохион байгуулах сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан.

2011 оны 11 сарын бүх аймаг, дүүрэгт зориулсан суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалтад Архангай аймаг болон нийслэлийн Багахангай дүүргээс (дүүргийн хэмжээнд ганцхан сургуультай) бусад буюу 20 аймаг, 8 дүүргийн “Аймаг, дүүргийн баг” сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан. Архангай аймгийн багт зориулан 2012 оны 3 сард тусгайлан зохион байгуулсан суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалтын үед, сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан. Багахангай дүүргийн баг нь сургалтын дараа сургалт зохион байгуулах төлөвлөгөөгөө боловсруулсан.

2012 оны 11 сарын бүх аймаг, дүүрэгт зориулсан суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалтаар хичээлийн судалгааны сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан.

Шалгуур 4: Суралцахуйд суурилсан багшлах арга зүй түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бий болгохын тулд БШУЯ нь бодлого, санхүү, хүний нөөцийн дэмжлэг үзүүлэх хүчин чармайлт гаргасан байх (Багшлахуйн арга зүй түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой БШУ-ны Сайдын тушаал гаргах).

БСШУЯ нь тус төсөлтэй холбоотой олон тооны сайдын тушаал, газрын даргын тушаал гаргасан (Хавсралт 6-г үзнэ үү). Үүнээс, суралцахуйд суурилсан багшлах арга зүй түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бий болгоход шууд хувь нэмэр оруулсан тушаалуудыг доор танилцуулъя.

- 2011 оны 9 сарын 9-ний БСШУЯ-ны Ерөнхий боловсролын газрын даргын 3/4973 тоот тушаал (Мэргэжлийн багийн гишүүдийн үндсэн ажлын ачааллыг хөнгөвчлөх тухай)
- 2012 оны 1 сарын 18-ны БСШУ-ны Сайдын 24 тоот тушаал (Төслийн холбогдох

байгууллагуудад багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах тухай)

- 2012 оны 1 сарын 31-ний БСШУЯ-ны Ерөнхий боловсролын газрын даргын 3/427 тоот тушаал (Багш бэлтгэдэг их дээд сургуулиудад багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах тухай)
- 2012 оны 9 сарын 10-ны БСШУ-ны Сайдын А-13 тоот тушаал (Загвар бус аймагт сургалт зохион байгуулах тухай)

Дээрхээс гадна мэргэжлийн баг дотор байгуулагдсан “Удирдлагын баг” нь төслийн хоёр дахь шатыг хэрэгжүүлж эхлэхээс өмнөх Засгийн газрын тогтоол, БШУ-ны Сайдын тушаал, хамтарсан тушаалд дурьдсан багшийн ажлын байрны тодорхойлолт, цар хүрээ, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхтэй холбоо бүхий зүйл заалтыг хичээлийн судалгаанд суурилсан багшлахуйн арга зүйг шинэчлэлд тус дөхөмтэй болохыг тодорхойлсон. Ингээд, бүх сургалтын үед “Хичээлийн судалгаа зохион байгуулж, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх нь багшийн үүрэг юм” гэж тайлбарлажээ.

Мөн, төсөл хэрэгжих хугацаанд Монгол Улсын Засгийн газар 2010 оны 239 тоот тогтоол (Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн хөлсний тогтолцоо, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ), 2010 оны 148 тоот тогтоолыг (Боловсролын салбарт ажиллагсад нэмэгдэл хөлс олгох хувь хэмжээ) гарган, багш зэрэг төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн нь төслийн хэрэгжилтэд сайнаар нөлөөлсөн.

Улмаар, 2013 оны 8 сарын дундуур багш сурагчдын үнэлгээний 4 журмыг (Багшийн үнэлгээ, багшлах эрх, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, сурагчдын суралцах чадварын үнэлгээ) батлах төлөвтэй байна. Эдгээр журмаас үзвэл, сурагчид (1) Сахилга бат, (2) Мэдлэг, технологи, (3) Авьяас (Сонирхлынхоо дагуу ур чадвараа хөгжүүлэх) (4) Суралцахуйн сэтгэл ханамж, (5) Өдөр тумын амьдралын 5 хандлагыг үнэлэх юм байна. Хариуцсан багш нь бүх хүүхдийн хүрэх ёстой зорилтыг судлан, түүнд нь нийцсэн өөрийн үнэлгээ хийлгэнэ. Сургуулийн захирал, эцэг эхчүүд үнэлгээний хороо байгуулан, багшийн өөрийн үнэлгээний үр дүн болон хүүхдүүдийн үнэлгээ үр дүнг тодорхойлон, зорилтоо 70-аас дээш хувиар биелүүлсэн багшид урамшуулал өгөх юм. Мөн, багшийн ажлын байрны тодорхойлолтод хичээлийн судалгааг тусгах төлөвтэй байна. Эдгээр журмыг урьд өмнөхтэй харьцуулахад суралцахуйд суурилсан гэсэн санаа нь тодорхой болсноос үзэхэд, суралцахуйд суурилсан багшлах арга зүй түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бий болгоход хувь нэмэр оруулсан гэж болно.

Энэ мэтчилэн, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бий болгохын тулд БШУЯ нь бодлого, санхүү, хүний нөөцийн дэмжлэг үзүүлэх хүчин чармайлт гаргаж ирсэн. Үүнтэй холбогдуулан уг шалгуур үзүүлэлтийг биелсэн гэж болно. Гэвч, шинээр батлагдах гэж буй багшийг үнэлэх журамд субъектив шалгуур ч цөөнгүй байгаа бөгөөд сургууль дээр хэрэгжүүлэхэд алдаа эндүүрэл гарах магадлалтай тул илүү нарийвлах шаардлагатай юм.

2.2 Төслийн хүрэх үр дүн

Дараа нь төслийн хүрэх үр дүн бүрийн биелэлтийг судалсан.

(1) Үр дүн 1: Бүх аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх багийн үр чадвар дээшилнэ.

Үр дүн 1-ийн тухайд, 2011-2012 болон 2012-2013 оны хичээлийн жилийн 11 сард зохион байгуулагдсан бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтын үр дүнг, сургалтын талаарх оролцогчдын сэтгэл ханамж болон ойлголт, оролцогчдын үйл ажиллагаан дахь өөрчлөлт, бүх аймаг, дүүргийн оролцогчдын тоог судалсан.

Шалгуур 1: Сургалтад оролцогчдын ойлголт, сэтгэл ханамжийн үнэлгээ өссөн байх.

1) Сэтгэл ханамж

Бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтын үеэр (1) Сургалтын зорилго болон агуулга нийцэж буй эсэх, (2) Сургагч багшийн ярианы агуулга ойлгомжтой байсан эсэх, (3) Цагийг үр дүнтэй ашигласан эсэх, (4) Лекц болон дадлага ажлын харьцаа тохиромжтой байсан эсэх, (5) Тараах материал болон сургалтын байр тохиромжтой байсан эсэхийн талаар сургалтад оролцогчдын сэтгэл ханамжийг судалсан.


2011 оны 11 сарын сургалтын талаарх сэтгэл ханамжийн 5 хоногийн дунджийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2-2: 2011 оны сургалтын сэтгэл ханамж (5 хоногийн дундаж)

Сургалтын байр	Сургалтын зорилго, агуулгын нийцэмж	Сургагч багшийн ярианы ойлгомжтой байдал	Цагийн үр дүнтэй ашиглалт	Лекц, дадлага ажлын харьцаа	Тараах материал, сургалтын байр
СХД	4.35	4.30	4.30	4.29	4.31
БЗД	4.48	4.47	4.31	4.52	4.07
Булган	4.40	4.45	4.50	4.43	4.50
Завхан	4.47	4.50	4.49	4.45	4.51
Сэлэнгэ	4.72	4.76	4.73	4.70	4.79
Дорнод	4.48	4.47	4.31	4.52	4.07

Дээрхээс тодорхой болсончлон бүх сургалтын бүх үзүүлэлт 5 шатны үнэлгээгээр 4.0-аас дээш байсан бөгөөд сэтгэл ханамж туйлын өндөр байсан гэж болно.

Гэвч, 5 хоногийн сэтгэл ханамж бүхий



л сургалт дээр баруун талын графикт (СХД) үзүүлсэнчлэн, 4 дэх өдөр нь хамгийн өндөр болсны дараа, 5 дахь өдөр нь ихээхэн буурах хандлагатай байсан. Эндээс, судалгаат хичээл зохион байгуулдаг 4 дэх өдөр сургалтын хувьд оргил үе нь болсны нөгөөтэйгүүр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах 5 дахь өдөр хүртэл оролцогчдын сонирхол болон анхаарал тогтвортой үргэлжлэхгүй байгааг харж болно.



2012 оны 11 сард зохион байгуулсан сургалтын талаарх сэтгэл ханамжийн 4 хоногийн дунджийг доор үзүүлэв.


Хүснэгт 2-3: 2012 оны сургалтын сэтгэл ханамж (4 хоногийн дундаж)

Зохион байгуулсан газар	Сургалтын зорилго, агуулгын нийцэмж	Сургагч багшийн ярианы ойлгомжтой байдал	Цагийн үр дүнтэй ашиглалт	Лекц, дадлага ажлын харьцаа	Тараах материал, сургалтын байр
СХД	4.23	4.19	3.90	3.91	4.02
БЗД	4.58	4.55	4.55	4.53	4.28
Булган	4.65	4.58	4.55	4.50	4.55
Завхан	4.73	4.73	4.55	4.63	4.63
Сэлэнгэ	4.63	4.63	4.63	4.53	4.55
Дорнод	4.75	4.78	4.68	4.65	4.65

СХД-ийг эс тооцвол, сэтгэл ханамж 2011 оны сургалтаас их төлөв өндөр байсныг харж болно. 2012 оны сургалтаар багшлахуйн арга зүйн хөгжлийн талаарх мэдлэг, туршлагыг нь гүнзгийрүүлэх зорилгоор өмнөх жилийн сургалтад хамрагдсан хүмүүсийг оролцуулахаар төлөвлөсөн байсан боловч, орон нутгийн сонгуулийн бэлтгэл ажилтай давхцсан тул ялангуяа Улаанбаатар хотын оролцогчдыг олж авахад хүндрэл гарч, СХД дэх сургалтын оролцогчдын дийлэнх нь 2012 онд анх удаа оролцож буй хүмүүс байсан. Иймд, өмнөх мэдлэг багатай оролцогчид байсан зэрэг нь дээрх үр дүнд нөлөөлсөн гэж үзэх үндэстэй.

Нөгөөтэйгүүр шугаман графикаас тодорхой болсончлон, 2011 оны 11 сарынх шиг сургалтын сүүлийн өдөр сэтгэл ханамж огцом буураагүй. Энэ нь 2011 онд 5 хоног байсан сургалтыг 4 хоног болгон багасгаж, илүү нягтрал сайтай сургалт болсонтой холбоотой юм.





Зураг 2-1: Сургалтын сэтгэл ханамж

2) Ойлголт

Оролцогчдын ойлголтыг тандах зорилгоор, сургалтын сүүлийн өдөр багшлахуйн арга зүйн хөгжлийн түлхүүр үгсийн утгыг лавлах асуулга судалгаа явуулсан.

2011 оны 11 сарын сургалтаар “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэж юу вэ?” гэсэн асуултад удирдлага 74 хүнээс 11 нь тохиромжтой хариулсан (15%). Мөн, “Хичээлийн бэлтгэл судалгаа гэж юу вэ?” гэсэн асуултад, 217 багшаас 86 нь тохиромжтой хариулт (40%) өгсөн. Тохиромжтой хариулаагүй удирдлагын 19%, багш нарын 26% нь суралцахуйд суурилсан багшлах арга зүй болон хичээлийн бэлтгэл судалгааг “Хичээлийн судалгаа юм” гэж ойлгосон байсан нь ч тодорхой болсон.

2012 оны 11 сарын сургалтын эхний болон сүүлийн өдөр асуулга судалгаа явуулж, ороцогчдын өөрчлөлтийг тандсан. “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэж юу вэ?”, “Хичээлийн судалгаа гэж юу вэ?”, “Хичээлийн бэлтгэл судалгаа гэж юу вэ?” гэсэн асуултад тохиромжтой бөгөөд тодорхой хариулсан оролцогчдын тоог хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2-4: Сургалтын ойлголт

Зохион байгуулсан газар	Суралцахуйд суурилсан багшлах арга зүй		Хичээлийн судалгаа		Хичээлийн бэлтгэл судалгаа	
	Эхний өдөр	Сүүлийн өдөр	Эхний өдөр	Сүүлийн өдөр	Эхний өдөр	Сүүлийн өдөр
СХД	17/90 (19%)	20/82 (20%)	14/90 (16%)	26/82 (32%)	15/90 (17%)	20/82 (24%)
БЗД	32/77 (42%)	22/64 (34%)	18/77 (23%)	12/64 (19%)	18/77 (23%)	9/64 (14%)
Булган	33/80	33/66	17/80	23/66	17/80	22/66

	(41%)	(50%)	(21%)	(35%)	(21%)	(32%)
Завхан	24/60 (40%)	35/77 (45%)	11/60 (18%)	16/77 (21%)	14/60 (23%)	16/77 (21%)
Сэлэнгэ	31/74 (42%)	37/65 (57%)	9/74 (12%)	19/65 (29%)	8/74 (11%)	12/65 (18%)
Дорнод	20/81 (25%)	32/75 (43%)	12/81 (15%)	14/75 (19%)	2/81 (2%)	14/75 (19%)

2012 оны 11 сарын сургалтыг зохион байгуулахдаа өмнөх жилийнхээ дүгнэлт тусган, сургагч багш нарын хичээлийн судалгааны талаарх ойлголтыг нь нэгтгэхийн хамт, чанартай судалгаат хичээл зохион байгуулж, суралцахуйд суурилсан багшлах арга зүйн талаарх ойлголтыг нь гүнзгийрүүлэхээр чармайж ажилласан. Үүний үр дүнд, 2012 оны 11 сарын сургалтаар “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй”-н талаар зөв ойлгосон оролцогчдын тоо нэмэгдсэн. 2012 оны 11 сарын сургалтад оролцогчдын хичээлийн судалгаа, хичээлийн бэлтгэл судалгааны талаарх ойлголт, 2011 оны 11 сарын сургалтад оролцогчдын ойлголтоос өндөр байсан гэх аргагүй ч, сургалт эхний болон сүүлийн өдрийг харьцуулахад, оролцогчдын ойлголт их төлөв дээшилсэн байна. Иймд, уг шалгуур биелсэн гэж болно.

Шалгуур 2: Оролцогчдын үйлийн хандлага эерэгээр өөрчлөгдсөн байх.

2012 оны 6 сарын 3-4-нд зохион байгуулсан “Хичээлийн судалгааны тайлангийн хурал”-ын үеэр үндэсний хэмжээний багшлахуйн арга зүйн шинэчлэлийн хэрэгжилтийг тодруулсан. Үндэсний хэмжээний 747 сургуулийн 476-д нь (64%) нь хичээлийн судалгаа зохион байгуулагдснаас гадна, Улаанбаатар хот болон 21 аймгийн 19-д нь сургалт зохион байгуулагдсан. Мөн, бүх аймагт аймгийн баг бүрдсэн зэрэг эерэг өөрчлөлт гарсан.

2013 оны 8 сарын 15-16-нд зохион байгуулсан “Хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал”-ын үед ч дахин үндэсний хэмжээний багшлахуйн арга зүйн хөгжлийн хэрэгжилтийг тандаж үзэхэд, 2012-2013 оны хичээлийн жилд 2-оос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан сургууль нийт 752 сургуулийн 487 (65%) байсан. Улаанбаатар хот болон 21 аймгийн 16-д нь сургалт зохион байгуулагдаж, одоогоор мэдэгдэж байгаа давхардсан тоогоор 14932 багш (Нийт багшийн тоо: 26492) хамрагджээ. 2013-2014 хичээлийн жилд 10 аймаг хичээлийн судалгаагаар холбоотой төлөвлөгөөг хэдийнэ боловсруулсан байна.

Шалгуур 3: Бүх аймаг, дүүргийн багийн гишүүд багшлах арга зүйн модульт сургалтад хамрагдсан байх. (8-аас доошгүй хүн)

2011 онд зам тээврийн осолд орсон Архангай аймгаас бусад 20 аймаг, 9 дүүргийн “Аймаг, дүүргийн баг”-ийн тус бүр 11 гишүүн сургалтын багц материалд тулгуурласан сургалтад хамрагдсан. 2012 оны 3 сарын 15-17-нд, БСШУЯ болон төслийн багийн зүгээс Архангай аймгийн баг болон холбогдох 53 хүнд зориулан сургалт зохион байгуулсан.

2012 онд ч, Архангай аймгаас бусад 20 аймаг, 9 дүүргийн “Аймаг, дүүргийн баг”-ийн

- 2012-2013 оны хичээлийн жилд 14 сургуулийн 13 нь зохион байгуулсан.

Шалгуур 1 биелэгдсэн ба шалгуур 2 ч их төлөв биелэгдсэн гэж болно. 2012-2013 оны хичээлийн жилд 8 хичээлээр хичээлийн судалгаа зохион байгуулж чадаагүй сургууль нь 18-хан багштай жижиг сургууль байсан. Интернетэд холбогдоогүй учир Мэдээлэл зүйн судалгаат хичээл зохион байгуулахад төвөгтэй байсан. Нөгөөтэйгүүр, бага дунд ахлах гэсэн 7 сургуулиас бүрддэг СХД-ийн Ирээдүй ЦС-ийн загвар сургуулиар сонгогдсон 2 сургуулиас бусад сургуулиуд ч жилд тус бүр 3 удаа хичээлийн судалгаа зохион байгуулжээ.

Шалгуур 3: Загвар сургуулиудын хичээлийн судалгааны чанар дээшилсэн байх.

Дөрөв дэх удаагийн хичээлийн судалгааны мониторингоор (2012 оны 9-10 сар), хичээлийн судалгааны чанарыг 2011 он болон 2012 оноор харьцуулж үзсэн. Мөн, тав дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн (2013 оны 3-4 сар) үед ч бүх загвар сургуулиудад зохион байгуулагдсан хичээлийн судалгааны чанарыг судалсан.

Дөрөв, тав дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн үед тодорхой болсон “Хичээлийн судалгааны чанар”-ыг Хавсралт 5-д үзүүлэв.

Мөн, тав дахь удаагийн мониторингоор дараах хичээлийн судалгааны менежментээр ажилласныг олж мэдсэн бөгөөд хичээлийн судалгааны чанар дээшилж байгаа нь харагдсан.

- Аль нэг өдрийг “Хичээлийн судалгааны өдөр” болгон тогтож, хоёр долоо хоногт нэг удаа сургалтын менежер нь лекц уншдаг, багш нар багаараа хичээлийн бэлтгэл судалгаа хийж буй сургууль байна.
- Нилээд олон сургууль дээр 2011, 2012 оны Япон дахь сургалтад оролцогчид голлон, самбар төлөвлөлт, дэвтэр хөтлөлт гэсэн сэдвээр сургуульд суурилсан хичээлийн судалгаа зохион байгуулж байна.
- Тухайн судалгаат хичээлийн бэлтгэлд оролцоогүй багш нар хөндлөнгөөс хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэгт оролцон, хэлэлцүүлэг дээр шинэ санаа оноо өгч байсан.
- Зэргэлдээ сургуулийн багш нартай хамтран, судалгаат хичээл зохион байгуулж буй сургууль ч байсан. Сургуульд нь ижил мэргэжлийн багш цөөн тохиолдолд ч нижгээд тооны сургуулийн багш нар хамтран ажилласнаар, хичээлийн бэлтгэл судалгааг үр дүнтэй зохион байгуулж болно. Хэлэлцүүлгийн хөтлөгч, хичээл заасан багш, ажиглагч багш нар дэс дараалан саналаа хэлэх хэв маягт баригдалгүйгээр, анхаарвал зохих зүйлүүдээ нэгтгэсэн ажлын хуудсанд нэгтгэх буй хэлэлцүүлэг ч харагдаж байсан.



Дээрхээс харахад, шалгуур 3 биелэгдсэн гэж болно.

Шалгуур 4: Загвар сургуулиудын хичээлийн судалгаанд оролцогчдын сэтгэл


ханамжийн үнэлгээ дээшилсэн байх.

Загвар сургуулиудын хичээлийн судалгааны талаарх сэтгэл ханамжийг тандах зорилгоор 2012 оны 9-10 сард асуулга судалгаа явуулсан.



2010 онд Сонгинохайрхан дүүргийн загвар сургуулиудын хичээлийн судалгаанд оролцсон 81 хүнээс “Хичээлийн судалгаанд маш их сэтгэл ханамжтай байсан” гэж хариулсан хүн 20%-тай байсан бол, 2012 оны байдлаар “Хичээлийн судалгаанд маш их сэтгэл ханамжтай байсан” гэж хариулсан хүн 53%-д хүрчээ.



Булган аймгийн загвар сургуулиудын хичээлийн судалгаанд оролцсон 73 хүнээс 2010 онд “Хичээлийн судалгаанд маш их сэтгэл ханамжтай байсан” гэж хариулсан хүн 25% байв. Нөгөөтэйгүүр, 2012 онд “Хичээлийн судалгаанд маш их сэтгэл ханамжтай байсан” гэж хариулсан хүн 58%-д хүрчээ.



Завхан аймгийн загвар сургуулиуд дээр хичээлийн судалгаанд оролцсон 129 хүнээс 2010 онд “Хичээлийн судалгаанд маш их сэтгэл ханамжтай байсан” гэж хариулсан хүн 26% байсан бол 2012 онд “Хичээлийн судалгаанд маш их сэтгэл ханамжтай байсан” гэж хариулсан хүн 67% болсон.



Дээрх асуулгын үр дүнгээс, төсөл хэрэгжиж эхэлсэн 2010 оны тухайн үетнй харьцуулахад, загвар сургуулиудын багш нарын хичээлийн судалгааны талаарх сэтгэл ханамж дээшилсэн болохыг харж болно. Үүнтэй холбогдуулан шалгуур 4 ч биелэгдсэн гэж болно.

Асуулгад хичээлийн судалгаанд сэтгэл ханамжтай гэсэн шалтгааныг нь ч тодруулсан юм. 2010 оны тухайн үед хичээлийн судалгаанд сэтгэл ханамжтай байсны шалтгаанд “Хичээлийн судалгаагаар өөрөө өөрийнхөө мэргэжлийн ур чадвар дээшлүүж болдог” гэсэн хариулт хамгийн олон байсан бол, 2012 онд “Хичээлийн судалгааны ач холбогдолыг ойлгосон учраас” гэдэг хариулт нэмэгджээ. Төслийн амжилттай хэрэгжихтэй зэрэгцэн, загвар сургуулийн багш нар хичээлийн судалгааны үр өгөөж сайтар ойлгон хүлээж авах болсон байна.

Дээрх 4 шалгуур биелэгдсэн тул үр дүн 2 биелэгдсэн гэж болно. Бүх загвар сургуулиуд сургуульд суурилсан хичээлийн судалгааны сэдвээ сонгон, зохион байгуулалтаа сайжруулах зэргээр алдаж оносоор, сургууль бүр өөртөө таарсан хичээлийн судалгаа хэрэгжүүлэх тогтолцоотой болсон. Тэдгээрийг дараах байдлаар загварчлах боломжтой бөгөөд цаашид Монголд хичээлийн судалгаагаар дамжуулан багшлахуйн арга зүйг хөгжүүлэхэд ашиглаж болох юм.

“Багшлахуйн арга зүйн хөгжил: Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент”-ийн гарын авлагад дурьдсан 3 загвар

- Багшлахуйн тодорхой арга зүйг сайжруулах хичээлийн судалгаа: Сургууль дээрээ судалгаат хичээл зохион байгуулж, хэлэлцүүлэг дээр олж авсан санаандаа үндэслэн ээлжит хичээлийн хөтөлбөрөө сайжруулан, өөр ангид хичээл зохион байгуулах гэсэн үг. Ангийн тоо олонтой сургуулийн хувьд, богино хугацаанд арга зүйгээ сайжруулах (Хэрэглэгдэхүүний тохиромжтой байдал зэрэг ч багтана) боломжтой. Бага хэмжээний сургуулийн хувьд, сайжруулсан ээлжит хичээлийн хөтөлбөрөөр дараа хичээлийн жилд л хичээл зохион байгуулахаас аргагүйд хүрдэг. Ижил судлагдахууны багш цөөнтэй хөдөөгийн сургууль (Ялангуяа дунд анги) дээр зохион байгуулахад хэцүү байдаг.
- Туршлага солилцох, тодорхой арга зүйг тогтмол ашиглах, сайжруулах: Зөвхөн нэг сургууль дээр бус, зэргэлдээ сургуулийн ижил судлагдахууны багш нарын хийх хичээлийн судалгаа. Туршлага солилцох, бүсийнхээ багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын арга хэрэгсэл болно гэдэг утгаараа үр дүнтэй. Туршлага багатай багш нарт зориулан ахмад багш загвар хичээл зохион байгуулах гэж хэлж ч болно. Судалгаат хичээлээр анзаарч олж авсан зүйлээ залуу багш нарт зааж сургах гэх мэт эргэх холбоо бий болгоход сургалтын менежер зэрэг удирдлагын ур чадвар чухлаар тавигдана.
- Урьд өмнө зохион байгуулсан хичээлийн судалгааны үр дүнг ашигласан хичээлийн судалгаа: Сургууль, аймаг, үндэсний хэмжээний аль ч түвшинд зохион байгуулах боломжтой. Гэвч, үлгэр жишээ болохуйц түвшинд зохион байгуулагдсан хичээлийн судалгааны тайлан хэрэг болно. Хичээлийн судалгаа тайлан боловсруулахад сургуулийн

удирдлага, БГ-аас чиглүүлэг өгөх, БМДИ-ийн тайланг ашиглавал илүү үр дүнтэй.

Загвар 14 сургуульд зохион байгуулсан “Сургуульд суурилсан хичээлийн судалгаа”-ны загвар

Загвар 14 сургуулиуд 2010-2011, 2011-2012, 2012-2013 оны 3 хичээлийн жилийн турш сургуульд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулсан.

- Эхний жил: Нэгээс бусад бүх загвар сургуулиуд эхний жил сэдэв сонголгүй хичээлийн судалгаа эхлүүлсэн. Ихэнх сургуулиуд төслийн зорилтот 8 хичээлээр шинэ баг бүрдүүлэх, эсвэл хуучин Заах аргын нэгдлийг (ЗАН) ашиглах байдлаар сургуульд суурилсан хичээлийн судалгааны зохион байгуулалтаа хийсэн. Олонхи сургуулиуд багаа 2010 оны 11 сарын сургалтын оролцогчид болон зорилтот 8 хичээлийн багш нараар голчлон бүрдүүлжээ.
- Хоёр дахь жил: Сэдэв сонгон сургуульд суурилсан хичээлийн судалгаа зохион байгуулсан сургуулиуд гарч ирсэн. Хамгийн түгээмэл сэдвээр “Самбар төлөвлөлт”-ийг (5 сургууль) дурьдаж болно. Зохион байгуулалтын тухайд, сургуулийнхаа цар хэмжээнээс хамаараад 8 хичээлийг 4 багт хуваах, эсвэл бага ангийн багш нарыг 4 баг, дунд ангийн багш нарыг 4 баг болгосон сургуулиуд ч байсан. Мөн, сургуулийнхаа бүх багш нарыг баг бүрт хуваан, хичээлийн судалгаанд оролцуулах болсон байна.
- Гурав дахь жил: Хийсвэр сэдэв сонгодог байсан сургуулиуд тодорхой сэдэв сонгох болсон. Зохион байгуулалтын хувьд үндсэндээ хоёр дахь жилийнхийг тэр хэвээр нь үргэлжлүүлэн, нарийн зохицуулалтуудыг хийсэн. 8 хичээлээс бусад хичээлээр ч судалгаат хичээл зохион байгуулах явдал нэмэгдсэн.

(3) Үр дүн 3: Загвар аймаг, дүүргийн багш нарын суралцахуйд суурилсан багшлах ур чадвар дээшилнэ.

Үр дүн 3-ын биелэлтийн тухайд, загвар аймаг, дүүргийн сургуулиудын багш, удирдлагын суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалтад хамрагдсан байдал, хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан байдал, загвар аймаг, дүүргийн сургуулиудын үйл ажиллагааны туршлага сургамж болон зөвлөмжөө нэгтгэсэн эсэхийг судалсан.

Шалгуур 1: Загвар аймаг, дүүргийн сургуулиудын багш, удирдлагын 70-иас доошгүй хувь нь багшлах арга зүйн модульт сургалтад хамрагдсан байх.

Загвар аймаг, дүүрэгт суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалтад хамрагдсан багш, удирдлагын тоо болон хувийг доор үзүүлэв.

Хүснэгт 2-6: Загвар аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалтад хамрагдагсадын тоо

Загвар аймаг, дүүрэг		2011-2012 оны хичээлийн жил 2012 оны 9 сарын байдлаар			2012-2013 оны хичээлийн жил 2013 оны 8 сарын байдлаар		
		Хүний тоо	Хамрагдсан хүний тоо	Хувь	Хүний тоо	Хамрагдсан хүний тоо	Хувь
СХД	Удирдлага	Тодорхой бус	74	Тодорхой бус	113	Тодорхой бус	Тодорхой бус
	Багш	1,493	1,080	72%	2,500	Тодорхой бус	Тодорхой бус
Булган	Удирдлага, багш	724	550	76%	572	Давхардсан тоогоор 889	-
Завхан	Удирдлага	72	58	81%	-	Давхардсан тоогоор 2339	-
	Багш	885	639	72%	885		

Шалгуур 2: Загвар аймаг, дүүргийн сургуулиудын 80-иас доошгүй хувь нь хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан байх.

2011-2012 оны хичээлийн жилд СХД-ийн 13 сургуулийн 13 (100%), Булган аймгийн 23 сургуулийн 19 (83%), Завхан аймгийн 29 сургуулийн 29 (100%) нь хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан.

2012-2013 оны хичээлийн жилд СХД-ийн 13 сургуулийн 13 (100%), Булган аймгийн 23 сургуулийн 23 (100%), Завхан аймгийн 29 сургуулийн 29 (100%) нь хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан.

Хүснэгт 2-7: Загвар аймаг, дүүрэгт “Хичээлийн судалгаа” зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан сургууль

Загвар аймаг, дүүрэг	Сургуулийн тоо	2011-2012 оны хичээлийн жил 2012 оны 9 сарын байдлаар		2012-2013 оны хичээлийн жил 2013 оны 8 сарын байдлаар		Тайлбар
СХД	13	13	100%	13	100%	
Булган	23	19	83%	23	100%	Зохион байгуулах төлөвлөгөө боловсруулаагүй сургуулийн 3 нь багийн (Сумын доторх засаг захиргааны нэгж) сургууль, 2 нь жижиг сумын сургууль байсан.
Завхан	29	29	100%	29	100%	

Шалгуур 1-ийн тухайд, бүх загвар аймаг, дүүргийн сургуулиудын багш, удирдлагын

70-аас дээш хувь нь суралцахууд суурилсан багшлах арга зүйн сургалтад хамрагдсанаас үзэхэд, энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэн гэж үзэж болно.

Мөн, шалгуур 2-ын тухайд, бүх загвар аймаг, дүүргийн сургуулиудын 80-аас дээш хувь нь хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан тул биелэгдсэн гэж болно.

Шалгуур 3: Загвар аймаг, дүүргүүдээс багшлах ур чадварыг дээшлүүлэх сургамж, зөвлөгөөг цуглуулсан байх.

Загвар аймаг, дүүргийн багшлахуйн арга зүйн хөгжлийн туршлага сургамж, зөвлөгөө болгож, аймаг, дүүрэг, сургуулийн түвшний хичээлийн судалгааны менежменттэй холбоотой “Багшлахуйн арга зүйн хөгжил: Хичээлийн судалгаанд удирдлагын үүрэг оролцоо” модуль болон “Багшлахуйн арга зүйн хөгжил: Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент” гарын авлагыг боловсруулан гаргасан.

Загвар аймаг, дүүргийн багшлахуйн арга зүйн хөгжлийн туршлага сургамж, зөвлөгөөг нэгтгэсэн тул шалгуур 3 биелэгдсэн. Дараа нь “Багшлахуйн арга зүйн хөгжил: Хичээлийн судалгаанд удирдлагын үүрэг оролцоо” модульд багтсан загвар сургуулиудын хичээлийн судалгаа зохион байгуулахад гарсан бэрхшээлийг даван туулах аргуудаас танилцуулья.

Загвар сургуулиудын хичээлийн судалгаа зохион байгуулахад гарсан бэрхшээлийг даван туулах арга

- Бэрхшээлийн нэгээр ээлжийн тогтолцоог дурьдаж болно. Нийслэлийн СХД-ийн 67-р сургуульд багш нар 2-3 ээлжээр ажиллаж байгаа тул хамтран үйл ажиллагаа явуулах цагаа зохицуулах, анги танхим олоход хүндрэл гардаг. Цагийн хуваарь боловсруулахдаа, хичээлийн судалгааны нэг багт харьяалагддаг багш нарыг ижил цагт 2-3 цаг чөлөөтэй байхаар зохицуулан хамтын үйл ажиллагааг нь дэмжсэн.
- Бас нэг бэрхшээл нь хичээлийн материал дутмаг байал юм. Зарим сургууль дээр эцэг эхчүүдийн дэмжлэгийг авснаар энэ асуудлаа шийдвэрлэсэн байна. Сургууль дээрээ мэдээллийн булан байгуулж, эцэг эхчүүдэд багш нарын үйл ажиллагааг таниулан ойлгуулах ажлуудыг хийсэн.

Дээрхээс харахад, үр дүн 3 биелэгдсэн.

(4) Үр дүн 4: Багш бэлтгэх шатанд суралцахууд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх орчин боловсронгуй болно.

Суралцахууд суурилсан багшлах арга зүйг багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сураглалтад нэвтрүүлэх, бодлогын зөвлөмжийг БШУЯ-ны бодлого зорилтод тусгагдсан эсэхийг судлан, үр дүн 4-ийн биелэлтийг шалгасан.

Шалгуур 1: Багш бэлтгэдэг их дээд сургуулиудад сургалтын модулийн “Багшлах арга зүй”-г нэвтрүүлсэн байх.

МУИС-ийн ХХИС-д сонголтот хичээл болох “Химийн хичээлийн судалгааны арга зүй” (2 кредит, 7 улирал), ФЭС, ГГС-д ч мөн адил сонголтот хичээлийг нэвтрүүлсэн.

Их дээд сургуульд “Хичээлийн судалгаа” гэсэн хичээл оруулах тухай төлөвлөгөө болон агуулгын талаар илтгэсэн “Хичээлийн судалгаа: Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр” боловсруулсан.

Төслийн эхний болон хоёр дахь жилд багш бэлтгэдэг их дээд сургуулиудад суралцахуйд суурилсан багшлах арга зүй болон хичээлийн судалгааг танилцуулах семинар зохион байгуулсан. Харин, оролцогчид “Угаасаа хичээл ихтэй учраас шинээр хичээл оруулахад хэцүү”, “Хариуцсан багшийн ачаалал ихэснэ” гэх зэргээр ярьсан тул, “Хичээлийн судалгаа” гэдэг хичээл ямар байж болох талаар санаа оноогоо солилцон, хариуцсан багшийн ачааллыг хөнгөвчлөх зорилгоор “Хичээлийн судалгаа: Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр”-ийг боловсруулсан.

Уг хөтөлбөр нь 8 лекц болон 16 семинараас бүрдэнэ. Үнэлгээ аргыг нь ч тодорхой тэмдэглэсэн бөгөөд практикт хэрэгжихүйц болжээ. Доор хөтөлбөрийн талаар танилцуулав.

Лекцийн сэдэв (1 кредит)		
7 хоногт судлах цаг	Лекцийн бүлэг сэдэв	Агуулга
I 2 цаг	Лекц 1: Танилцуулга	<ul style="list-style-type: none"> • Боловсролын шинэчлэл • Багшийн хөгжил, эсвэл ажлын байран дээр мэргэжил дээшлүүлэх асуудал • Хичээлийн судалгаа, түүний хөгжил
II 2 цаг	Лекц 2: Хичээлийн бэлтгэл судалгаа -1	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн бэлтгэл судалгааны талаарх ойлголт, мөн чанар • Сургалтын агуулгын судалгаа • Хэрэглэгдэхүүний судалгаа
IV 2 цаг	Лекц 3: Хичээлийн бэлтгэл судалгаа -2	<ul style="list-style-type: none"> • Мэдлэг эзэмшилтийн судалгаа, хүүхдийн судалгаа • Арга зүйн судалгаа
VI 2 цаг	Лекц 4: Хичээлийн бэлтгэл судалгаа -3	<ul style="list-style-type: none"> • Үнэлгээний судалгаа
VIII 2 цаг	Лекц 5: Хичээлийн бэлтгэл судалгааны үр дүнг ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулалтад тусгах	<ul style="list-style-type: none"> • Ээлжит хичээлийн хөтөлбөрийн алхмууд • Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулалтад хичээлийн бэлтгэл судалгааны үр дүнг тусгах
X 2 цаг	Лекц 6: Хичээл заах, ажиглах	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн технологи: Хичээлийн зорилго, зорилт, агуулга, багшлахуйн арга зүй, үнэлгээ, багшийн заах

		үйл ажиллагаа, сурагчдын суралцахуй болон танин мэдэхүйн үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> Хичээлд ажиглалт хийх арга: Хичээлийн ажиглалтын технологи, баримт нотолгоо цуглуулах арга, ажиглалтын тэмдэглэлд үндэслэн дүн шинжилгээ хийх
XII 2 цаг	Лекц 7: Хичээлийн дараах хэлэлцүүлэг	<ul style="list-style-type: none"> Судалгаат хичээлийн хэлэлцүүлэг хийх, хэлэлцүүлгийн орчин Хэлэлцүүлгийг чиглүүлэх Хэлэлцүүлэг - Идэвхтэй оролцоо Судалгаат хичээлийн хуудас
XIV 2 цаг	Лекц 8: Хичээлийн судалгааны үр дүнг багшлахуйн арга зүйн шинэчлэлд ашиглах тухай	<ul style="list-style-type: none"> Ээлжит хичээлийн хөтөлбөрийг сайжруулах Агуулгаа сайжруулахад ашиглах Багшлахуйн арга зүй, дидактик шийдлээ сайжруулахад ашиглах Хэрэглэгдэхүүнээ сайжруулахад ашиглах

Лекцийн даалгавар зохиох, шалгалт авах:

1. Лекц бүрийн дараа, ойлгосныг нь шалгах асуулт, тэдгээрт холбоотой мэдээлэл орсон сурах бичиг, ашиглах материалын нэр, уншиж судлах хуудасны дугаарыг зааж өгөх.
2. Лекцийн даалгаврын биелэлтийг улиралд 2 удаа шалгах. Лекцийн даалгаврыг семинарт ашиглах.

7.5 оноо х 2 удаа = 15 оноо

Семинарын сэдэв (1 кредит)

7 хоногт судлах цаг	Семинарын сэдэв	агуулга
I (II) 2 цаг	Семинар 1: Багш нар хичээлийн судалгаа хийх г эрх зүйн үндэслэл	<ul style="list-style-type: none"> Багшийн ажил байрны тодорхойлолт ба хичээлийн судалгаа Багшийн ажлын үр дүнгийн үнэлэх журам ба хичээлийн судалгаа
III 2 цаг	Семинар 2-7: Хичээлийн бэлтгэл судалгаа	<ul style="list-style-type: none"> Агуулгын судалгааны арга Хэрэглэгдэхүүний судалгааны арга
III (IV) 2 цаг		
V 2 цаг		<ul style="list-style-type: none"> Мэдлэг эзэмшилтийн судалгааны арга Арга зүйн судалгааны арга
V (VI) 2 цаг		
VII 2 цаг		<ul style="list-style-type: none"> Үнэлгээний судалгааны арга Ээлжит хичээл ба нэгж хичээлийн сэдвийг үнэлэх судалгааны арга
VII (VIII) 2 цаг		
IX 2 цаг	Семинар 8: Ээлжит хичээлийн хичээлийн бэлтгэл судалгаа хийх	<ul style="list-style-type: none"> Тухайн хичээлийн сэдвийг сонгон, түүнд бэлтгэхийн тулд хичээлийн бэлтгэл судалгаа хийх.
IX (X) 2 цаг	Семинар 9: Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах	<ul style="list-style-type: none"> Хийсэн хичээлийн бэлтгэл судалгааны үр дүнгээ ашиглан, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах.
XI 2 цаг	Семинар 10-11: Хичээлд ажиглалт хийх	<ul style="list-style-type: none"> Хичээлд ажиглалт хийн тэмдэглэл хөтлөх, судалгаанд шаардлагатай мэдээлэл цуглуулах дадлага ажил хийх.
XI (XII) 2 цаг		
XIII 2 цаг	Семинар 12-13: Судалгаат хичээлийн хэлэлцүүлэг	<ul style="list-style-type: none"> Хэлэлцүүлэг хийн, бодит жишээ авч дүн шинжилгээ хийн, хэлэлцүүлгийн орчинг хэрхэн бүрдүүлэх, хэрхэн чиглүүлэх тухай дүгнэлт гаргах.

XIII (XIV) 2 цаг		<ul style="list-style-type: none"> • Судалгаат хичээлийн ажиглалтын хуудас бөглөх жишээнээс суралцах • Бодит хэлэлцүүлэгт оролцох.
XV 2 цаг	Семинар 14-15:	<ul style="list-style-type: none"> • Ажиглалтын тэмдэглэл, хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн, судалгаат хичээлийн хөтөлбөрөө сайжруулах. Үндэслэлээ тодорхой болгох. Ээлжит хичээлийн хөтөлбөрийг сайжруулах.
XV (XVI) 2 цаг	Судалгаат хичээлийн хөтөлбөрийг сайжруулах	
XVI 2 цаг	Семинар 16: Хичээлийн судалгааны талаар судалснаа нэгтгэх	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн судалгааны үндсэн алхмууд, хичээлийн судалгаа ба судалгаат хичээл, хичээлийн бэлтгэл судалгаа

Семинарын үнэлгээ:

Семинарын явцад хийсэн үйл ажиллагаанд оролцсон байдал, илтгэл хийсэн байдал, гаралт, санал зэргийн биелэлтийн нийлбэрээр үнэлнэ.

- Хийсэн үйл ажиллагаан дахь оролцоо 5 оноо
- Илтгэл, гаралт, санал 9 оноо
- Семинарын биелэлт, дасгал, дэвтэр хөтлөлт 10 оноо
- Оролцоо 1 оноо

Нийт: 25 оноо

Дээрхээс харахад, шалгуур 1 биелэгдсэн. Гэвч, их дээд сургуульд шинэ хичээл болгон оруулахын тулд, эхлээд багшийн ажилтай холбоотой хөтөлбөрийг нэлэнхүйд шинэчлэх шаардлагатай болно. Эдүгээ БШУЯ нь багш бэлтгэдэг их дээд сургуулийн шинэчлэлийг хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид ахиц дэвшил гарна гэдэгт найдаж байна.

Шалгуур 2: БСШУЯ-ны үйл ажиллагааны бодлого зорилтод төслөөс гаргасан бодлогын зөвлөмжийг тусгасан байх.

БСШУЯ нь 2010-2011 оны хичээлийн жилийн зорилтдоо “Бүх багш хичээлийн судалгааны арга зүйг судлан, сургууль бүр хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан, энэ хичээлийн жилд 2-оос дээш удаа хичээлийн судалгааг хийх” гэж тусгасан.

Дээр дурьдсанчлан шалгуур 2 биелэгдсэн. БСШУЯ нь “Бүх багш хичээлийн судалгааны арга зүйг судлан, сургууль бүр хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан, энэ хичээлийн жилд 2-оос дээш удаа хичээлийн судалгааг хийх” гэсэн зорилт дэвшүүлснээр, хичээлийн судалгаагаар дамжуулан багшлахуйн арга зүйн хөгжлийг багшийн үндсэн ажил болохыг багш нарт ойлгуулж өгсөн юм. Энэ нь загвар сургуулиудад өөрсдийн үйл ажиллагаандаа итгэлтэй болсны зэрэгцээ, загвар бус аймгийн сургуулиуд ч хичээлийн судалгааг сонирхох болсон.

Дээрхээс харахад үр дүн 4 биелэгдсэн.

Төслийн зорилго: “Суралцагчдын суралцахуйг дэмжих багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” шалгуур үзүүлэлтийн 4 хүрэх үр дүнгийн шалгуурууд дээр дурьдсанчлан биелэгдсэн. Энэ нь уг багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх боловсон хүчин болох мэргэжлийн баг болон “Аймаг, дүүргийн баг” бэлтгэгдсэн явдал, загвар аймаг, дүүргийн хичээлийн судалгааны загварт суурилсан сургалтын багц материал (Сургалтын хөтөлбөр бүхий сургалтын модулиуд) боловсруулагдсаны зэрэгцээ БШУЯ нь хүчин чармайлт гарган ажиллаж, суралцагчдын суралцахуйг дэмжих багшлахуйн арга зүйн хөгжил Монголд орон даяар түгэн дэлгэрэх тогтоцлоо бий болсныг гэрчилж байна.

2.3 Эрхэм зорилго: “Загвар болон бусад аймаг, дүүргийн багш нар суралцахуйд суурилсан багшлах арга зүйг туршин хэрэгжүүлнэ.”

Эрхэм зорилго төсөл дууссанаас хойш 3-5 жилийн дараа биелэх ёстой. “Үндэсний хэмжээнд нийт сургуулиудын 60-аас доошгүй хувь нь жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан байх”, “Бүх аймаг, дүүрэгт суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалт зохион байгуулагдсан байх” гэсэн 2 шалгуур үзүүлэлтийг төслийн эцсийн шатны үнэлгээгээр (2012 оны 9 сар) болон төсөл дуусахад (2013 оны 8 сар) тандаж үзсэн.

Шалгуур 1: Монгол улсын бүх сургуулийн 60 хувь нь жилд хоёроос доошгүй удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан байх.

Төслийн эцсийн шатны үнэлгээгээр, 2011-2012 оны хичээлийн жилд доод тал нь нэг удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан сургууль үндэсний хэмжээнд 747 сургуулиас 476 болжээ.

2013 оны 8 сарын байдлаар, 2012-2013 оны хичээлийн жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан сургууль үндэсний хэмжээнд 752 сургуулиас 487 (65%) болсон.

Шалгуур 2: Багшлахуй арга зүйн сургалтыг бүх аймаг, дүүрэгт зохион байгуулсан байх.

Төслийн эцсийн шатны үнэлгээгээр, 2011-2012 оны хичээлийн жилд Улаанбаатар хот болон 21 аймгийн 19-д нь суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны сургалт зохион байгуулагдсан байна. Улаанбаатар хотын хувьд, НБГ-аас хичээл тус бүрээр 32 удаа сургалт зохион байгуулж, 1800 хүн хамрагдсан.

2013 оны 8 сарын байдлаар, 2012-2013 оны хичээлийн жилд суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны сургалтыг Улаанбаатар хот болон 21 аймгийн 16-д нь зохион байгуулсан байна. Эдгээр сургалтад давхардсан тоогоор 14932 багш

оролцжээ. (Үндэсний хэмжээнд нийт багшийн тоо 26492)

Төсөл дуусах үед, үндэсний хэмжээнд нийт сургуулиудын 65% нь жилд доод тал нь хоёр удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан. Мөн, Улаанбаатар хот болон 21 аймгийн 16-д нь суралцахуйд суурилсан багшлах арга зүйн сургалт зохион байгуулагдсанаас үзэхэд, эрхэм зорилго биелэгдэх төлөвтэй байна.

Загвар аймаг, дүүргийг сонгон, мэргэжлийн баг бүрдүүлсний дараа буюу 2010 оны 11 сард сургалтын модулийн эхний хувилбарыг турших боломжтой болсон. Монголд хичээлийн шинэ жил 9 сард эхлэн, 6 сард дуусдаг гэдгийг тооцож үзвэл, төслийн үндсэн хугацаанд (2010 оны 3 сар - 2013 оны 2 сар) зөвхөн 2011-2012 оны хичээлийн жилд л төсөл хангалттай хэмжээнд үйл ажиллагаа явуулах бололцоотой байсан. Төслийн хугацааг хагас жилээр сунгаснаар 2011-2012 болон 2012-2013 оны хоёр хичээлийн жилд үйл ажиллагаа явуулах боломжтой болсон зэргээс эрхэм зорилго биелэгдэх магадлал илт тодорхой болж ирсэн.

Үндэсний хэмжээнд 752 сургуулийн 487 нь жилд хоёроос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулах болсон үндэслэлд, Монгол Улсын хэмжээнд суралцахуйд суурилсан багшлах арга зүйг таньж мэдэх болсны зэрэгцээ шаардлага ч өндөрсөж байгааг дурьдаж болно. 2012 оны 8 сард байгуулагдсан шинэчлэлийн засгийн газар “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” бодлогоо илэрхийлснээр, суралцахуйд суурилсан багшлах арга зүйн талаарх ойлголт мэдлэг болон хэрэгцээ шаардлага өндөрсөн, төслийн эхний шатнаас хойш тус төслийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн багшлахуйн арга зүйн шинэчлэлийг хүлээн авах хөрс суурь түргэн хугацаанд бүрдсэн. Энэ цаг үед төсөл хэрэгжсэн явдал ч бас чухал юм.

Түүнчлэн, 2012 оны 9 сард байгуулагдсан БМДИ нь арга зүйч нартаа төслийн сургалт болон Япон дахь сургалтад хамруулан, мэргэжлийн багтай хамт хичээлийн судалгааны мониторингт оролцуулан туршлагажуулах зэргээр багшлахуйн арга зүйн хөгжил болон хичээлийн судалгааны талаарх ойлголтыг нь гүнзгийрүүлж ирсэн. Мөн, төслийн хүрээнд тус БМДИ-ийн сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулахал нь дэмжлэг үзүүлсэн зэргээр, тус БМДИ-ийн зохион байгуулдаг үндсэн сургалт¹⁵ зэрэгт хичээлийн судалгааг сургууль дээр багшлахуйн арга зүйг хөгжүүлэх арга хэрэгсэл хэмээн танилцуулах болсон нь ч бас нэгэн хүчин зүйл болов уу.

Жишээлбэл, 2013 оны 3-4 сард БМДИ-ийн зүгээс багшийн мэргэжил дээшлүүлэх 10 дахь жилийн үндсэн сургалтыг дараах хөтөлбөрөөр зохион байгуулсан.

- Сургалтад нийт 1186 хүн оролцсон бөгөөд Улаанбаатар, Ховд (Баруун бүс), Хэнтий

¹⁵ Шинэчлэлийн засгийн газар байгуулагдсанаас хойш шинэ багш, 5 жил ажилласан багш, 10 жил ажилласан багш нарын сургалтыг зохион байгуулагдах болсон (Орон нутгийн БГ-ууд тус тусдаа 2, 3, 4 дэх жилийн сургалтыг зохион байгуулах болсон).

(Зүүн бүс), Архангай (Хангайн бүс) гэсэн 4 газарт 7 хоногийн турш зохион байгуулсан.

- Сургалтын агуулга - Эхний өдөр: БШУЯ-ны бодлогыг танилцуулах, 2-3 дахь өдөр: Судлагдахуун бүрийн агуулга болон заах арга (Subject Content and Pedagogy), 4 дэх өдөр: Мэдээллийн технологи ашигласан багшлахуйн арга зүй, 5 дахь өдөр: Хичээлийн судалгаанд суурилсан багшлахуйн арга зүй, 6 дахь өдөр: “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” тухай, 7 дахь өдөр: Хичээлээс гадуурх сургалт (Музей, шүүх зэрэг байгууллагаар зочлон, хичээл явуулах).
- Сургалтын 2, 3 дахь өдөр, төслийн эхний шатанд боловсруулсан зөвлөмжийн агуулгын зарим хэсгийг ашигласан. 5 дахь өдрийн сургалтад, хичээлийн судалгаанд суурилсан багшлахуйн арга зүйн талаар танилцуулснаас гадна 7 дахь өдрийн агуулгад ч төслийн хүрээнд нилээд өмнөөс Монголын талд санал зөвлөгөө болгож ирсэн агуулга ч багтсан.

2.4 Хэтийн зорилго: “Бага болон дунд сургуулийн сурагчдын сурлагын амжилт дээшилсэн байна”

Хэтийн зорилго биелэлтийг тандах зорилгоор, Завхан аймгийн БСГ-аас 2011 онд аймгийнхаа 31 сургуульд зохион байгуулсан түвшин тогтоох шалгалтын үр дүнг загвар бус 25 сургууль болон загвар 6 сургуулиар харьцуулж үзсэн.

Шалгалтыг 5, 9, 11-р ангиас авсан бөгөөд бага ангид Монгол хэл, Математик /бага/, Англи хэл гэсэн 3 хичээл, дунд ангид Англи хэл, Хими, Биологи, Физик, Газар зүй, Түүх, Монгол хэл, Математик /суурь/ гэсэн 11 хичээлээр тухайн анги бүлгийн бүх сурагчдаас авсан.

Шалгалтын дүнг А, В, С, D болон F гэж ангилсан. А-аас D нь тэнцсэн, F нь тэнцээгүй гэсэн үнэлгээ юм. Загвар бус сургуулийн (25 сургууль) А авсан сурагчид 6.7%, АВ авсан сурагчид 15.1%, ABCD авсан сурагчид 43.8% байв. Харин, загвар сургуулийн А авсан сурагчид 6.3%, АВ авсан сурагчид 15.1%, ABCD авсан сурагчид 46% -ийг эзэлсэн. Загвар сургуулийн ABCD авсан сурагчдын тоо 2.2% -иар өндөр байсан бөгөөд энэ бол багшлахуйн арга зүйн хөгжил нь “Сурлагын хоцрогдол”-ыг багасгаж буйг илтгэж байх магадлалтай юм. Гэхдээ, энэ дүнгийн Т-тестээс үзэхэд, статистик үзүүлэлтийн хувьд чанарын ялгаа харагдаагүй.

БҮЛЭГ III ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1 ЭХНИЙ ЖИЛ (2010 оны 3 сар - 2011 оны 3 сар)

(1) Үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх төлөвлөгөөний талаар

Төслийн эхний хувилбарыг Япон болон Англи хэл дээр боловсруулсан.

(2) Төсөл хэрэгжүүлэх тогтолцоо буй болов

1) Төслийн эхний хувилбарыг танилцуулах, хэлэлцүүлэх

Дээр дурьдсанаар 2010 оны 4 сараас төслийн үйл ажиллагааг эхлүүлсэн ч, төслийн Япон мэргэжилтнүүдийг Монголд ирэх үеэр төслийн бодлогын зохицуулагч эрүүл мэндийн шалтгаанаар эзгүй байсны улмаас төслийн багийн ажиллах ажлын байр хараахан тодорхой болоогүй тул төслийг эхлүүлэх зохион байгуулалтын ажилд сар гаруйн хугацаа шаардагдсан.

Ингээд төслийн удирдагч, менежер, зохицуулагчид харилцан зөвлөлдөөд төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг санал нэгтэй батлав. Үүний дараа “Үндэсний баг” (Үндсэн баг) дээр сургалтын багц материал боловсруулах, сургалтын сургагч багшаар ажиллах ажлыг хариуцан гүйцэтгэх “Мэргэжлийн баг”-ийг байгуулсан болно.

2) Загвар аймаг, дүүрэг болон загвар сургуулиудыг сонгов

Загвар аймаг, дүүрэг сонгохтой холбогдуулан, төсөлд оролцох саналаа ирүүлэхийг хүссэн БСШУЯ-ны албан бичгийг 2010 оны 4 сарын 26-нд бүх аймаг, бүх дүүргийн БСГ/БХ-т илгээсэн. Хариу хүлээн авах эцсийн хугацаа буюу 5 сарын 7 хүртэлх хугацаанд саналаа ирүүлсэн 6 дүүрэг, 13 аймгаас тухайн орон нутгийн онцлог¹⁶ болон боловсон хүчний нөөц бололцоо зэргийг нь харгалзан сонголт хийж, Нийслэлийн СХД болон Булган, Завхан аймгуудыг загвар аймаг, дүүргээр сонгосон. Мөн оны 6 сарын 9-ний өдөр, БСШУЯ-ны Бага, дунд боловсролын газрын дарга төслийн загвар аймаг, дүүргийг сонгосон тухай албан бичгийг илгээсэн.

Багшлахуйн арга зүйн шинэчлэл болон хичээлийн судалгааг шаталсан хэлбэрээр түгээн дэлгэрүүлэх үүднээс зарчмын хувьд загвар аймаг, дүүргийн бүх бүс, тойргийн түшиц сургуулийг загвар сургуулиар сонгон авсан юм.

¹⁶ УБ хотыг тооцохгүйгээр Монгол Улсыг Зүүн, Баруун, Төв, Хангайн гэсэн 4 бүсэд хуваан авч үзсэн. Төслийн нэг дэх шатны загвар аймаг болох Сэлэнгэ, Дорнод аймгуудийн байршил нь Төв болон Зүүн бүсэд хамаарч байсан учир, төслийн хоёр дахь шатны загвар аймгийг Хангайн болон Баруун бүсээс сонгох нь зүйтэй хэмээн тооцсон.

Хүснэгт 3-1: Загвар сургуулиуд

СХД	Булган аймаг	Завхан аймаг
Ирээдүй ЦС 12-р сургууль 67-р сургууль	1-р сургууль Хишиг-Өндөр сумын сургууль Сэлэнгэ сумын сургууль Гурванбулаг сумын сургууль Хутаг-Өндөр сумын сургууль	Чандмань-Эрдэнэ ЦС Шилүүстэй сумын сургууль Сонгино сумын сургууль Баянтэс сумын сургууль Тосонцэнгэл сумын 1-р сургууль Завханмандал сумын сургууль

2010 оны 9 сард, төслийн баг загвар аймаг, дүүргийн БСГ/БХ болон нижгээд тооны загвар сургуулиудаар зочлон төслийн тухай танилцуулснаас гадна загвар аймаг, дүүрэг, загвар сургуулийн үүрэг оролцоо болон цаашдын үйл ажиллагааны талаарх танилцуулга хийв.


(3) Японд сургалт зохион байгуулав

2010 оны 10 сарын 4-15-нд (Японд ирэх: 3/Х, буцах: 16/Х), мэргэжлийн багийн 8 гишүүнд (БШУЯ-ны мэргэжилтэн 1, Боловсролын хүрээлэнгийн 1 судлаач, Арга зүйн хөгжлийн 4 төв17-ийн нийт 5 хүн, НБГ-ын 1 мэргэжилтэн) зориулан Японд сургалт зохион байгуулав. Энэхүү сургалтаар Японы одоо ажиллаж байгаа багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын бүтэц тогтолцоо болон хичээлийн судалгааны хийх аргачлалын талаарх ойлголтыг нь гүнзгийрүүлэн, багш нарыг давтан сургах, хичээлийн судалгааг хэвшүүлэх, тогтмолжуулахад хандлагыг бий болгох явдлыг зорилго болгосон.

Сургалт хөтөлбөрөөс оролцогчдын хамгийн ихээр сонирхлоо илэрхийлсэн зүйл нь Токио Гакүгэй их сургуулийн харьяа Сэтагаяа бага сургуулийн сургуульд суурилсан хичээлийн судалгаа хэлэлцүүлэгтэй танилцсан явдал байв. БСШУЯ-ны мэргэжилтэн болон мэргэжлийн багийн цөм гишүүд “Хичээлийн судалгааны бодит байдал”-ыг нүдээр үзэж танилцсан нь цаашид Монголд сургуульд суурилсан хичээлийн судалгаа хийхэд дэмжлэг болж өгсөн.

Мөн, Фүчюү хотын Фүчюү 3-р бага сургуулийн менежментийн төлөвлөгөөнд хэд хэдэн оролцогч сонирхлоо илтгэж байсан. Сургуулийнхаа зорилтыг дунд болон богино хугацааны менежментийн зорилт болгон бодитжуулсан байдал, тэдгээрт тохирсон үйл ажиллагаа нь тодорхой харагдаж буй байдал, ээлжит хичээлийн хөтөлбөрүүдэд ч зорилтоо тусгасан байдал нь тодорхой бус зорилт дэвшүүлэх хандлагатай Монголын сургуулиудаас эрс ялгаатай байгааг оролцогчид өөрсдийн биеэр олж мэдсэн юм. Энэ талаар “Багшийн хөгжил: Хичээлийн судалгаанд удирдлагын үүрэг оролцоо” модульд дараах маягаар бичжээ.

¹⁷ МУБИС-ийг түшиглэн байгуулагдсан Бага боловсролын арга зүйн хөгжлийн төв, Математикийн боловсролын арга зүйн хөгжлийн төв, Мэдээлэл зүйн боловсролын арга зүйн хөгжлийн төв болон МУИС-ийг түшиглэн байгуулагдсан Байгалийн ухааны боловсролын арга зүйн хөгжлийн төв.



Зураг 3: Сургуулийн зорилго, зорилт

Дээрх зураг нь Японы бага сургуулийн зорилго, зорилтын жишээ юм. Үүнээс, сургуулийн зорилго, зорилт нь хэд хэдэн мэдээллийн эх сурвалжид үндэслэсний зэрэгцээ нийтлэг бөгөөд тодорхой байгааг харж болно.

Зорилго, зорилт нь хэрэгжүүлэх боломжтой, хэмжих боломжтой, тодорхой чадваруудыг тусгасан зэрэг хэд хэдэн зарчимтай байна. Энэ өнцгөөс дараах 3 сургуулийн зорилтыг харьцуулж үзэхийг хүсье.

...Монголын сургууль болон Японы сургуулийн зорилтыг харьцуулах хүснэгт оруулав.

Энэ мэтчилэн, сургалтад оролцогчид Япон дахь сургалтаар дамжуулан сурч мэдсэн зүйлээ сургалтын багц материал боловсруулах болон загвар аймаг, дүүргийн багт зориулсан багшлахуйн арга зүйн сургалт зохион байгуулах зэрэгт ашигласан юм.

(4) Үр дүн 1-тэй холбоотой үйл ажиллагаа: “Бүх аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх багийн ур чадвар дээшилнэ”

1) Сургалтын багц материал боловсруулав

“Бүх аймаг, дүүргийн БСГ/БХ нь хуучин багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоогоо ашиглан, багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” гэсэн төслийн зорилгыг биелүүлэхийн тулд багшийн мэргэжил дээшлүүлэх бүхий л сургалтад ашиглах боломжтой сургалтын материал буюу сургалтын багц материалыг боловсруулсан. Сургалтын багц материал нь дараах хүснэгтэд үзүүлсэнчлэн нижгээд тооны модулиас бүрдэнэ. Эхний жил, төслийн зорилтот 8 хичээл бүрээр багшийн модуль, удирдлагын модуль, багшлахуйн арга зүйг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, мониторинг хийх тухай менежментийн модуль боловсруулахаар төлөвлөсөн.

Мэргэжлийн багийн гишүүд сургалтын багц материалыг боловсруулан, эхний

хувилбарыг 2010 оны 11 сарын зохион байгуулсан загвар аймаг, дүүргийн багт зориулсан багшлахуйн арга зүйн сургалтад туршсан. Тэр үеийн сургалтын багц материалын бүтцийг доорх хүснэгтэд дурьдав. Багууд турших ажлын үр дүнг тусгасан эхийг 2010 оны 12 сарын 24-ны дотор төслийн багт ирүүлсэн бөгөөд БШУЯ-наас томилогдсон экспертизийн баг экспертиз хийсэн.

Хүснэгт 3-2: Эхний жилийн сургалтын багц материалын бүтэц

№	Модуль	Боловсруулсан баг	Тайлбар
1	Багшийн модуль	Физик	Физикийн баг
2		Хими	Химийн баг
3		Хүн орчин	Хүн орчин баг
4		Хүн байгаль	Хүн байгаль баг
5		Математик /бага/	Математикийн баг /бага/
6		Математик /суурь/	Математикийн баг /суурь/
7		Мэдээлэл зүй	Мэдээлэл зүйн баг
8		Төсөлт ажил	Төсөлт ажил баг
9	Удирдлагын модуль	Удирдлага менежментийн баг	Тус бүр 10 хэвлэлийн хуудас ¹⁸ бичихээр төлөвлөсөн. Үүний 2 хэвлэлийн хуудас нь бүх судлагдахуунд хамаарах суралцагчдын суралцахуйг дэмжсэн багшлах арга зүй, хичээлийн судалгааны тухай тайлбар юм.
10	Менежментийн модуль	Мониторингийн баг, бусад	
			20 хэвлэлийн хуудас байхаар тооцсон. Арга зүйгээ хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, мониторинг хийх гэсэн агуулгуудыг багтаасан. Эхний жил, зөвхөн мониторингтой холбоотой хэсгийг ирүүлсэн.

2) Мэргэжлийн баг загвар аймаг, дүүргийн багт зориулан арга зүйн сургалт зохион байгуулав

Боловсруулагдаж буй сургалтын багц материалыг ашиглан 2010 оны 11 сард, загвар аймаг, дүүргийн багт зориулсан багшлахуйн арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Тав хоногийн сургалтын хөтөлбөрыг дараах байдлаар танилцуулъя. Энэхүү сургалтын хөтөлбөр нь төслийн хүрээнд хэрэгжүүлэх багшлахуйн арга зүйн шинэчлэлийн сургалтын жишиг хөтөлбөр болсон.

- Эхний өдөр: Боловсролын стандарт болон суралцахуйд суурилсан багшлах арга зүйн тухай лекц (Нийт оролцогчдод зориулсан)
- 2-3 дахь өдөр: Суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны тухай лекц болон дадлага ажил (Бүх судлагдахуунаар), бүх байгууллагууд хичээлийн судалгааг хэрхэн зохион байгуулах тухай лекц, дадлага ажил (Удирдлагад зориулсан)
- 4 дэх өдөр: 2-3 дахь өдөр боловсруулсан хичээлийн хөтөлбөрийг ашиглан зохион байгуулсан судалгаат хичээл ба хэлэлцүүлэг, хичээлийн хөтөлбөр сайжруулалт (Бүх судлагдахуунаар)
- 5 дахь өдөр: Байгууллага тус бүрээр хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулах ажил

Анх оролцогчдыг Улаанбаатар хотод цуглуулан зохион байгуулахаар төлөвлөсөн

¹⁸ 1 хэвлэлийн хуудас А4-ийн хэмжээтэй 8 хуудастай тэнцэнэ.

байсан боловч, загвар аймаг, дүүрэг дэх багшлахуйн арга зүйн шинэчлэлийг нэн даруй хэрэгжүүлж эхлэхийн тулд тухайн бүсээс нэг ч атугай олон оролцогч хамруулах, бүсийн онцлогт тохируулан сургалтаа зохион байгуулах явдал чухал хэмээн үзсэн учир СХД, Булган, Завхан аймаг тус бүрд сургалтаа зохион байгуулсан юм.

Гурван газарт хэрхэн чанартай сургалт зохион байгуулах вэ гэсэн асуудал тулгамдаж байсан. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор эхлээд СХД-т сургалт зохион байгуулж, бусад 2 аймагт сургагч багшаар ажиллахаар төлөвлөсөн хүмүүсийг хөндлөнгийн ажиглагчаар оролцуулан, сургалтын талаарх ойлголтыг нь нэгтгэхийг зорьсон. Эхний сургалтыг сурагчдын улирлын амралтын өмнө зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд нилээд томоохон хэмжээний сургууль дээр явуулах байсан тул зохицуулалт хийх боломжтой байв. Нэг талаас, Булган болон Завхан аймаг дахь сургалтыг сурагчдын амралтаар зохион байгуулах төлөвлөгөөтэй байсан боловч, 10 жилд 1 удаа явагддаг нийт хүн амын тооллоготой давхцсанаар сургалтын хөтөлбөр батлуулах ажилд хүндрэл учирсан¹⁹. Гэвч БШУЯ болон дээрх 2 аймгийн БСГ-уудтай хэдэнтээ зөвлөлдсөний эцэст сургалтын хөтөлбөрийг батлуулсан.

Оролцогчдын тухайд, сургуулийн 3 удирдах ажилтан (Захирал, бага, дундын сургалтын менежер тус бүр 1 хүн) болон төсөл зорилтот 8 судлагдахуун бүрээс тус бүр 1 хүн, нийт 11 хүнийг 1 баг болгон авч үзсэн. БСГ/БХ-г хандан тухайн загвар аймаг, дүүрэг дэх багшлахуйн арга зүйн шинэчлэлийг хариуцан ажиллах “Аймаг, дүүргийн баг”-аа бүрдүүлэх хүсэлт тавьсан. Гэвч, БСГ/БХ-үүд мэргэжилтний тоо хүрэхгүй, нэг мэргэжилтэн хэд хэдэн судлагдахуун давхар хариуцдаг тул зөвхөн мэргэжилтнүүдэд 8 судлагдахууныг хариуцуулах боломжгүй болсон. Иймд, мэргэжилтний тоо хүрэлцээгүй судлагдахууныг тухайн бүсийн шилдэг сайн багш нарт даалгахаар болов.

Бүх сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулсан газар, сургагч багш, оролцогчдын талаарх мэдээллийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3-3: Нийслэлийн СХД дэх сургалт

Хөтөлбөр	2010 оны 11 сарын 1-5	
Зохион байгуулсан газар	Ирээдүй ЦС-ийн 1-р ахлах сургууль, 2-р ахлах сургууль	
Сургагч багш	Мэргэжлийн баг: Нийт 63 хүн	
Оролцогч	Нийт 84 хүн	
	НБГ	НБГ: 7 хүн, загвар бус дүүргийн БХ: 1 хүн, загвар бус дүүрэг сургуулийн төлөөлөл: 13 хүн
	СХД-ийн БХ (дүүргийн баг)	БХ-ийн мэргэжилтэн: 2 хүн, сургуулийн төлөөлөл: 8 хүн
	Ирээдүй ЦС ²⁰	Сургуулийн захирал: 5 хүн, Сургалтын менежер: 5 хүн,

¹⁹ Монгол Улсад хүн амын тооллого, парламентын сонгууль зохион байгуулах ажилд ЕБС-ийн багш нар дайчлагдан ажилладаг бөгөөд хүн амын тооллого болон сонгуулийн үеэр олон нийтийг хамруулсан аливаа үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглодог байна.

²⁰ Ирээдүй ЦС нь дотроо 3 бага, 2 дунд, 2 ахлах сургуультай учир бусад сургуулиудаас илүү олон

		Багш: 8 судлагдахуун х 2 хүн
	12-р сургууль	Сургуулийн захирал: 1 хүн, Сургалтын менежер: 2 хүн, Багш: 8 судлагдахуун х 1 хүн
	67-р сургууль	Сургуулийн захирал: 1 хүн, Сургалтын менежер: 2 хүн, Багш: 8 судлагдахуун х 1 хүн
	Бусад	Дорнод дээд сургууль: 1 хүн, Сэлэнгэ аймаг 4-р сургууль: 1 хүн, Оюуны ирээдүй ЦС: 1 хүн, Японы залуу сайн дурын гишүүн: 2 хүн

Хүснэгт 3-4: Булган аймаг дахь сургалт

Хөтөлбөр	2010 оны 11 сарын 12-16	
Зохион байгуулсан газар	Булган аймгийн 1-р сургууль	
Сургагч багш	Мэргэжлийн баг: нийт 18 хүн	
Оролцогч	Нийт 70 хүн	
	Булган аймгийн БСГ (Аймгийн баг)	БСГ: 10, сургуулийн төлөөлөл: 3
	1-р сургууль	Сургуулийн захирал: 1, Сургалтын менежер: 2, Багш: 8 судлагдахуун х 1
	Хишиг-Өндөр сумын сургууль	Сургуулийн захирал: 1, Сургалтын менежер: 1, Багш: 8 судлагдахуун х 1
	Сэлэнгэ сумын сургууль	Сургуулийн захирал: 1, Сургалтын менежер: 2, Багш: 8 судлагдахуун х 1
	Гурванбулаг сумын сургууль	Сургуулийн захирал: 1, Сургалтын менежер: 2, Багш: 8 судлагдахуун х 1
	Хутаг-Өндөрсумын сургууль	Сургуулийн захирал: 1, Сургалтын менежер: 2, Багш: 8 судлагдахуун х 1
	Бусад	МУБИС-ийн харъяа Архангай аймгийн багшийн сургууль: 1, Эрдмийн өргөө ЦС: 2

Хүснэгт 3-5: Завхан аймаг дахь сургалт

Хөтөлбөр	2010 оны 11 сарын 19-23	
Зохион байгуулсан газар	Завхан аймгийн Чандмань-Эрдэнэ ЦС	
Сургагч багш	Мэргэжлийн баг: Нийт 23 хүн	
Оролцогч	Нийт 116 хүн	
	Завхан аймгийн БСГ ²¹ (аймгийн баг)	БСГ: 9 хүн, сургуулийн төлөөлөл: 8 хүн
	Чандмань-Эрдэнэ ЦС	Сургуулийн захирал: 1, Сургалтын менежер: 2, Багш: 8 судлагдахуун х 1
	Шилүүстэй сумын сургууль	Сургуулийн захирал: 1, Сургалтын менежер: 1, Багш: 8 судлагдахуун х 1
	Сонгино сумын сургууль	Сургуулийн захирал: 1, Сургалтын менежер: 1, Багш: 8 судлагдахуун х 1 + 1 (Төсөлт ажил)
	Баянтэс сумын сургууль	Сургуулийн захирал: 1, Сургалтын менежер: 1, Багш: 7 судлагдахуун (Мэдээлэл зүйгээс бусад) х 1
	Тосонцэнгэл сумын 1-р сургууль	Сургуулийн захирал: 1, Сургалтын менежер: 3, Багш: 8 судлагдахуун х 1 + 1 (Төсөлт ажил)

оролцогчийг сургалтад хамруулсан.

²¹ Төслийн зорилтот бус судлагдахуун хариуцдаг мэргэжилтнүүдээ ч төсөлд идэвхтэй оролцуулахыг хүссэн БСГ-ын хүсэлтэд үндэслэн олон оролцогч сургалтад хамруулсан.

	Завханмандал сумын сургууль	Сургуулийн захирал: 1, ЗАН: 1, Багш: 8 судлагдахуун х 1
	Бусад	Баян-Өлгий аймгаас 8, Улиастай хотоос 27

Бүх БСГ/БХ болон сургалт явуулсан сургуулиуд бүх талын туслалцаа үзүүлэн ажилласны дүнд, сургалтуудыг амжилттай зохион байгуулсан. Гэвч, СХД дэх сургалтын үед сургагч багш нар болон хөндлөнгийн ажиглагчид орж гарах хөдөлгөөн их, бага зэрэг замбараа муутай байв. Харин, Булган болон Завхан аймаг дахь сургалтын хувьд, оролцогчид дотуур байранд байрлаж байсан тул, үдэш бүр сургагч багш нарын уулзалтыг зохион байгуулах боломжтойгоос гадна сургалт явуулсан сургуулийн санаачлагаар оролцогчдын дунд олон нийтийн үйл ажиллагаа ч зохион байгуулагдаж байлаа.

2011 оны 2-3 сард, хэд хэдэн загвар сургууль дээр эдгээр сургалтад оролцсон “Сургуулийн баг” голлон эхний хичээлийн судалгааг зохион байгуулсан. Уг “Сургуулийн баг”-ийг ур чадвар, санаачлага өндөртэй багш нараар бүрдүүлсэн тул, зарим үед бүрэлдэхүүнд бага зэрэг өөрчлөлт орж байсан хэдий ч төслийн хугацаанд эрчимтэй үйл ажиллагаа явуулсан. Харин, эдгээр багш нар болон сургалтад оролцож байгаагүй багш нарын хооронд ялгаа гарч байсан нь сургууль нийтийн багшлахуйн арга зүйн хөгжилд саад болж байсан. Иймд, төслийн хоёр дахь жилээс эхлэн ихэнх сургуулиуд бүх багш нараа төслийн зорилтот 8 хичээлийн багт хуваан, судалгаат хичээл зохион байгуулахын зэрэгцээ төслийн баг ч бүх “Аймаг, дүүргийн баг”-г зориулсан сургалтад эхний жилийнхээс өөр оролцогчдыг хамруулсан.

Нөгөөтэйгүүр, БСГ-ыг түшиглэн бүрдсэн загвар аймаг, дүүргийн багийн үйл ажиллагаа бүс бүрээр харилцан адилгүй байсан. Хамгийн сайн ажилласан баг бол хэд хэдэн мэргэжилтнийг багтаасан Завхан аймгийн баг байв. БСГ нь үүрэг оролцоогоо сайтар ухам сарлан, аймагтаа багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэхэд идэвхтэй оролцох болсон. Харин, СХД-ийн багийн хувьд тус дүүргийн БХ хүчин чадал багатай учир, дүүргийнхээ нилээд хэдэн сургуулийн багш нараас гишүүд бүрдүүлсэн. Үүний улмаас, сургалтын дараа хамтран ажиллахад төвөгтэй байснаас “Дүүргийн баг” гэдэг утгаар үйл ажиллагаа явуулаагүй юм. Хоёр дахь жилийн бүх “Аймаг, дүүргийн баг”-г зориулсан сургалтаар тус дүүргийн баг дээр нэмээд НБГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг сургагч багшаар ажиллуулах тухай хүсэлт гаргасан.

3) Мэргэжлийн багаас бүх “Аймаг, дүүргийн баг”-г зориулсан технологийн дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын тухай

Эхний жилд мэргэжлийн баг болон төслийн багаас аль болох олон хүнд суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааг танилцуулах зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Хүснэгт 3-6: Бүх аймаг, дүүрэгт үзүүлсэн технологийн дэмжлэг

Огноо	Үйл ажиллагааны нэр	Зохион байгуулагч (байр)	Зорилтот бүлэг	Дэмжлэгийн агуулга
2010 он				
3/V	Лекц	НБГ	Тус БСГ-ын мэргэжилтэн	Төслийн мэргэжилтэн Японы боловсролын тогтолцооны талаар лекц уншив.
9-11/XII	Хичээлийн судалгааны сургалт	Сэлэнгэ аймгийн БСГ (1-р сургууль)	Тус аймгийн сургалтын менежерүүд	Тус сургалтын үеэр төслийн мэргэжилтэн төслийн болон Японы хичээлийн судалгааны жишээнээс танилцуулав.
13-14/XII	Хичээлийн судалгааны сургалт	БГД-ийн 2-р сургууль	Тус сургууль болон зэргэлдээ 5 сургуулийн багш 40 орчим хүн	Мэргэжлийн баг болон төслийн мэргэжилтэн сургагч багшаар ажиллав.
18/XII	Бага ангийн Математикийн хэлэлцүүлэг	МУБИС	Багш бэлтгэдэг их сургуулийн төлөөлөл: Ойролцоогоор 50 хүн	Төслийн мэргэжилтэн төсөл болон хичээлийн судалгааны талаар танилцуулав.
2011 он				
7/III	Хичээлийн судалгааны уулзалт	Сэлэнгэ аймгийн БСГ (2-р сургууль)	Тус аймгийн төвийн (Сүхбаатар хот) багш нар	Төслийн мэргэжилтэн Физик, Хүн орчин, Бага ангийн Математик, Нийгмийн судалгаат хичээл, хэлэлцүүлэгт оролцов. Хичээлийн судалгааг түгээн дэлгэрүүлэх зөвлөгөө өгөв.

(5) Үр дүн 2-той холбоотой үйл ажиллагаа: “Загвар аймаг, дүүрэгт хичээлийн судалгааны загвар бий болно”

1) Загвар аймаг, дүүргийн хичээлийн судалгааны төлөвлөгөө боловсруулах, зохион байгуулах

Загвар аймаг, дүүргийн багт зориулсан багшлахуйн арга зүйн сургалтын (2010 оны 11 сар) тав дахь өдөр, БСГ болон загвар сургуулиуд хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан. Сургалтын дараа, өөрийн нөхцөл байдалдаа нийцүүлэн засвар өөрчлөлт оруулсан ба төслийн багаас өгсөн зөвлөгөөг тусган төлөвлөгөөгөө сайжруулсан.

Бүх загвар сургуулиуд дээрх төлөвлөгөөндөө тулгуурлан 2011 оны 1 сараас хичээлийн судалгаа зохион байгуулсан.

2) Мэргэжлийн баг, загвар сургуулиудын хичээлийн судалгаанд мониторинг хийв

Загвар сургуулиуд дахь арга зүйн шинэчлэлийн байдалтай танилцахын хамт холбогдох хүмүүст зөвлөгөө өгөх зорилгоор хичээлийн судалгааны мониторинг зохион байгуулсан.

СХД-ийн хувьд, сургуулиудаас ирүүлсэн судалгаат хичээл заах графикт нийцүүлэн

мэргэжлийн баг болон төслийн багийн гишүүд загвар сургуулиудад очиж ажиллан, сургууль бүр дээр зорилтот 8 судлагдахууны хичээлүүдэд тус бүр 1 удаа мониторинг хийхээр зохион байгуулсан. Загвар 2 аймгийн хувьд, зам болон цаг хугацаагаа харгалзсаны үндсэн дээр тухайн аймгийн загвар сургуулиудыг 2 хэсэгт хуваан тус бүр 4 судлагдахуунаар судалгаат хичээл зохион байгуулахаар төлөвлөж, тухайн судлагдахуунуудыг хариуцсан мэргэжлийн багийн гишүүд болон төслийн багийнхан 2 багт хуваагдан мониторинг хийсэн. Түүнчлэн, Завхан аймгийн төвөөс 300 орчим км-ийн зайтай орших Баянтэс сумын сургууль руу өвлийн улиралд очиход зам харилцаа хүндрэлтэй байсны улмаас энэ удаад очоогүй юм.

Хүснэгт 3-7: Хичээлийн судалгааны анхны мониторингийн товч танилцуулга /2011/

Загвар аймаг, дүүрэг	Хөтөлбөр	Баг 1		Баг 2	
СХД	14/II-11/III	Сургууль бүр 8 судлагдахуунаар тус бүр 1 удаа			
Булган	27/II-5/III	1-р сургууль, Хутаг-Өндөр, Сэлэнгэ	Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Мэдээлэл зүй, Төсөлт ажил, Удирдлага	Гурванбулаг, Хишиг-Өндөр, 1-р сургууль	Физик, Хими, Хүн орчин, Хүн байгаль
Завхан	19-26/II	Тосонцэнгэл, Сонгино, Чандмань-Эрдэнэ	Хими, Хүн орчин, Хүн байгаль, Төсөлт ажил	Шилүүстэй, Чандмань-эрдэнэ Завханмандал	Физик, Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Мэдээлэл зүй, Удирдлага

Загвар 2 аймагт хийсэн мониторингийн хугацаанд, мэргэжлийн баг болон хамт явсан төслийн багийн гишүүн зөвхөн судалгаат хичээл, хэлэлцүүлэгт оролцсон төдийгүй, хичээлийн судалгааны тухай лекц уншсан.

Бүх багтай хамт явсан тухайн аймгийн БСГ-ын мэргэжилтнүүдэд технологи шилжүүлсэн. Мөн, уг мониторингоор багшлахуйн арга зүй түгээн дэлгэрүүлэх мэргэжилтний зүгээс мэргэжлийн багийн гишүүдэд технологи шилжүүлэх боломж ч олгосон юм. Үдэш бүр тухайн өдрийн судалгаат хичээлүүдийн талаар санал бодлоо солилцож байв. Энэ үед, төслийн эхний шатанд зөвлөмж боловсруулахад туршигч багшаар ажилласан нэгэн гишүүн “Төслийн эхний шатанд нойргүй хонон байж бэлтгэсэн судалгаат хичээлийг маань бүгд шүүмжлэхэд их хэцүү байж билээ. Мэргэжлийн багт их дээд сургуулийн багш нар ч олон, судалгаат хичээл зааж байгаагүй багш нар ч цөөнгүй байсан. Судалгаат хичээл заах багш нар шүүмжлүүлж магад гэсэн айдсаа даван туулж, арга зүйн хөгжилд хувь нэмрээ оруулж байна гэсэн бодлоор хэлэлцүүлэгт орох нь зүйтэй” хэмээн саналаа хэлсэн. Энэ мэтчилэн, мэргэжлийн багийн гишүүд хичээлийн судалгааны мониторинг нь “Багш үнэлэх боломж” бус, “Багшийг дэмжих боломж” гэдгийг ойлгож ухам сарласан юм.

Мөн, хамт явсан БСГ-ын мэргэжилтнүүд ч судалгаат хичээл, хэлэлцүүлэг, лекц, оройн уулзалтад оролцох үедээ, мониторинг бол суралцах боломж гэдгийг ойлгож мэдсэн билээ. Аймгийн сургуулиудын байршил хол тул мэргэжилтнүүдийн сургуулиуд дээр очиж ажиллах боломж нь хязгаарлагдмал байдаг. Мониторингийг нэг чухал боломж хэмээн хүлээн авах болсноор мониторингт хамт явахыг хүсэгчид олширсон билээ.

(6) Үр дүн 4-тэй холбоотой үйл ажиллагаа: “Багш бэлтгэдэг их сургуулиудад суралцахууд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх, хэвшүүлэхэд чиглэсэн орчин боловсронгуй болно”

1) Багш бэлтгэдэг их сургуулийн төлөөлөлд сургалтын багц материалыг танилцуулав

2010 оны 9 сарын 23-нд МУБИС-ийн захирал Б.Жадамбаатай уулзан, төслийн үйл ажиллагаа болон сургалтын багц материалын талаар товч танилцуулга хийсэн.

2) БСШУЯ-ны 2010-2011 оны хичээлийн жилийн зорилгод “Хичээлийн судалгаа” тусгагдав

БСШУЯ-ны 2010-2011 оны хичээлийн жилийн зорилгод, “Бүх багш хичээлийн судалгааны арга зүйд суралцахын зэрэгцээ бүх сургуулиуд хичээлийн судалгаа хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан, энэ хичээлийн жилд 2-оос доошгүй удаа хичээлийн судалгаа хийсэн байх” гэж заасан.

3.2 ХОЁР ДАХЬ ЖИЛ (2011 оны 4 сар - 2011 оны 12 сар)

(1) Японд сургалт зохион байгуулав

Үр дүн 2, 3-ыг биелүүлэх зорилгоор, загвар аймаг, дүүргийн БСГ/БХ-ийн мэргэжилтэн, загвар сургууль холбогдох хүмүүсийг суралцахууд суурилсан багшлах арга зүйд туршлагажуулах нь чухал хэмээн үзэж, 2011 оны 9 сарын 26-наас 10 сарын 7-нд (Японд очсон: 25/IX, Нутаг буцсан: 8/X) эдгээр холбогдох хүмүүст зориулан Япон дахь сургалт зохион байгуулсан. БСГ/БХ-ийн мэргэжилтнүүдийн (1) Суралцахууд суурилсан багшлах арга зүй болон (2) Японы багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцооны (Боловсролын хороо, их дээд сургуулиуд, ЕБС-ийн зохион байгуулдаг сургалт) талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, сургалтын менежер, багш нарын (1) Суралцахууд суурилсан багшлах арга зүй болон (2) Японы сургуульд суурилсан хичээлийн судалгааны талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх зорилгоор Японд сургалтыг зохион байгуулсан.

Уг сургалтын үеэр Токио хот болон Нагано мужийн бага, дунд, ахлах сургуулиуд, улсын болон хувийн сургуулиудаар зочлон, хичээлтэй танилцсан. Нээлттэй хичээлийн судалгааны өдөрлөгт оролцох боломж олдоогүй ч, зочилсон сургуулийн удирдлагын зүгээс сургуульд суурилсан хичээлийн судалгааныхаа талаар дэлгэрэнгүй тайлбар өгч,

Монголын сургуулиудад хичээлийн судалгааг хэрхэн хийж болох тухай санаа өгсөн юм.

Мөн, самбар төлөвлөлтийн тухай лекцийг оролцогчид ихэд сонирхож байсан бөгөөд энэ явдлаас хойш загвар сургуулиуд самбар төлөвлөлтийг сургуульд суурилсан хичээлийн судалгааныхаа сэдэв болгох болсон юм. Самбар төлөвлөлт нь арга зүйн төлөвлөлт, багш хүүхдийн харилцаатай гүн гүнзгий холбоотой байдаг учир, багшлахуйн арга зүйн хөгжилд зайлшгүй шаардагатай хүчин зүйлийн нэг болдог. Мөн, үр дүн, сайжирсан байдал нь самбар дээр шууд илэрхийлэгдэх учир үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлэхэд дөхөм байсан болов уу.

Загвар сургуулиас оролцсон оролцогчдын 3 нь сургалтын менежер байсан бөгөөд тэдний ажилладаг сургуулийн багшлахуйн арга зүйн хөгжил илт идэвхжин, багшлахуйн арга зүйн хөгжлийн талаарх сургуулийн удирдлагын ойлголтыг дээшлүүлэхийн чухлыг бидэнд ойлгуулсан билээ. Тиймээс, гурав дахь жилийн Япон дахь сургалтыг загвар сургуулийн удирдлагад зориулан зохион байгуулахаар шийдвэрлэсэн юм.

(2) Үр дүн 1-тэй холбоотой үйл ажиллагаа: “Бүх аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх багийн ур чадвар дээшилнэ”

1) Сургалтын багц материалыг засан сайжруулав

Эхний жилийн загвар аймаг, дүүрэгт зохион байгуулсан хичээлийн судалгааны мониторингийн дүнд, БСШУЯ-наас томилсон экспертизийн баг болон төслийн багийн саналд үндэслэн сургалтын багц материалыг засан сайжруулсан. 2011 оны 6 сарын 13 болон 20-нд, бүх багийн төлөөлөл цуглан, сургалтын багц материалын бүтэц, модуль боловсруулсан бүх багийг дараах байдлаар дахин зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Хүснэгт 3-8: Сургалтын багц материалын бүтэц

№	Модуль	Боловсруулсан баг	Тайлбар	
1	Үндсэн модуль	Бүх судлагдахууны багийн төлөөлөл	Эхний хувилбарын үндсэн хэсгийг сайжруулан бие даасан модуль болгон боловсруулах.	
2	Багшийн модуль	Физик	Физикийн баг	
3		Хими	Химийн баг	
4		Хүн орчин	Хүн орчин баг	
5		Хүн байгаль	Хүн байгаль баг	
6		Бага ангийн Математик	Бага ангийн Математикийн баг	
7		Дунд ангийн Математик	Дунд ангийн Математикийн баг	
8		Мэдээлэл зүй	Мэдээлэл зүйн баг	
9	Төсөлт ажил	Төсөлт ажлын баг	Бүх хичээлийн онцлогийг тусгасан хүүхдийн хөгжлийг дэмжих багшлахуйн арга зүй болон хичээлийн судалгааны аргачлалын талаар нэгтгэн оруулах.	
10	Удирдлагын модуль	Удирдлага, менежментийн баг		Эхний жилд Удирдлагын баг, Менежментийн баг, Мониторингийн баг гэсэн байдлаар үйл ажиллагаа явуулж байсан 3 багийг нэгтгэж, БСГ болон сургуулийн удирдлагад зориулсан модуль боловсруулах.

Засвар оруулсан модулиудыг 11 сард зохион байгуулсан бүх “Аймаг, дүүргийн баг”-т

зориулсан сургалтын үеэр туршсаны дараа улам сайжруулж, БСШУЯ-нд хүлээлгэж өгөв. 12 сарын 5-нд БСШУЯ-ны зүгээс дахин засан сайжруулах тухай саналаа илэрхийлсэн.

2) Бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулан сургалт зохион байгуулав

2010 оны 11 сард зохион байгуулсан загвар аймаг, дүүргийн багт зориулсан багшлахуйн арга зүйн сургалтыг үргэлжлүүлэн бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтыг үндэсний хэмжээний 9 дүүрэг, 21 аймгийн суралцахуйд суурилсан багшлах арга зүй түгээн дэлгэрүүлэх цөм болох “Аймаг, дүүргийн баг”-ийг бэлтгэх зорилгоор зохион байгуулсан юм.

Энэхүү сургалтыг зохион байгуулахтай холбогдуулан, төслийн эхний шатны загвар аймгаар ажилласан Сэлэнгэ, Дорнод аймгийн дэмжлэгийг авч, Булган аймагт хангайн бүсийн 4 аймаг, Завхан аймагт баруун бүсийн 4 аймаг, Сэлэнгэ аймагт төвийн бүсийн 2 аймаг болон Дорноговь аймаг, Дорнод аймагт зүүн бүсийн 2 аймгийн “Аймгийн баг”-ийг урьж оролцуулахаар төлөвлөсөн. Нийслэлийн 9 дүүрэг болон үлдсэн 4 аймгийн хувьд СХД болон БЗД²²-т зохион байгуулах сургалтад оролцхыг хүссэн.

Хамгийн их тулгамдсан асуудал бол сургагч багшийн асуудал байв. Өмнөх жилийн сургалтыг 3 газарт зохион байгуулж байсан бол, энэ удаад 6 газарт зохион байгуулах болсонтой уялдан, 2010 оны загвар аймаг, дүүрэгт зориулсан багшлахуйн арга зүйн сургалтын нэгэн адил судлагдахуун тус бүрээр мэргэжлийн багийн 2 гишүүнийг бүх сургалтад томилон ажиллуулахад хүндрэл тулгарсан. Иймд, мэргэжлийн багийн гишүүдийг “Загвар аймгийн баг”-ийн гишүүдтэй хамтран сургагч багшаар ажиллуулах төлөвлөгөө гаргасан юм. Нийслэлийн хувьд СХД-ийн багийн гишүүдийг сургагч багшаар ажиллуулахаар төлөвлөж байсан боловч, дүүргийн БХ боловсон хүчний нөөц бололцоо багатай, арга зүйн дэмжлэг үзүүлэх хүчин чадал муутай болох нь тодорхой болсон тул, НБГ-ын мэргэжилтэн болон хотын түвшний сургагч багшийн зэрэгтэй багш нарыг сургагч багшаар урин ажиллуулахаар болсон.

Сургагч багшийн тоог нэмэгдүүлэх, 2010 оны загвар аймаг, дүүрэгт зориулсан багшлахуйн арга зүйн сургалтын дүгнэлтэд үндэслэн сургагч багш нарын багийн чанарыг дээшлүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

- 2011 оны 6 сарын 2-4-нд зохион байгуулсан “Хичээлийн судалгааны тайлангийн хурал” (хойно дурьдах) семинарын үеэр загвар аймаг, дүүргийн багийн гишүүдийн “Хичээл ажиглах нүд”-ийг нь хөгжүүлэх зорилгоор, төслийн эхний шатны загвар сургуулиуд дээр судалгаат хичээл зохион байгуулав.
- 2011 оны 10 сарын 21-22-нд “Сургагч багшийн сургалт”-ыг зохион байгуулав.

Оролцогчид болон загвар сургуулийн тухайд зарчмын хувьд сургуулийн захирал,

²² НБГ-аас танилцуулсны дагуу дотуур байр бүхий БЗД-ийн 85-р сургууль дээр орон нутгийн оролцогчдыг хүлээн авсан.

бага болон дунд ангийн сургалтын менежер тус бүр 1, 2010 оны сургалтад оролцоогүй 8 багш (Төслийн зорилтот судлагдахууны мэргэжлийн), нийт 11 хүнийг 1 баг болгосон. Өмнөх жилийн сургалтад хамрагдсан болон хамрагдаагүй багш нарын хооронд багшлахуйн арга зүйн хөгжлийн талаарх ойлголтын зөрүү загвар сургуулиуд дээр ажиглагдаж буй тухай тайланд дурьдагдсан тул, 2, Гурав дахь жилийн сургалтад шинэ оролцогчдыг хамруулан, загвар сургуулиуд дахь багшлахуйн арга зүйн хөгжлийн цөмийг бага ч атугай тэлэх нь зүйтэй гэж үзсэн.

Нөгөө талаас, загвар бус “Аймаг, дүүргийн баг”-ийн хувьд, зөвхөн БСГ-ын дарга, мэргэжилтнүүд 8 судлагдахууныг бүрэн хамарч чадахгүй тохиолдолд, шилдэг тэргүүний багш нараа оролцуулах хүсэлт тавьсан. Мөн, БСГ-ын дарга нарын оролцоо нь аймаг, дүүрэг бүрээр харилцан адилгүй байв. Мөн, жирийн багшийг “Аймаг, дүүргийн баг”-ийн гишүүн болголоо ч бодит амьдрал дээр аймаг, дүүрэгтээ манлайлах үүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй гэсэн саналууд ч сургалтын үеэр гарч байлаа.

Бүх сургалтын хуваарь, сургагч багш, оролцогчдын тоог дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3-9: Сургалтын товч танилцуулга /2011 он/

№	Хөтөлбөр	Зохион байгуулсан газар	Сургагч багш	Оролцогч	Оролцогчид (Хөндлөнгийн ажиглагчдыг багтаана)
1	1-5/XI	СХД-ийн Ирээдүй ЦС	34	124	НБГ, СХД (СХД-ийн баг, Ирээдүй ЦС, 12-р сургууль, 67-р сургууль), ХУД, БЗД, ЧД, БГД, СБД, МУБИС, ЖАЙКА-гийн сайн дурын гишүүн
2	10-14/XI	БЗД-ийн 85-р сургууль	24	97	Багануур, Налайх, Багахангай дүүрэг, 85-р сургууль, Говьсүмбэр, Төв, Өмнөговь, Дорноговь аймаг болон Монгол хэл, Нийгмийн ухааны баг ²³
3	11-15/XI	Булган аймгийн 1-р сургууль	20	3	Булган аймаг (БГ, 1-р сургууль, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Гурванбулаг, Сэлэнгэ сумын сургууль), Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор аймаг, ²⁴
4	11-15/XI	Завхан аймгийн Чандмань-Эрдэнэ ЦС	20	104	Завхан аймаг (БГ, Чандмань-Эрдэнэ ЦС, Сонгино, Шилүүстэй, Баянтэс, Завханмандал сумын сургууль,

²³ 2011 оны 11 сарын 7-ны өдрийн БСШУ-ны Сайдын 428 тоот тушаалаар Монгол хэл, Нийгмийн ухааны хичээлийн мэргэжлийн багийг байгуулсан. БСШУЯ, эдгээр багуудад хандан хүмүүнлэг, нийгмийн ухааны чиглэлийн судлагдахууны хувьд чухам ямар хэлбэрээр арга зүйн шинэчлэлийг хэрэгжүүлбэл зохих талаар судлах үүрэг өгсөн.

²⁴ Зөвхөн Архангай аймгийн баг сургалтад оролцохоор явах замдаа осолд орсны улмаас, сургалтад оролцож чадаагүй. Иймд, 2013 оны 3 сарын 15-17-нд Архангай аймгийн баг болон МУБИС-ийн Архангай аймаг дахь салбар сургуульд зорилусан сургалтыг жич зохион байгуулсан.

					Тосонцэнгэл сумын 1-р сургууль), Говь-Алтай, Ховд, Увс, Баян-Өлгий аймаг
5	11-15/XI	Дорнод аймгийн Хан-Уул ЦС	21	86	Дорнод аймаг (БГ, Чойбалсан баг, Хан-Уул ЦС, Баян-Уул, Дашбалбар сумын сургууль), Хэнтий, Сүхбаатар аймаг
6	12-16/XI	Сэлэнгэ аймгийн 1-р сургууль	20	91	Сэлэнгэ аймаг (БГ, Сүхбаатар баг, Мандал баг, Хөтөл баг, Цагаан нуур баг, Ерөө баг), Дорноговь, Орхон, Дархан-Уул аймаг

Энэхүү сургалтын сэтгэл ханамж өндөр байсан боловч, сургалтын сүүлийн өдөр сэтгэл ханамж огцом буурах хандлага ажиглагдсан. Сургалтын сүүлийн өдөр, оролцогчдоос “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэж юу вэ?”, “Хичээлийн бэлтгэл судалгаа гэж юу вэ?” гэж асуухад, эхний асуултад тохиромжтой хариулсан хүмүүс дөнгөж 15% орчим байв. Үүний шалтгаанд, оролцогчид “Хичээлийн судалгаа”-г суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэж ойлгосон байсныг дурьдаж болно.

Энэ асуудлыг харгалзан үзээд, гурав дахь жилийн сургалтыг зохион байгуулахдаа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

- Сургагч багш нарын сургалтаар сургагч багш нарт дээрх үр дүнг танилцуулан, хичээлийн судалгаа бол багшлахуйн арга зүйн хөгжлийн нэг арга хэрэгсэл юм гэдгийг дахин тайлбарласан.
- Сургалтын өмнө, сургагч багш болон хичээл заах багш ээлжит хичээлийн хөтөлбөрийг хамтран боловсруулж, сайтар шалгаж нягталсны үндсэн дээр судалгаат хичээл зохион байгуулахаар төлөвлөсөн. Судалгаат хичээлийн чанарыг дээшлүүлэн, сургалтад оролцогчдод суралцахуйд суурилсан багшлах арга зүйг зөв ойлгуулахыг хичээсэн юм.

3) “Мэргэжлийн баг”-аас бүх “Аймаг, дүүргийн баг”-г зориулсан технологийн дэмжлэгийн тогтолцооны талаар

Мэргэжлийн баг болон төслийн багийн зүгээс багшлахуйн арга зүйгээ хөгжүүлэх хүсэл, сонирхлоо илэрхийлсэн загвар бус аймаг, дүүрэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Хүснэгт 3-10: Бүх аймаг, дүүрэгт зориулсан технологийн дэмжлэг /2011/

Огноо	Үйл ажиллагааны нэр	Зохион байгуулагч (Байр)	Зорилтот бүлэг	Дэмжлэгийн агуулга
7/XI	Лекц	ХУД-ийн БХ (Тус дүүргийн 15-р сургууль)	ХУД-ийн БХ-ийн мэргэжилтэн, захирал, сургалтын менежер	Төслийн мэргэжилтэн суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгаа, сургуульд суурилсан хичээлийн судалгааны тухай лекц уншив.
8/XII	Лекц	БГД-ийн БХ	БГД-ийн БХ-ийн	НБГ-ын мэргэжилтэн, төслийн

		(Тус дүүргийн БХ сургалтын төв)	мэргэжилтэн 2, захирал 20, сургалтын менежер 2, багш 2	зохицуулагч, төслийн багийн мэргэжилтэн хичээлийн судалгааны тухай лекц уншив.
9-10/ХII	Лекц	БЗД-ийн БХ (Тус дүүргийн 14-р сургууль)	БЗД-ийн 45 сургалтын менежер (Тус дүүргийн 38 сургуулийн 71 менежерийн дотроос)	НБГ-ын мэргэжилтэн, БЗД-ийн БХ-ийн мэргэжилтэн, 102-р сургуулийн сургалтын менежер, төслийн мэргэжилтэн нар хичээлийн судалгааны тухай лекц уншив.

Бүх “Аймаг, дүүргийн баг”-т үзүүлэх дэмжлэгийн нэг хэсэг болгож, багшлахуйн арга зүйн шинэчлэлийн талаар зөвлөгөө өгөх, мэдээлэл тавих зорилгоор цахим хуудас байгуулах тухай судалж үзсэн. Ингээд 2012 оны БСШУЯ-ны төсөвт цахим хуудас байгуулахтай холбогдон гарах зардлыг суулгаж өгсөн (Зардлын тухайд, Хавсралт 7 -оос үзнэ үү).

(3) Үр дүн 2-той холбоотой үйл ажиллагаа: “Загвар аймаг, дүүрэгт хичээлийн судалгааны загвар бий болно”

1) Загвар аймаг, дүүрэгт хичээлийн судалгааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэв

2011 оны 6 сарын 2-4-нд, 2010-2011 оны²⁵ хичээлийн жилд загвар аймаг, дүүрэгт зохион байгуулагдсан багшлахуйн арга зүйн шинэчлэлийн үр дүнг танилцуулан, 2011-2012 оны хичээлийн жилийн үйл ажиллагаа төлөвлөгөө боловсруулах зорилгоор “Хичээлийн судалгааны тайлангийн хурал” семинарыг зохион байгуулав. СХД, Булган, Завхан аймгийн холбогдох хүмүүс анх удаа нэг доор хуран цуглаж, харилцан амжилт туршлага, бэрхшээл хүндрэлээ харилцан ярилцах боломж олдсон.

Семинарын 3 дахь өдөр, бүх загвар аймаг, дүүргийн БСГ/БХ болон загвар сургуулиуд 2011-2012 оны хичээлийн жилд хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөөгөө гаргасан. Мэргэжлийн багийн гишүүд загвар сургуулиуд дээр очиж ажиллан, хичээлийн судалгааны мониторинг хийж буй явдал загвар сургуулийн холбогдох хүмүүс болон мониторингийг хамтран хийж буй БСГ-ын мэргэжилтнүүдийн хувьд суралцах томоохон боломж болдог тухай тодорхой дурьдаж байлаа. Иймд, төслийн 2 дахь жилээс хойш хавар, намрын улиралд 2 удаа (2-3 сар, 9-10 сар) хичээлийн судалгааны мониторингийг зохион байгуулж байхаар тогтов.

2) Мэргэжлийн багаас загвар сургууль дээр хийсэн хичээлийн судалгааны мониторинг

Хоёр дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийг дараах хөтөлбөрөөр зохион байгуулав. Анхны мониторингтой харьцуулахад сорил туршилт ихтэй, ахуй амьдралтай холбосон агуулга бүхий хичээлүүд олон болсон байсан. Тухайлбал,

²⁵ Монголд хичээлийн шинэ жил 9 сард эхлэн, 6 сард дуусдаг.

Завханмандал сумын сургууль дээр шилэн саванд загас хийн авчирч ажиглалт хийх Хүн байгаль хичээл зохион байгуулагдсан. Тосонцэнгэл сумын сургуулийн Төсөлт ажлын хичээл дээр нутагтаа ургадаг жимсийг судлан, жимсээр хийдэг бүтээгдэхүүн болон тэдгээрийн үйлчлэлийн талаар ярилцаж, жимсний шүүс хийх зэрэг үйл ажиллагаа явагдсан.

Мөн, хичээлийн судалгааны менежменттэй холбоотойгоор ч эерэг өөрчлөлтүүд ажиглагдсан. Жишээ нь, Булган аймгийн Сэлэнгэ сумын сургууль цагийн хуваарьтаа өөрчлөлт оруулж, судалгаат хичээлтэй өдрөө амралтын өдөр болгон бүх багш нарын оролцох боломжийг бүрдүүлжээ. Төслийн зорилтот 8 хичээлээс бусад хичээлийн багш нар ч хичээлийн судалгаанд оролцох болж, бүсийнхээ бусад сургуулиудаас ажиглагч багш урин оролцуулж оролцуулж байв.

Нөгөөтэйгүүр “Ажиглагч багш нарт харуулах”-ад хэт анхаарснаас, хүүхэд нэг бүрийн суралцахуйг сайн анзаарахгүй байгаа байдал ч цөөнгүй ажиглагдсан.

Хүснэгт 3-11: Хоёр дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн товч танилцуулга /2011/

Загвар аймаг, дүүрэг	Хөтөлбөр	Баг 1		Баг 2	
СХД	15/IX - 15/X	Сургууль бүр 8 судлагдахуунаар тус бүр 1 удаа			
Булган	11-14/X	Сэлэнгэ, 1-р сургууль, Хутаг-Өндөр	Физик, Хими, Хүн орчин, Хүн байгаль	Гурванбулаг, Хишиг-Өндөр, 1-р сургууль	Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Төсөлт ажил, Мэдээлэл зүй, Удирдлага
Завхан	10-17/IX	Чандмань-Эрдэнэ, Шилүүстэй, Завханмандал, Тосонцэнгэл	Хими Хүн орчин Хүн байгаль Төсөлт ажил	Чандмань-Эрдэнэ, Сонгино, Баянтэс	Физик, Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Мэдээлэл зүй, Удирдлага

3) СХД-ийн Ирээдүй ЦС-д зориулсан тусгай лекц

Ирээдүй ЦС нь бага, дунд, ахлах 7 сургууль бүхий томоохон хэмжээний сургууль бөгөөд багшийн тоо ч олон. Энэхүү төслийн шууд загвар сургууль болох 3-р бага, 1-р ахлах сургуулиас бусад сургуулиудад ч багш нар нь бие даан хийж буй хичээлийн судалгаагаар дамжуулан арга зүйн шинэчлэлд оролцож байна. Өнөөг хүртэл, энэхүү төслийн хүрээнд зохион байгуулж ирсэн сургалтуудад хамрагдаж байгаагүй багш нарын хүсэлтээр 2011 оны 11 сарын 18-нд төслийн багийн зүгээс лекц уншин, судалгаат хичээл болон хэлэлцүүлэгт оролцов.

(4) Үр дүн 3-тай холбоотой үйл ажиллагаа: “Загвар аймаг, дүүргийн багш нарын суралцахуйд суурилсан багшлах ур чадвар дээшилнэ”

Загвар аймаг, дүүргүүд багшлахуйн арга зүйн сургалтаа 2012 оны 1 сард (Гурав дахь жил) эхлүүлэхээр төлөвлөсөн байсан боловч, үүнээс урьтан бүх загвар сургуулиуд бие даан зэргэлдээ сургуулиуддаа зориулсан сургалтыг зохион байгуулсан юм.

Хүснэгт 3-12: Хоёр дахь жилийн загвар сургуулийн сургалтын хэрэгжилт /2011/

№	Сургуулийн нэр	Хөтөлбөр	Зорилтот сургууль	Оролцогч
1	67-р сургууль	2-3/V	74, 76, 104, 105-р сургууль	97
2	Хишиг-Өндөр сумын сургууль	тодорхойгүй	Орхон, Могод, Бүрэгхангай сумын сургууль	48
3	Хутаг-Өндөр сумын сургууль	2-4/III 9-10/IV	Уньт, Хантай, Баян-Агт, Сайхан, Тэшиг сумын сургууль	85
4	Сэлэнгэ сумын сургууль	6-7/V	Бугат, Хангал, Хялганат сумын сургууль	63
5	Гурванбулаг сумын сургууль	тодорхойгүй	Рашаант, Дашинчилэн, Баяннуур сумын сургууль	78
6	Тосонцэнгэл сумын 1-р сургууль	11-13/II	Тосонцэнгэл сумын 1, 2-р сургууль, Их-Уул, Идэр, Тэлмэн сумын сургууль	64
7	Сонгино сумын сургууль	11-13/II	Сонгино сумын сургууль ба бусад бүсийн багш нар	Сонгино 25 бусад 40
8	Баянтэс сумын сургууль	11-13/II	Баянтэс сумын сургууль ба бусад бүсийн багш нар	71
9	Завханмандал сумын сургууль	11-13/II	Завханмандал сумын сургууль ба бусад бүсийн сургуулийн багш нар	51
10	Шилүүстэй сумын сургууль	11-13/II	Шилүүстэй сумын сургууль ба бусад бүсийн сургуулийн багш нар	45

Хоёр дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн үр дүнг эргэн харвал, загвар сургуулиуд багшлахуйн арга зүйг хөгжүүлэхээр хичээнгүйлэн ажиллаж байгаа ч, хичээлийн чанар нь сайжирсан гэхэд хэцүү. Энэ тохиолдолд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулбал мэргэжлийн багийнхнаас сурч мэдсэн зүйл нь бүдгэрсэн байдалтайгаар бүх сургуулиудад түгэн дэлгэрэх эрсдэлтэй.

Гэхдээ, загвар сургуулиудын сайн дурын үйл ажиллагааг талархан дэмжих нь зүйтэй бөгөөд загвар аймаг, дүүргийн олон сургууль суралцахуйд суурилсан багшлах арга зүй болон хичээлийн судалгааг зөв ойлгоход үр дүнгээ өгсөн юм. Загвар сургуулиас сургалт авсан бусад сургуулиуд мэргэжлийн багийн зохион байгуулдаг хичээлийн судалгааны мониторингт ч оролцох болж, загвар сургуулийн судалгаат хичээлээр дамжуулан ойлголтоо гүнзгийрүүлэх болжээ.

(5) Үр дүн 4-тэй холбоотой үйл ажиллагаа: “Багш бэлтгэх шатанд Багш бэлтгэх шатанд суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх орчин боловсронгуй болно”

1) Багш бэлтгэдэг их сургуулиудад сургалтын багц материалыг танилцуулав

2011 оны 8 сарын 29-30-нд МУБИС-тай хамтран Багш бэлтгэдэг их сургуулиудын төлөөлөлд зориулан сургалтын багц материалыг танилцууллаа. Уг арга хэмжээнд МУБИС (12 сургуулиас 93 багш, Архангайн салбар сургуулиас 5 багш), Дорнод дээд сургуулиас 2 багш, Ховдын Боловсролын их сургуулиас 2 багш, Ховдын Боловсролын их сургуулийн харьяа Баян-Өлгийн багшийн сургуулиас 2 багш, хувийн хэвшлийн Гурван-Эрдэнэ дээд сургуулиас 2 багш оролцсон.

МУБИС-тай хамтран ажилласнаар олон тооны оролцогчидтой болсны нөгөөтэйгүүр, оролцогчдын мэргэжлийн чадвар болон сонирхол нь харилцан адилгүй, боловсруулж буй сургалтын багц материалыг танилцуулахад суралцахууд суурилсан багшлах арга зүйн хичээлийг багш бэлтгэдэг сургуульд нэвтрүүлэх талаар тодорхой зүйл хэлэлцэж чадаагүй юм.

Ингээд, гурав дахь жилд их сургуулийн хөтөлбөрийн шинэчлэлд нөлөөтэй оролцогчдоор хязгаарлан, мөн адил семинарыг зохион байгуулсан. Мөн, суралцахууд суурилсан багшлах арга зүйн хичээлийг багш бэлтгэдэг сургуульд нэвтрүүлэх тодорхой аргыг тусгасан “Хичээлийн судалгаа: Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр” модуль боловсруулахаар шийдвэрлэж, гурав дахь жилийн үйл ажиллагааны Монголын талын төсөвт уг модулийг боловсруулах зардлыг тусгасан.

Уг сургалтын дараах дэмжлэг болгон МУБИС-ийн төлөөллийг бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтад (Өмнө дурьдсан) хөндлөнгийн ажиглагчаар оролцуулав. Мөн, 12 сарын 2-нд МУБИС-ийн Архангай аймаг дахь салбар сургуульд зочлон, цаашдын хамтын ажиллагааны төлөв байдлын талаар хэлэлцсэн.

3.3 ГУРАВ ДАХЬ ЖИЛ (2012 оны 2 сар - 2013 оны 1 сар)

(1) Японд сургалт зохион байгуулав

Хичээлийн судалгааны мониторингийн үр дүнд сургуулийн удирдлагын ойлголт, хандлага нь тухайн сургуулийн багшлахуйн арга зүйн шинэчлэлд ихээхэн нөлөөлдөг болох нь тодорхой болсон тул 2012 оны 6 сарын 18-29-нд (Японд очсон: 16/VI, нутаг буцсан: 30/VI) загвар сургуулийн удирдлага 21 хүнд зориулан Японд сургалт зохион байгуулсан. Энэхүү сургалтын зорилгыг (1) Япон багш нарын заах арга зүйгээс суралцах, (2) Хичээлийн бэлтгэл судалгааны талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх, (3) Японд сургууль дээр хэрхэн багшийн багшлах ур чадвар дээшлүүлдэг болох болон сургуульд суурилсан хичээлийн судалгааны бүтэц, зохион байгуулалтаас суралцах явдал гэж тодорхойлсон.

Сургуулийн удирдлагад зориулсан сургалт байсан тул сургалтын дараа Японд сурч мэдсэнээ нэн даруй ажил хэрэг болгосон жишээ ч гарсан. Тодорхой жишээг доор дурьдав.

- Японы сургуулиуд шиг өглөөний ном уншлагатай болж, сургуулийн цэвэрлэгээг хүүхдүүд хийх болсон. (СХД-ийн 12-р сургууль)

- Нэг оролцогч ЖАЙКА-гийн сургалтад төгсөгчдийн холбооны дэмжлэгийг авч, 2013 оны 1 сарын 24-нд Ирээдүй ЦС-ийн харъяа 7 сургууль болон зэргэлдээх 62-р сургуульд хичээлийн бэлтгэл судалгааны сургалтыг зохион байгуулсан. (СХД-ийн Ирээдүй ЦС)
- Самбар төлөвлөлт ба дэвтэр хөтлөлт гэсэн тодорхой зорилт дэвшүүлэн, сургуульд суурилсан хичээлийн судалгааг улам идэвхтэй хийх болсон. (Булган аймгийн Хишиг-Өндөр сумын сургууль)
- Дунд ангийн төслийн зорилтот хичээлийн чанар дээшилсэн. (Завхан аймгийн Баянтэс сумын сургууль)

(2) Гуравдагч оронтой туршлага солилцов

Төслийн явцын үнэлгээ судалгаанаас өгсөн зөвлөмжийн дагуу, 2012 оны 5 сарын 21-29-нд БШУЯ, Боловсролын хүрээлэн, НБГ, Мэргэжлийн баг болон загвар аймгийн БСГ зэрэг байгууллагын төлөөлөл болох 12 хүн Индонезид айлчлан, ЖАЙКА-гийн “Анхан шатны дунд боловсролын чанарыг дээшлүүлэх төсөл”-ийн оролцогчидтой туршлага солилцсон.

Энэхүү туршлага солилцох хөтөлбөрийн зорилго нь (1) Хичээлийн судалгаа хэрэгжүүлэх тал дээр Монголоос илүү урт түүхтэй Индонези дэх хичээлийн судалгааны үйл ажиллагаа болон тэдний туршлага сургамжаас суралцан, цаашид Монгол Улсад хичээлийн судалгааны менежментийг боловсронгуй болгоход тус дэм болох, (2) Монгол дахь үйл ажиллагааг бусад улс орны төсөл хөтөлбөрүүдэд танилцуулснаар Монголын талын хүсэл эрмэлзлэлийг дээшлүүлэх, ур чадварыг бэхжүүлэхэд чиглүүлэх явдал байв.

Уг туршлага солилцох хөтөлбөр нь Монголын гэсэн хичээлийн судалгааны онцлог шинж юу болох талаар тунгаан бодох сэжиг болсон юм. Хөтөлбөрт оролцогчид дараах зүйлүүдэд голчлон анхаарчээ.

- Эрх мэдлийг орон нутагт шилжүүлэх үйл явц өрнөж буй Индонезитэй харьцуулахад, төвлөрсөн эрх мэдэл бүхий Монгол оронд дээрээс гагцхүү босоо холбоонд нь хичээлийн судалгааг түгээн дэлгэрүүлэх явдал үр дүнтэй гэсэн санал гарч байв.
- Аймгуудын БСГ-ын төлөөллүүд сургууль болон аймгийн түвшинд зөвхөн доороосоо санаачлагатай үйл ажиллагаа буюу Индонезийн жишээнээс суралцах нь зүйтэй гэсэн санал хэлж байв.
- Индонезийн анхан шатны дунд боловсролын чанарыг дээшлүүлэх төслийн мэргэжилтэнтэй санал бодлоо солилцсоны дүнд, хичээлийн судалгааг яаран зохион байгуулах, албадан зохион байгуулах нь хичээлийн судалгааг хэлбэр хөөцөлдсөн төдий зүйл болгон хувиргах эрсдэлтэй болохыг анзаарсан.
- Ажиглалтын хуудас болон хичээлийн видео бичлэг хийж буй байдлаас нь Индонезид хүүхдийн суралцахууд гол анхаарлаа хандуулдаг болохыг анзаарсан.
- Индонезитэй харьцуулахад, Монголд хичээлийн бэлтгэл судалгаанд илүү их хүч хаяж буй нь онцлогтой болохыг мөн анзаарчээ.

Туршлага солилцох хөтөлбөрийн үеэр өөрсдийн хичээлийн судалгааг хэрхэн зохион байгуулж буй тухайгаа илтгэх боломж олдсон бөгөөд бусад улс оронд түүнийгээ сурталчлан түгээх хүсэл эрмэлзэл нь дээшилсэн юм. Уг туршлага солилцох хөтөлбөрийн нэг оролцогч 2012 оны 11 сард Сингапурт зохион байгуулагдсан “Олон улсын хичээлийн судалгааны нийгэмлэгийн хурал”-д (World Association of Lesson Studies 2012 International Conference) Монгол дахь үйл ажиллагаа²⁶-ны талаар илтгэл тавьсан.

(3) Үр дүн 1-тэй холбоотой үйл ажиллагаа: “Бүх аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх багийн үр чадвар дээшилнэ”

1) Сургалтын багц материалыг засан сайжруулав

Мэргэжлийн баг, БШУЯ-наас томилогдсон экспертизийн баг болон төслийн багийн санал зөвлөмж, хичээлийн судалгааны мониторингийн үр дүн, бүх аймаг, дүүргийн багц зориулсан сургалтын үр дүнг үндэслэн сургалтын багц материалыг засан сайжруулсан. Сургалтын багц материалын төслийг 2012 оны 12 сарын эцсээр БШУЯ-нд хүргүүлсэн.

2) Бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулан сургалт зохион байгуулав

а. Хичээлийн судалгааны тайлангийн хурал зохион байгуулав

2012 оны 6 сарын 3-4-нд, Хичээлийн судалгааны тайлангийн хуралыг зохион байгуулж, загвар аймаг, дүүргийн төлөөллөөс гадна загвар бус аймаг, дүүргүүдийн нэг нэг төлөөллийг урин оролцуулж, 2011 оны 11 сарын бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтаас хойших бүх аймаг, дүүргийн сургуулидын багшлахуйн арга зүйн хөгжлийн явцыг судалсан. Үндэсний хэмжээний 747 сургуулийн 476 нь 2011-2012 оны хичээлийн жилд хичээлийн судалгааг нэгээс дээш удаа зохион байгуулсан, Улаанбаатар хот болон 21 аймгийн 19-д нь суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны сургалт зохион байгуулагдсан нь тодорхой болсон.

Нөгөөтэйгүүр, загвар бус аймгууд дахь тулгамдсан асуудлаар дараах зүйлүүд хөндөгдсөн.

<Багшлахуйн арга зүйн хөгжлийн менежменттэй холбоотой тулгамдсан асуудал>

- Удирдлагын ойлголт дутмаг.
- Ахмад багш нарын оролцоо сул байгаагийн улмаас багш нар хамтран ажиллахад хүндрэлтэй.
- Нэг сургуульд ижил судлагдахууны багш цөөн тул, багийн үйл ажиллагаа бэрхшээлтэй.
- Сургууль дээр сургалт болон судалгаат хичээл зохион байгуулах цаг зохицуулалт хэцүү.
- Мэргэжилтнүүдийн сургууль дээр ажиллахад шаардлагатай төсөв болон судалгаат

²⁶ Ch. Nyamgerel, J. Enebish “Some results of implementing the Lesson Study by chemistry teachers of Bayangol District”

хичээлд ашиглах хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авах, бэлтгэх төсөв хүрэлцээгүй.

< Хичээлийн судалгаа зохион байгуулахтай холбоотой тулгамдсан асуудал >

- Хичээлийн судалгааг хэлбэрийн төдий хийх.
- Судлагдахууны агуулгын талаарх ойлголт дутмаг.
- Хэрэглэгдэхүүн хүрэлцээгүй.
- Багшийн туршлага нимгэн, хичээлд ашиглах материал хомс тул сорил туршилт хийхэд хүндрэлтэй.
- Сайн самбар төлөвлөлт, дэвтэр хөтлөлт гэж юу болох талаар ойлголт багатай учир чиглүүлэхэд хүндрэлтэй.
- Хүүхдүүдийн оролцоог дэмжих арга мэдэхгүй.
- Судалгаат хичээлд ажиглалт хийх арга мэдэхгүй.
- Судалгаат хичээлийн дараах хэлэлцүүлэгт ажиглагч багш нар хичээл заасан багшийг шүүмжлэх хандлагатай.

Гурав дахь жилийн бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтыг зохион байгуулахад эдгээр асуудлуудыг харгалзан, сургалт хөтөлбөрөө эргэн харах шаардлагатай бий болсон.

б. Сургагч багшийн сургалт

Хоёр дахь жилийн бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтаар, сэтгэл ханамж сүүлийн өдөр огцом буурсан асуудал, оролцогчид “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй” болон “Хичээлийн судалгаа”-г хольж хутгасан асуудал гарсан. Иймд, 2012 оны 10 сарын 20-21-нд сургагч багшийн сургалтыг зохион байгуулж, сургагч багш нарт энэ тухай дуулгахын зэрэгцээ хичээлийн судалгаа нь багшлахуйн арга зүйн хөгжлийн нэг арга хэрэгсэл болохыг тайлбарласан. Мөн, 5 хоног байсан сургалтыг 4 хоног болгон багасгаж, сүүлийн өдөр хүртэл нягт нямбай зохион байгуулахыг санал болгосон.

6 сард зохион байгуулагдсан хичээлийн судалгааны тайлангийн хуралын үеэр загвар бус аймгийн оролцогчдод сургалттай холбоотой дараах хэрэгцээ шаардлага байгаа болох нь тодорхой болсон. Загвар бус аймгийн олонх нь онолын бус хичээл практик, хичээлийн судалгааны бодит жишээг илүү хүсч байсан тул, сургалтыг оролцогчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бэлтгэх ажлыг сургагч багш нарт даалгасан.

< Хичээлийн чанарыг дээшлүүлэх >

- Хүүхдийн хэдийнэ мэддэг зүйл болон эрэлт хэрэгцээг судлах тодорхой аргаас суралцах.
- Хүүхдийн хандлагыг хэрхэн тооцож, ээлжит хичээлийн хөтөлбөрт тусгадаг талаарх тодорхой аргад суралцах.
- Хүүхдийн алдааг хичээлд хэрхэн ашиглах тухай тодорхой аргад суралцах.
- Судлагдахууны агуулгын талаар зөвлөгөө авах.

< Хичээлийн судалгааны менежментийг сайжруулах >

- Хичээлийн судалгаа зохион байгуулах жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэг загвар сургуулийн бодит жишээтэй танилцах.
- Аймаг доторх бүсийн сүлжээ бий болгосон загвар аймгийн туршлагаас суралцах.
- Аймгийн баг болон мэргэжилтнүүдээс сургалт авах (Онлайн сургалт ч байж болно).

в. Бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулан сургалт зохион байгуулав

Сургалтын хөтөлбөрийн тухайд, өмнөх сургалтын агуулгыг нягтруулан 4 өдрийн сургалт болгож өөрчилсөн. Мөн, оролцогчдын “Хичээл ажиглах нүд”-ийг хөгжүүлэхийн тулд, сургалтын 3 дахь өдөр нь хичээл заах багш болон сургагч багш нарын урьдчилан бэлтгэсэн судалгаат хичээлийг зохион байгуулахаар зохицуулалт хийсэн.

Загвар бус аймаг, дүүргийн оролцогчдын хувьд, тэдний багшлахуйн арга зүйн шинэчлэлийн талаарх мэдлэг, туршлагыг улам гүнзгийрүүлэх зорилгоор өмнөх жилийн сургалтад оролцсон хүмүүсийг хамруулахаар төлөвлөсөн байсан юм. Гэхдээ, өмнөх жилийн сургалтын дүгнэлтэд тулгуурлан, нэг багт удирдлагаас 2 хүн, төслийн зорилтот 8 судлагдахуун бүрээс нэг багш буюу багшлахуйн арга зүйн шинэчлэлийг удирдан чиглүүлэх боломжтой боловсон хүчнээр дахин бүрдүүлэх хүсэлтийг төслийн баг гаргасан. Мөн, шинэчлэн бүрдүүлэх багт БСГ/БХ-ийн мэргэжилтнүүдээс гадна сургалтын менежерүүдийн оролцоог хөхүүлэн дэмжсэн. Оролцогчдоос гадна хөндлөнгийн ажиглагчаар БМДИ-ийн 30 арга зүйчийг оролцуулсан.

Эдгээр бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр зохион байгуулсан бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтын талаар дараах хүснэгтэд танилцуулъя.

Хүснэгт 3-13: Сургалтын товч танилцуулга /2012/

№	Хөтөлбөр	Зохион байгуулсан газар	Сургагч багш	Оролцогч	Оролцогчид (Хөндлөнгийн ажиглагчийг оролцуулан)
1	3-6/XI	СХД-ийн Ирээдүй ЦС	33	120	НБГ, СХД (Ирээдүй ЦС, 12-р сургууль, 67-р сургууль), ХУД, БЗД, ЧД, БГД, СБД, БМДИ, ЖАЙКА-гийн сайн дурын гишүүн
2	10-13/XI	БЗД-ийн 85-р сургууль	26	82	Багануур, Налайх, Багахангай дүүрэг, 85-р сургууль болон Говьсүмбэр, Төв, Өмнөговь, Дорноговь аймаг болон БМДИ, ЖАЙКА-гийн сайн дурын гишүүн
3	14-17/XI	Булган аймгийн ²⁷ 1-р сургууль	22	84	Булган аймаг (БГ, 1-р сургууль, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Гурванбулаг, Сэлэнгэ сумын сургууль) болон Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор аймаг, БМДИ, ЖАЙКА-гийн сайн дурын гишүүн
4	11-14/XI	Завхан аймгийн Чандмань-Эрдэ нэ ЦС	18	113	Завхан аймаг (БГ, Чандмань-Эрдэнэ ЦС, Сонгино, Шилүүстэй, Баянтэс, Завханмандал сумын сургууль болон Тосонцэнгэл сумын 1-р сургууль),

²⁷ Зөвхөн Архангай аймгийн баг орон нутгийн сонгуультай гэдэг шалтгаанаар сургалтад оролцоогүй.

					Говь-Алтай, Ховд, Увс, Баян-Өлгий, Ховд их сургууль, Ховд их сургуулийн харьяа Баян-Өлгийн Багшийн коллежи
5	14-17/XI	Дорнод аймгийн Хан-Уул ЦС	21	82	Дорнод аймаг (БГ, Хан-Уул ЦС, 5-р сургууль, бусад сургууль), Хэнтий, Сүхбаатар аймаг болон Дорнод дээд сургууль, БМДИ
6	14-17/XI	Сэлэнгэ аймгийн 1-р сургууль	18	94	Сэлэнгэ аймаг (Сүхбаатар, Мандал, Хөтөл, Цагааннуур, Ерөө, бусад бүсийн сургалтын менежер), Дорноговь аймаг, Орхон аймаг, Дархан-Уул аймаг, БМДИ, ЖАЙКА-гийн сайн дурын гишүүн

Орон нутгийн сонгуулийн өмнөхөн зохион байгуулагдсан СХД дэх сургалтад өмнөх жилийн сургалтын оролцогчдыг хамруулах нь төвөгтэй байсан бөгөөд хичээлийн судалгааны талаар огт мэдлэг, туршлагагүй багш нар олноор оролцсоны улмаас бага зэрэг хүндрэл бэрхшээл гарч байсан юм. Гэхдээ, бүх сургалтын хувьд сургалтад оролцогчдын сэтгэл ханамж 4 хоногийн турш өндөр байж, ойлголт нь ч дээшилсэн байна.

3) Мэргэжлийн багаас бүх “Аймаг, дүүргийн баг”-т үзүүлсэн технологийн дэмжлэгийн талаар

а. Мэргэжлийн багаас загвар бус аймаг, дүүрэгт үзүүлсэн технологийн дэмжлэг

2011 оны 11 сард зохион байгуулагдсан бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтад, улам илүү дэмжлэг шаардлагатай гэж үзсэн аймгуудад мэргэжлийн багийн гишүүд дараах байдлаар технологийн дэмжлэг үзүүлсэн. Архангай, Өмнөговь аймгууд дахь сургалтын тухайд, БШУЯ нэмэлт төсөв хувиарлан, тухайн аймагт гарсан зардлыг хариуцсан юм.

Харин, Дархан-Уул аймаг дахь сургалтыг БГ-ын хүсэлтээр зохион байгуулсан бөгөөд тус аймаг дахь зардлыг тус аймгийн БГ хариуцсан.

Хүснэгт 3-14: Загвар бус аймаг, дүүрэгт үзүүлсэн технологийн дэмжлэг /2012/

Зохион байгуулагч	Зорилтот аймаг	Дэмжлэгийн агуулга	Хугацаа
Мэргэжлийн баг	Архангай аймаг	Сургалт	15-17/III
Мэргэжлийн баг	Өмнөговь аймаг	Сургалт	1-3/X
Мэргэжлийн баг	Дорноговь аймаг	Мониторинг	8-12/X
Төслийн баг	Дархан-Уул аймаг	Сургалт	3-5/X

б. Цахим хуудас нээн ажиллуулав

Хоёр дахь жилийн үйл ажиллагааны хүрээнд, урьдчилан төлөвлөсний дагуу хичээлийн судалгааны цахим хуудсыг (<http://hicheeliin-sudalгаа.mn/>) нээн ажиллуулсан. Монголд багш нар арга зүйгээ хөгжүүлэхдээ ашиглахуйц материал ховор бөгөөд нааш цааш зорчиход ч хүндрэлтэй тулгардаг. Тиймд энэхүү цахим хуудсаар дамжуулан, хичээлийн судалгаа зохион байгуулж буй багш нар болон судалгаачдын мэдээллээ хуваалцах явдлыг дэмжихийг зорьсон.

Энэхүү цахим хуудасны бүтцийг дараах схемд үзүүлэв. 2013 оны 3 сарын 1-нээс уг

цахим хуудсыг БМДИ-эд шилжүүлсэн.



Зураг 3-1: Цахим хуудсын бүтэц

в. Хичээлийн судалгаа видео бүтээв

Математикийн /суурь/ багийн гишүүд голлон хичээлийн судалгааг ойлгомжтой байдлаар тайлбарласан видео бүтээсэн. Уг видеог холбогдох материалын хамт DVD болгон хэвлэж, БШУЯ, Боловсролын хүрээлэн, БМДИ зэрэг холбогдох байгууллагууд болон аймаг, дүүргүүдийн БГ/БХ, нийт ЕБС-иудад тус бүр 3 ширхэгийг хуваарилсан.

4) Загвар аймаг, дүүргийн түгээн дэлгэрүүлэх багаас загвар бус аймаг, дүүрэгт арга зүйн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө, хэрэгжилт

Анх тус төслийн хүрээнд, загвар аймаг, дүүргийн хичээлийн судалгааны загварыг бий болгох, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг хэрэгжүүлэх ур чадварыг дээшлүүлэхээр төлөвлөсний нөгөөтэйгүүр, загвар бус аймаг, дүүрэгт түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа болгон зөвхөн бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалт л зохион байгуулахаар төлөвлөж байсан.

Төслийн дунд хугацааны үнэлгээ судалгаагаар, анх төлөвлөгдсөн үйл ажиллагаа төдийхнөөр багшлахуйн арга зүйг хөгжүүлэх үйл ажиллагааг бүх талаар түгээн дэлгэрүүлэхэд амаргүй учир загвар аймаг, дүүргээр дамжуулан загвар бус аймаг, дүүрэгт үйл ажиллагаа явуулахыг зөвлөсөн. Мөн, энэ үйл ажиллагаанд загвар аймаг, дүүргийн туршлагыг бусдад таниулан түгээх үйл ажиллагаагаар дамжуулан суралцахуйд суурилсан багшлах арга зүйг хэрэгжүүлэх тэдний ур чадварыг дээшлүүлэх зорилго ч мөн агуулагдаж байсан.

Иймээс, доорх хүснэгтэд үзүүлсэнчлэн, загвар аймаг, дүүргээс загвар бус аймаг,

дүүрэгт сургалт болон мониторингийг зохион байгуулсан юм. Үүнээс, Өвөрхангай болон Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан сургалтад БШУЯ нэмэлт төсөв хуваарилан, тэдгээр аймаг дахь зардлыг хариуцсан.

2012 оны 11 сард зохион байгуулагдсан бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалт дахь “Багшлахуйн арга зүйн шинэчлэлд сургуулийн удирдлагын ойлголт зайлшгүй шаардлагатай, сургуулийн удирдлагад зориулсан сургалт зохион байгуулах хэрэгтэй” гэсэн оролцогчдын саналыг үндэслэн, Сэлэнгэ аймгийн багаас аймагтаа Сэлэнгэ, Орхон, Дорноговь аймгуудад зориулсан сургалтыг зохион байгуулсан. Сургалтад оролцогчдын замын зардал, томилолтын зардлын тодорхой хэсгийг оролцогчид өөрсдөө хариуцсан.

Хүснэгт 3-15: Загвар бус аймаг, дүүрэгт үзүүлсэн технологийн дэмжлэг /2012/

Зохион байгуулагч	Зорилтот бүлэг	Дэмжлэгийн агуулга	Зохион байгуулсан хугацаа
Завхан аймгийн баг	Баян-Өлгий	Мониторинг	22-28/IV
Сэлэнгэ аймгийн баг	Дархан-Уул	Мониторинг	30/IV-5/V
Дорнод аймгийн баг	Хэнтий	Мониторинг	6-12/V
Булган аймгийн баг	Өвөрхангай	Сургалт	24-26/IX
НБГ	Чингэлтэй дүүрэг	Мониторинг	24-28/IX
Дорнод аймгийн баг	Сүхбаатар	Сургалт	27-29/IX
Булган аймгийн баг	Хөвсгөл	Мониторинг	24-30/X
Сэлэнгэ аймгийн баг	Сэлэнгэ, Орхон, Дорноговь	Сургалт	15-16/I /2013/

Эдгээр үйл ажиллагаа нь эрхэм зорилго биелэгдэх магадлалыг өндөрсгөхөд нэмэр болсон.

(4) Үр дүн 2-той холбоотой үйл ажиллагаа: “Загвар аймаг, дүүрэгт хичээлийн судалгааны загвар бий болно”

1) Загвар аймаг, дүүрэгт хичээлийн судалгааны төлөвлөгөө боловсруулан, хичээлийн судалгааны тайлангийн хурал зохион байгуулав

2012 оны 6 сарын 3-4-нд, 2011-2012 оны хичээлийн жилд загвар аймаг, дүүрэгт хэрэгжсэн багшлахуйн арга зүйн шинэчлэлийн үр дүнг хуваалцах, 2012-2013 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зорилгоор “Хичээлийн судалгааны тайлангийн хурал” зохион байгуулав.

Энэхүү тайлангийн хурлын үед, загвар аймаг, дүүргийн БСГ/БХ болон загвар сургуулийн холбогдох хүмүүс хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан. Мөн, хоёр дахь жилийн бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтад судалгаат хичээлийн чанарт асуудал байсан тул, холбогдох хүмүүс цугласан уг тайлангийн хурал дээр “Сайн хичээлийн жишээ” үзүүлэхээр төлөвлөсөн. Тодорхой хэлвэл, МУБИС, төслийн эхний шатны загвар 97-р сургууль, Сэтгэмж ЦС-д томилогдон ажиллаж байсан ЖАЙКА-гийн сайн дурын гишүүдтэй хамтран, судалгаат хичээлүүдийг зохион байгуулсан юм.

2) Загвар сургуулиудад хичээлийн судалгаа зохион байгуулав

Загвар сургуулиуд хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөөныхөө дагуу хичээлийн судалгаа зохион байгуулсан.

3) Мэргэжлийн багаас загвар сургуулиудын хичээлийн судалгаанд мониторинг хийв

Мэргэжлийн баг төслийн багтай хамтран 2-3 сар, 9-10 сард загвар сургуулиудын хичээлийн судалгаанд мониторинг хийв. Намрын мониторингоор бүх сургуулиудын хичээлийн судалгааны хэрэгжилт болон судалгаат хичээлийн чанарт хяналт тавьж, 2010-2011 оны хичээлийн жилтэй харьцуулсан.

Хүснэгт 3-16: Гурав дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн товч танилцуулга /2012/

Загвар аймаг, дүүрэг	Хөтөлбөр	Баг 1		Баг 2	
СХД	12-21/III	Сургууль бүр 8 судлагдахуунаар тус бүр 1 удаа			
Булган	2-7/III	Сэлэнгэ, 1-р сургууль, Хутаг-Өндөр	Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Мэдээлэл зүй, Төсөлт ажил, Удирдлага	1-р сургууль, Хишиг-Өндөр, Гурванбулаг	Физик, Хими, Хүн орчин, Хүн байгаль, Удирдлага
Завхан	10-17/III	Тосонцэнгэл, Сонгино, Чандмань-Эрдэнэ	Физик, Хүн байгаль, Мэдээлэл зүй, Төсөлт ажил, Удирдлага	Шилүүстэй, Чандмань-Эрдэнэ, Завханмандал	Хими, Хүн орчин, Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Удирдлага

Хүснэгт 3-17: Дөрөв дэх удаагийн хичээлийн судалгааны мониторингийн товч танилцуулга /2012/

Загвар аймаг, дүүрэг	Хөтөлбөр	Баг 1		Баг 2	
СХД	3-12/X	Сургууль бүр 8 судлагдахуунаар тус бүр 1 удаа			
Булган	24-29/IX	Сэлэнгэ, 1-р сургууль, Хутаг-Өндөр	Физик, Хими, Хүн орчин, Хүн байгаль, Удирдлага	Гурванбулаг, Хишиг-Өндөр, 1-р сургууль	Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Мэдээлэл зүй, Төсөлт ажил, Удирдлага
Завхан	15-22/IX	Чандмань-Эрдэнэ, Сонгино, Баянтэс	Хими, Хүн орчин, Хүн байгаль, Төсөлт ажил, Удирдлага	Шилүүстэй, Завханмандал, Тосонцэнгэл	Физик, Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Мэдээлэл зүй,

				Удирдлага
--	--	--	--	-----------

(5) Үр дүн 3-тай холбоотой үйл ажиллагаа: “Загвар аймаг, дүүргийн багш нарын суралцахуйд суурилсан багшлах ур чадвар дээшилнэ”

1) Загвар аймаг, дүүргийн сургуулийн удирдлага, багш нарт зориулсан сургалтын төлөвлөгөө боловсруулав

Загвар “Аймаг, дүүргийн баг”, 2011 оны 11 сарын сургалтаар сургуулийн удирдлага, багш нарт зориулсан сургалтын төлөвлөгөө боловсруулав. Уг төлөвлөгөөнд, бүх аймаг, дүүргийн бүсийн түшиц сургууль болох загвар сургууль дээр зэргэлдээ сургуулийн төлөөллийг урин сургалт зохион байгуулж болох тухай тусгаж өгсөн. Мөн, аль болох БСГ-ын урьд өмнө хэрэгжүүлж байсан сургалтын төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулахыг хичээсэн. Ингэснээр, сургалттай уялдан гарах зардал төсвийг аль болох хөнгөвчлөх, төсөл дууссаны дараа тасралтгүй зохион байгуулах механизмыг бий болгохыг зорьсон юм.

Улмаар, сургалтад оролцсон бүх “Аймаг, дүүргийн баг”-ууд өөрсдийн аймаг, дүүрэгтээ багшлахуйн арга зүйн сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан.

2) Загвар аймаг, дүүргийн сургуулийн удирдлага, багш нарт зориулсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэв

Загвар “Аймаг, дүүргийн баг”-аас 2012 оны 1 сараас хойш, дараах байдлаар загвар бус сургуульд зориулсан сургалт зохион байгуулсан. Аймаг, дүүргийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүй байсны улмаас, сургалт зохион байгуулахад загвар сургуулийн ачаалал их байлаа. Мөн, нилээд олон сургагч багш нарын хувьд чадвар ур дутах, мэргэжлийн багийн боловсруулсан сургалтын материалыг сайтар судлаагүй чигээрээ ашиглах байдал ажиглагдсан зэрэг асуудлууд ч гарч байсан.

Харин, “Би боловсролын салбарт 30 жил ажиллаж байна. Багш өдөр тутам арга зүйгээ сайжруулахад чиглэсэн ийм үр дүнтэй сургалтад оролцож байсан нь хуруу дарам цөөхөн байлаа” хэмээн сэтгэгдлээ хэлэх зэргээр оролцогчдод харьцангуй таалагдсан байсан. Ялангуяа, багш нар хамтын үйл ажиллагааны чухлыг ойлгосон шинжтэй байлаа.

а. Сонгинохайрхан дүүрэг

СХД-ийг хөдөөтэй харьцуулахад, сургуулиуд руу зорчиход хялбар явдал юм. Багшийн нэг өдрийн ажлын ачааллыг багасгахын тулд, 3 хоног зарцуулан байж зохион байгуулдаг (12-р сургууль) сургалтаа хугацааг нь хуваан зохион байгуулж үзэх (67-р сургууль, Ирээдүй ЦС) зэрэг оролдлогууд харагдсан. Гэвч, энэ сургалтыг зохион байгуулахад дүүргийн БХ болон “Дүүргийн баг” хооронд уялдаа холбоо харагдахгүй байсан бөгөөд Улаанбаатар хотод хөдөө орон нутгийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцооноос ялгаатай тогтолцоо бий болгох шаардлагатай болохыг мэдэрсэн.

Хүснэгт 3-18: СХД-ийн загвар бус сургуульд зориулсан сургалт /2012/

Загвар сургууль	Сургалт зохион байгуулсан хугацаа	Хамрагдсан сургууль болон оролцогчийн тоо
12-р сургууль	13-15/II	6 сургууль: 50 орчим оролцогч
67-р сургууль	27/III, 6-13/IV	74, 76, 104, 105-р сургууль 5, 6-р анги хариуцсан багш нар болон Физик, Хими, Мэдээлэл зүй, Дунд ангийн Математикийн багш: 40-50
Ирээдүй ЦС	10/IV	Ирээдүй ЦС (Загвар сургуулиас гадна 5 сургууль): 56

б. Булган аймаг

Бүх загвар сургуулиуд аймгийнхаа БСГ-ын дэмжлэгээр бүсийн сургуулиудад зориулан сургалт зохион байгуулсан.

Хүснэгт 3-19: Булган аймаг дахь загвар бус сургуульд зориулсан сургалт /2012/

Загвар сургууль	Сургалт зохион байгуулсан хугацаа	Хамрагдсан сургууль ба оролцогчийн тоо
1-р сургууль	30/I-1/II	Эрдмийн өргөө ЦС: 10, Биеийн тамирын дунд сургууль: 6
Гурванбулаг сумын сургууль	8-9/I	Рашаант, Дашинчилэн, Баяннуур сумын сургууль
Хишиг-Өндөр сумын сургууль	12-13/I	Могод сумын сургууль: 21, Бүрэгхангай сумын сургууль: 16, Орхон сумын сургууль: 16
Сэлэнгэ сумын сургууль	13-14/I	Зүүн бүс: 39
Хутаг-Өндөр сумын сургууль	6-8/I	Уньт, Хантай, Сайхан, Баян-Агт, Тэшиг сумын сургууль: 35

в. Завхан аймаг

Завхан аймгийн БСГ, 2012 оны 4 сард дараах хүснэгтэд дурьдсаны дагуу загвар сургуулиуд дээр сургалт зохион байгуулсан. Сургуулиуд хоорондоо алс зайдуу байрладаг тул, сургалтын хугацааг сунгах юм уу, хэд хуваан зохион байгуулахад хүндрэлтэй. Тиймээс, судалгаат хичээлийнхээ сэдвийг зэргэлдээ сургуулиуд руу урьдчилан дуулган, тус бүрдээ бэлтгэлээ хангаж байгаад сургалтад оролцдог санал санаачлага гарч байсан.

Хүснэгт 3-20: Завхан аймаг дахь загвар бус сургуульд зориулсан сургалт /2012/

Загвар сургууль	Сургалт зохион байгуулсан хугацаа	Хамрагдсан сургууль ба оролцогчийн тоо
Чандмань-Эрдэнэ ЦС	11-12/IV	60 орчим хүн
Сонгино сумын сургууль	19-20/IV	Түдэвтэй, Нөмрөг, Цэцэн-Уул, Сантмаргац сумын сургууль: 106
Тосонцэнгэл сумын 1-р сургууль	21-22/IV	Тосонцэнгэл сумын 2-р сургууль, Их-Уул, Тэлмэн, Идэр сумын сургууль: 143
Баянтэс сумын сургууль	21-22/IV	тодорхойгүй
Завханмандал сумын сургууль	20-21/IV	Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Яруу, Ургамал сумын сургууль: 78
Шилүүстэй сумын сургууль	23-24/IV	Цагаанхайрхан, Цагаанчулуут, Алдархаан, Отгон сумын сургууль: 90

Улмаар, Завхан аймаг загвар бус сургуульд зориулсан сургалтыг 2012 оны 10 сард дахин зохион байгуулсан. Уг төлөвлөгөөгөөр тус аймгийн БСГ-ын мэргэжилтнүүд 1 сар орчмын хугацаанд аймгийн 6 бүсийн бүх сургууль, цэцэрлэгийн багш нарт зориулан сургалт зохион байгуулжээ.

3) Мэргэжлийн баг загвар аймаг, дүүргийн сургалтад мониторинг хийв

Мэргэжлийн баг бүх загвар аймаг, дүүргийн сургалтад мониторинг хийх төлөвлөгөөтэй байсан боловч, хөтөлбөр зохицуулахад хүндрэлтэй байсны улмаас зөвхөн СХД-ийн сургалтад мониторинг хийсэн. Завхан аймагт 2012 оны 4 сард зохион байгуулагдсан Завханмандал, Шилүүстэй сумын сургууль дахь сургалтад төслийн баг мониторинг хийсэн. Мөн, 2012 оны 10 сард зохион байгуулагдсан Тэс сумын сургууль дахь сургалтад ЖАЙКА-гийн төслийн эцсийн шатны үнэлгээний багтай хамт төслийн багаас менежер Т.Иший очиж танилцсан.

4) Skype мессенжер ашиглахад зориулсан хэрэгслийг олгов

Төслийн явцын үнэлгээний багийн зөвлөснөөр эдгээр загвар аймаг, дүүрэг, загвар сургуулийн багшлахуйн арга зүйг зохион байгуулах ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор, мэргэжлийн баг болон загвар аймаг, дүүрэг, загвар сургуулиуд өөр хоорондоо Skype мессенжерээр харилцах хэрэгслийг (Вебкамер, чихэвч,) олгосон.

Төслийн бүх холбогдох хүмүүсийг Skype хаягтай болгон, хаягийн жагсаалт гаргаж, өөр хоорондоо Skype мессенжер ашиглахыг санал болгосон. Гэхдээ, төслийн холбогдох хүмүүсийн олонх нь Yahoo мессенжер ашигладаг тул Skype-д дасахгүй байх, интернетэд холбогдохгүй байх, эсвэл холболт нь тогтворгүй сургуулиуд ч цөөнгүй байсан тул Skype мессенжер ашиглах хэрэгслийг үр дүнтэй ашигласан гэхэд хэцүү юм.

(6) Үр дүн 4-тэй холбоотой үйл ажиллагаа: “Багш бэлтгэх шатанд Багш бэлтгэх шатанд суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх орчин боловсронгуй болно”

1) Багш бэлтгэдэг их сургуулиудад шинэ арга зүй нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

Багш бэлтгэдэг их сургуулиуд дахь суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх зорилгоор, мэргэжлийн багийн төлөөлөл багш бэлтгэдэг их сургуульд зориулсан модуль боловсруулж эхэлсэн.

2) Үр дүн 4-тэй холбоотой нэмэлт үйл ажиллагаа

2012 оны 9 сарын 13-14-нд МУИС-аас 6 хүн, МУБИС-аас 14 хүн, Ховд их сургуулиас 7 хүн, Архангайн багшийн коллежоос 5 хүн, Ховд их сургуулийн харъяа Баян-Өлгийн багшийн коллежоос 3 хүн, Дорнод дээд сургуулиас 3 хүн, хувийн хэвшлийн Гурван-Эрдэнэ дээд сургуулиас 2 хүнийг хамруулан сургалтын багц материалыг танилцуулах сургалтыг зохион байгуулав.

Өмнөх жил 100 орчим оролцогчтой зохион байгуулж байсан бол, оролцогчдын ойлголт өнгөцхөн төдий байсан тул төслийн гурав дахь жилд багш бэлтгэх сургалтын киррикулимийн шинэчлэлийг хариуцаж буй хүмүүсийг хамруулахыг хичээснээс гадна, боловсруулах шатандаа байсан “Хичээлийн судалгаа: Аагш бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр”-ийг танилцуулж, их дээд сургуулиудад бодитоор хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлсэн юм.

(7) Бусад үйл ажиллагаа

1) Самбар худалдан авах, нийлүүлэх, самбар төлөвлөлтийг чиглүүлэх тухай

Загвар сургуулийн багш нарын багшлах ур чадвараа дээшлүүлэх явдлыг хөндлөнгөөс дэмжих зорилгоор, төслийн эхний шат болон хоёр дахь шатны загвар сургуулиудад самбар олгосон. 2012 оны 2-3 сард бүх загвар сургуулиудаар зочлон, шаардлагатай самбарын тоог судалсан. Ингээд, нийт 152 ширхэг самбар худалдан авч, 10 сард загвар сургуулиудад илгээсэн. Мөн, самбар худалдан авахаас өмнө загвар сургуулиудын багш нарт зориулан самбар төлөвлөлтийн тухайн сургалтыг зохион байгуулсан..

Хүснэгт 3-21: Самбар олгосон сургууль болон олгосон тоо ширхэг

Аймаг/хот	Олгосон сургууль	Тоо ширхэг	Олгосон өдөр
Улаанбаатар хот	97-р сургууль	4 ш	12/Х
	12-р сургууль	6 ш	12/Х
	67-р сургууль	3 ш	11/Х
	Ирээдүй ЦС	21 ш	12/Х
Сэлэнгэ аймаг	1-р сургууль	9 ш	14/Х
	4-р сургууль	5 ш	14/Х
	Хушаат сумын сургууль	7 ш	14/Х
Дорнод аймаг	5-р сургууль	8 ш	16/Х
	Хан-Уул ЦС	9 ш	16/Х
	Матад сумын сургууль	6 ш	16/Х
Булган аймаг	1-р сургууль	9 ш	15/Х
	Сэлэнгэ сумын сургууль	3 ш	15/Х
	Хутаг-Өндөр сумын сургууль	6 ш	15/Х
	Хишиг-Өндөр сумын сургууль	10 ш	15/Х
	Гурванбулаг сумын сургууль	7 ш	15/Х
Завхан аймаг	Чандмань-Эрдэнэ ЦС	2 ш	18/Х
	Шилүүстэй сумын сургууль	9 ш	18/Х
	Завханмандал сумын сургууль	6 ш	18/Х
	Тосонцэнгэл сумын 1-р сургууль	6 ш	18/Х
	Сонгино сумын сургууль	8 ш	18/Х
	Баянтэс сумын сургууль	8 ш	18/Х
нийт		152 ш	

Хоёр дахь жилийн Япон дахь сургалтын оролцогчид Япон багш нарын самбар төлөвлөлтөд анхаарал хандуулах болсноос хойш, самбар төлөвлөлтөө сайжруулах ажлыг сэдэв болгон сонгож, сургуульд суурилсан хичээлийн судалгаа хийдэг загвар сургуулиуд ихэссэн. Самбар олголт нь самбар төлөвлөлтөд анхаарлаа хандуулахад үр дүнгээ өгсөн.

2) ЗАН-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үндэсний хэмжээний хичээлийн судалгааны нийгэмлэг байгуулах бэлтгэл ажил

Төслийн явцын үнэлгээний багаас өгсөн зөвлөмжид тусгагдсаны дагуу бүх сургуулиудын арга зүйн судалгааг идэвхжүүлэх, тогтмолжуулахын тулд үндэсний хэмжээнд, эс бөгөөс бүсийн түвшний хичээлийн судалгааны бүтцийг бий болгон, боловсролын салбарын холбогдох хүмүүсийн хамтын ажиллагааг хөгжүүлэн, хичээлийн хөтөлбөр болон хичээлийн судалгааны дэвшилтэт жишээгээ хуваалцах боломжийг бүрдүүлэх нь чухал хэмээн үзээд, үндэсний хэмжээний хичээлийн судалгааны нийгэмлэг байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлсэн.

2012 оны 5 сард, төслийн арга зүйг түгээн дэлгэрүүлэх мэргэжилтэн мэргэжлийн багийн гишүүдэд хандан, нийгэмлэг байгуулах тухай тайлбарласан. Мөн, Индонезитэй туршлага солилцох хөтөлбөрт оролцсон гишүүн “Олон улсын хичээлийн судалгааны нийгэмлэг”-ийн хуралд (World Association of Lesson Studies 2012 International Conference) илтгэл тавьсан тухайгаа мөн оны 12 сард тайлагнасан ба уг тайлангийн хуралд оролцогчид хичээлийн судалгааны нийгэмлэг байгуулах явдлыг санал нэгтэй дэмжсэн.

3.4 ТӨСЛИЙН ГУРАВ ДАХЬ ЖИЛИЙН СУНГАГДСАН ХУГАЦААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (2013 оны 3 сар - 2013 оны 8 сар)

2012 оны 6 сард явагдсан УИХ-ын сонгуулиар шинэ засгийн газар байгуулагдсаны дараа, БМДИ байгуулагдсан зэргээр багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоонд томоохон өөрчлөлт гарсан. Мөн оны 10 сард зохион байгуулагдсан төслийн эцсийн шатны үнэлгээгээр энэхүү төслийн үйл ажиллагааг БМДИ-д шилжүүлэн өгөх хугацаанд төслийн үйл ажиллагааг сунган, төсөл дууссаны дараах тогтвортой байдлыг хангах нь зүйтэй гэж дүгнэсэн. Монгол Улсын тал албан ёсны хүсэлтээ гаргаснаар, энэхүү төслийг 6 сарын хугацаагаар сунгах тухай асуудлаар 2013 оны 1 сард хоёр талын санамж бичигт (R/D) өөрчлөлт оруулсан. Эдгээр шалтгаанаар төслийн хугацааг 2013 оны 8 сар хүртэлх хугацаагаар сунгасан болно.

(1) Японд сургалт зохион байгуулав

Шинээр байгуулагдсан БМДИ, үүрэг функцийн хувьд бэхэжсэн Боловсролын хүрээлэн болон БШУЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын холбогдох хүмүүсийн дунд өнөөг хүртэл багшлахуйн арга зүйн шинэчлэлд гар бие оролцож байгаагүй хүмүүс, нөгөө талаас боловсролын шинэчлэлд чухал үүрэг гүйцэтгэж буй цөөнгүй байсан. Энэхүү төслийн үйл ажиллагааг БМДИ-д шилжүүлэн өгөхийн хамт, өнөөг хүртэл боловсролын салбарт ЖАЙКА-гийн зүгээс үзүүлсэн дэмжлэгийг үр дүнтэй ашиглах замаар боловсролын шинэчлэлийг тогтвортой үргэлжлүүлэх зорилгоор эдгээр хүмүүсийг Япон дахь сургалтад хамруулан, Японы боловсролын тогтолцоо, боловсролын агуулгын талаарх ойлголтыг нь гүнзгийрүүлэх шаардлага бий болсон юм.

Эдгээр шалтгаанаар, төслийн гурав дахь жилд хоёр дахь удаагийн Япон дахь сургалтыг зохион байгуулсан. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах гол Сайд болох БМДИ, бодлого боловсруулах байгууллага болох БШУЯ-ны Стратеги бодлого төлөвлөлтийн газар болон Боловсролын хүрээлэнгийн төлөөллийн Япон дахь сургалтаар суралцах ёстой зүйл нь ялгаатай байсан тул дараах байдлаар 2 баг болгон хуваасан.

Хүснэгт 3-22: Гурав дахь жилийн хоёр дахь удаагийн Япон дахь сургалтын танилцуулга

Багийн нэр	Зорилтот бүлэг (Хүний тоо)	Сургалтын гол агуулга	Зохион байгуулсан хугацаа
Боловсролын тогтолцооны баг	БШУЯ: 3 МУБИС: 1 Боловсролын хүрээлэн: 6	<ul style="list-style-type: none"> • Японы боловсролын тогтолцоо товч танилцуулга • Боловсролын стандарт боловсруулах • Сурах бичиг боловсруулах • Сургуулийн менежмент • Багш бэлтгэх • Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоо • Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төвтэй танилцах • Хичээлийн судалгааны хэлэлцүүлэгт оролцох • Бага, дунд, ахлах сургуультай танилцах 	20-31/V (Японд очсон: 18/V, Нутаг буцсан: 1/VI)
Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны баг	БМДИ: 10	<ul style="list-style-type: none"> • Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоо • Токио хотын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын төвтэй танилцах • Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төвтэй танилцах • Хичээлийн судалгааны хэлэлцүүлэгт оролцох • Мэргэжилтнүүдийн үүрэг • Судлагдахууны боловсролыг дэмжих үйл ажиллагаа • Хичээлийн бэлтгэл судалгаа • Сургуулийн сургалтын төлөвлөгөө боловсруулах • Хичээлд ажиглах хийх (БУ, Математик) 	27/V-7/VI (Японд очсон: 25/V, Нутаг буцсан: 8/VI)

Энэхүү сургалтад оролцогчид “Сургалтаар дамжуулан, сургууль бол хүүхдүүдийн орон зай байх ёстой гэдгийг анзаарлаа. Монголын сургуулиуд үүдэндээ ямар нэг шагнал авсан багш, хүүхдүүдийн фото зургийг хаддаг бол, Японы сургуулиуд хүүхдэд зориулсан ямар нэг зүйл, хүүхдүүдийн бүтээлээр дүүрэн байх юм”, “Урьдчилсан хэлэлцүүлэг сургалт болон Япон дахь сургалтын эхэнд Японы боловсролын тогтолцооны талаар ойлголт авсан нь сайн хэрэг болсон. Багшлах дадлага болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын талаар ойлгоход суурь нь болж өглөө”, “Лекц уншсан багш нар дотор Монголын боловсролын талаар мэддэг хүн ч байна. Сургалтын агуулгыг Монголын

байдалд сайтар нийцүүлжээ” гэх зэрэг сэтгэгдэл хэлж байсан юм.

(2) Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулахад үзүүлсэн дэмжлэг

Төслийн эцсийн шатны үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийн дагуу, төслийн хүрээнд хэрэгжүүлсэн хичээлийн судалгааны ноу хау-г багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоонд оновчтойгоор нэвтрүүлэх зорилгоор БМДИ-ийн төлөвлөгөө боловсруулах үйл явцад оролцон, шаардлагатай дэмжлэгийг үзүүлсэн.

2013 оны 7 сарын 5-6-нд БШУЯ, Боловсролын хүрээлэн, БМДИ, НБГ-ын төлөөлөл нэг дор цуглан, төсөл дууссанаас хойш 3 жилийн дараа бага, дунд боловсролын салбарын төлөв байдал ямар түвшинд хүрэх тухай харилцан ярилцаж, БМДИ зэрэг боловсролын холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах зорилготой “Төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн уулзалт”-ыг зохион байгуулсан. Уг ажлын хэсгийн уулзалтаар мэргэжлийн багийн гишүүд болон төслийн хүрээнд бэлтгэгдсэн орон нутгийн сургагч багш нар цаашид сургалтын багц материалыг хэрхэн ашиглаж болох талаар ярилцсан бөгөөд ажлын хэсгийн уулзалтыг БМДИ эцэслэн дүгнэсэн юм (Хавсралт 8, 9-ийг үзнэ үү). Мөн, холбогдох бүх байгууллагуудад өгөх зөвлөмжийг ч нэгтгэн гаргасан болно.

(3) БМДИ-д үзүүлсэн дэмжлэг

Шинээр байгуулагдсан БМДИ-ийн арга зүйчдэд төслийн хүрээнд хэрэгжүүлсэн хичээлийн судалгааны ноу хау-ны талаар зөв ойлголт авч, түүнийг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх чадвартай суулгахын тулд тогтмол хэлэлцүүлэг сургалт, үйл ажиллагааны мониторинг хийх замаар шаардлагатай дэмжлэг үзүүлсэн. Тодорхой үйл ажиллагааны талаар доор дурьдав.

- Мэргэжлийн баг болон БМДИ-ийн танилцах уулзалт (2013 оны 1 сарын 10)
- Хичээлийн судалгааны хамтарсан мониторинг (2013 оны 3-4 сар)
- Хичээлийн судалгааны цахим хуудас ажиллуулах эрх шилжүүлэх (2013 оны 3 сараас хойш)
- БМДИ-ийн арга зүйчийн ажлын байран дээрх сургалт

Дээрх ажлын байран дээрх сургалтын зорилго бол БМДИ-ийн нэг арга зүйчид төслийн үйл ажиллагаанаас хариуцуулан, төслийн багтай хамтран дээр дурьдсан төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн уулзалт болон хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулж, төслөөр хэрэгжүүлсэн ноу хауг шилжүүлэх явдал байсан. БМДИ-ийн төсөл хариуцсан арга зүйч өмнө нь мэргэжлийн багийн гишүүн байсан ба тухайн үед хариуцаж байсан үүрэг нь нэг судлагдахууны багийн үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байсан юм. Ялангуяа, хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлыг зохион байгуулахад, янз бүрийн хүмүүстэй холбоо барих шаардлага гарч байсан бөгөөд уг ажлын байран дээрх сургалтаар

БМДИ-ийн арга зүйчид мэргэжлийн багийнхантай холбогдон ажиллах, бүх аймгийн БГ-ын хичээлийн судалгаа хариуцсан мэргэжилтнүүдтэй холбоо тогтоох боломжийг бий болгосон хэмээн үзэж байна..

(4) Мэдлэг, мэдээллээ хуваалцах семинар, ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулав

2013 оны 8 сарын 15-16-нд, Багшийн хөгжлийн төв дээр “Хүүхдийн хөгжил - Хичээлийн судалгаа сэдэвт үндэсний анхдугаар эрдэм шинжилгээний бага хурал”-ыг зохион байгууллаа. Загвар аймаг, дүүрэг болон загвар бус аймаг, дүүрэг, мэргэжлийн багийн гишүүд туршлага солилцон, хичээлийн судалгааг үндэсний хэмжээнд хэвшүүлэх, хөгжүүлэх үндэс суурийг бий болгох явдлыг зорилт болгон дэвшүүлсэн.

Сургуульд суурилсан хичээлийн судалгаа, төслийн зорилтот 8 судлагдахууны судалгаат хичээлийн 33 жишээг аман илтгэлээр, 25 жишээг ханын илтгэлээр оролцогчдод танилцуулсан. Загвар аймаг, дүүрэг холбогдох хүмүүс болон Бүх аймгийн БГ-ын хичээлийн судалгаа хариуцсан мэргэжилтэн зэрэг 130 гаруй хүн оролцсон. Бага хурлын төгсгөлд, хичээлийн судалгааг цаашид хөгжүүлэх зорилго бүхий “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (Mongolian Association of Lesson Study)” ТББ-ыг үүсгэн байгуулах тухай зарласан юм.

(5) Үр дүн 1-тэй холбоотой үйл ажиллагаа: “Бүх аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх багийн ур чадвар дээшилнэ”

1) Сургалтын багц материалыг боловсруулж дуусгав

Төслийн хүрээнд боловсруулагдсан 12 төрлийн сургалтын модулийг 2013 оны 7 сар хүртэлх хугацаанд дараах байдлаар хэвлүүлж дуусгав.

- Хичээлийн судалгааны арга зүйн үндэс: 800 ш
- Багшийн модуль (Физик, Хими, Хүн орчин, Хүн байгаль, Математик /бага/, Математик /суурь/, Мэдээлэл зүй, Төсөлт ажил) : тус бүр 800 ш
- Хичээлийн судалгаанд удирдлагын үүрэг оролцоо: 800 ш
- Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр: 800 ш
- Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент: 800 ш

2013 оны 7 сарын 5-6-нд зохион байгуулсан “Төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн уулзалт”-ын хаалтын ажиллагаан дээр “Хичээлийн судалгааны арга зүйн үндэс”, “Багшийн модуль (8 судлагдахуун)”, “Хичээлийн судалгаанд удирдлагын үүрэг оролцоо” модулиуд болон “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент”-ийн гарын авлагаас тус бүр 700 ширхэг, “Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр” модулиас 50 ширхэгийг төслийн багаас БМДИ-д хүлээлгэн өгсөн.

Дараа нь, орон нутагт 2, 3, 4 дэх жилийн сургалтыг зохион байгуулах болсон учраас, тэрхүү сургалтын материал болгон бүх БГ-уудад сургуулийн тоогоор тараасан.

Төслийн баг үлдсэн модулиудыг бүх их дээд сургуулийн номын сан болон боловсруулсан багийнханд тараасан. Мөн, 750 ширхэг “Хичээлийн судалгаа: Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр” модулийг МУИС, түүний харьяа Орхон их сургууль, МУБИС, түүний харьяа Архангайн багшийн коллежи, Баян-Өлгийн багшийн коллежи, Соёлын сургууль, Ховд их сургууль, Дорнод дээд сургууль, Боловсрол дээд сургууль, Зохиомж дээд сургууль, Дидактикийн боловсрол судалгааны төв, Гурван-Эрдэнэ дээд сургуулиудад түгээсэн.

2) Сургалтын багц материал болон хичээл ажиглалтын хуудсыг цаашид ашиглах боломжийн талаар танилцуулав

Төслийн хүрээнд, сургалтын багц материал болон хичээлийн чанарыг тодорхойлох хичээл ажиглалтын хуудсыг боловсруулан гаргасан билээ. Мөн, төслийн эхний шатанд ч хичээл ажиглалтын хуудас болон түүнийг ашиглах аргачлалын тухай нэгтгэсэн “Хичээлд мониторинг хийх зөвлөмж”-ийг боловсруулсан юм. Төслийн эцсийн шатны үнэлгээгээр “Энэхүү төсөлд ашиглагдсан “Хичээл ажиглалтын хуудас”-ыг цаашид өргөнөөр ашиглах нь зүйтэй” гэсэн зөвлөмж өгсний дагуу 2013 оны 5 сарын 1-3-нд БШУЯ-ны 4 мэргэжилтэн, Боловсролын хүрээлэнгийн 10 судлаач, БМДИ-ийн 21 арга зүйчид зориулан “Хичээлийн судалгааны семинар” зохион байгуулсан.

Монголын талтай харилцан зөвлөлдсөнөөр, хичээл ажиглалтын хуудсыг хатуу баримтлах бус, судалгаат хичээлийн зорилго зорилтод нийцүүлэн уян хатан байдлаар өөрчлөн сайжруулах шаардлага байсан тул, хичээл ажиглалтын хуудсыг танилцуулах гэхээсээ илүү “Хичээл ажиглах нүд”-ээ хөгжүүлэхэд нь зориулсан семинар зохион байгуулахаар тогтсон.

Уг семинараар нэгж хичээлийн төлөвлөлт, ээлжит хичээлийн хөтөлбөрийг хэрхэн боловсруулсан болон хичээлийн бэлтгэл судалгааг хэрхэн хийсэн тухайгаа багш нар танилцуулж, судалгаат хичээлүүд зохион байгуулсан. Оролцогчид хичээл ажиглалтын хуудас ашиглан хичээлд ажиглалт хийж, хэлэлцүүлэгт оролцсон бөгөөд сургагч багш нарын чиглүүлгийн дагуу хичээлийн хөтөлбөрөө сайжруулсан. Дараа нь, сургалтын багц материал зэрэг төслийн эцсийн бүтээгдэхүүнийг цаашид хэрхэн ашиглах талаар санал бодло солилцсон юм. Энэхүү семинараар оролцогчдын хичээлийн судалгаа хийх хүсэл сонирхлыг дээшлүүлж чадсан ч, төслийн эхний шатнаас хойших 6 жилийн үр дүнг 1 өдөр хагасын хугацаанд эзэмшинэ гэдэг боломжгүй бөгөөд цаашид багш нарын хичээл зүтгэл, оролдлого чухал юм.

3) Суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгаа ноу хау-д суралцахад зориулсан технологийн дэмжлэг үзүүлэв

БМДИ, Боловсролын хүрээлэн болон НБГ-ын төлөөлөлд зориулан хичээлийн бэлтгэл

судалгааны хэлэлцүүлэг сургалтыг тогтмол зохион байгуулж, шинэ арга зүй болон хичээлийн судалгааны талаарх ойлголтыг нь аажмаар гүнзгийрүүлэх зорилгоор хэлэлцүүлэг сургалтууд зохион байгуулсан.

а. Байгалийн ухааны хэлэлцүүлэг сургалт

МУИС-ийн Физик электроникийн сургуульд харъяалагддаг мэргэжлийн багийн гишүүн, тус төслийн багшлахуйн арга зүй түгээн дэлгэрүүлэх мэргэжилтэнтэй хамтран анхны хэлэлцүүлэг сургалтыг 2013 оны 1 сарын 28-наас 2 сарын 1-нд, хоёр дахь удаагийн хэлэлцүүлэг сургалтыг 5 сарын 1 болон 3-4-нд зохион байгуулсан. Хэлэлцүүлэг сургалтуудад, гарын доорх материал ашигласан сорил туршилт хийсэн юм.

б. Бага ангийн Математикийн хэлэлцүүлэг сургалт

Японы залуу сайн дурын гишүүний дэмжлэгтэйгээр дараах хөтөлбөрийн дагуу сард нэг удаа хэлэлцүүлэг сургалт зохион байгуулж байсан. Удаа дараа бараг адилхан оролцогчид тогтмол оролцсон бөгөөд НБГ-аас зохион байгуулдаг сургалтад сургагч багшаар ажилладаг багш нар тун их идэвх зүтгэл гарган оролцсон юм. Хэлэлцүүлэг сургалтад оролцож байсан Боловсролын хүрээлэнгийн судлаачид болон мэргэжлийн багийн гишүүдийн дунд сурах бичиг боловсруулагчид ч байсан тул хэлэлцүүлэг сургалтаар дамжуулан өдөр тутмын хичээлд шууд ашиглах боломжтойгоос гадна хүүхдийн хөгжлийн үе шатанд тохирсон агуулгыг зохиох, агуулгын холбоосыг гаргах зэргийг ч хөндсөн.

Хүснэгт 3-23: Бага ангийн Математикийн хэлэлцүүлэг сургалтын товч танилцуулга

№	Хөтөлбөр	Дэвшүүлсэн сэдэв
1	28/I-1/II	Бутархай тооны нэмэх, хасах үйлдэл болон трапецийн талбай
2	23/II	Үржүүлэх үйлдэл
3	11/IV	2 оронтой тоог 1 оронтой тоогоор үржүүлэх, олон оронтой тоог 1 оронтой тоогоор үржүүлэх
4	4/V	Биетийн гадаргуун талбай
5	13/VI	Япон дахь сургалтаар сурч мэдсэнээ хуваалцах, хичээлийн хэрэглэгдэхүүнийг сонгох аргачлал

4) Мэдээллийн хэрэгсэл ашиглан ээлжит хичээлийн хөтөлбөрийн жишээ туршлагаа нийт багш нарт танилцуулах, сургалчлах арга замыг эрэлхийлэх нь

Хэдийгээр бүх сургуулиуд хичээлийн судалгаа зохион байгуулдаг болсон ч, гаднаас тэргүүний жишээ туршлага, санал санаачлагыг байнга нэвтрүүлж байхгүй бол хичээлийн судалгааны нэгэн хэвийн үйл ажиллагааг дахин давтан хийлээ гээд багшлахуйн арга зүйн хөгжил нь тодорхой нэг түвшнээс илүү гарахгүй. Иймд, хичээлийн судалгаа болон хичээлийн хөтөлбөрийн сайн жишээгээ өргөнөөр танилцуулах нь зүйтэй. Ялангуяа, бусад сургуулиудын хичээлийн судалгааны үйл ажиллагаатай танилцах боломж нь хязгаарлагдмал хөдөө орон нутгийн сургуулиудын хувьд мэдээллийн хэрэгслээр

дамжуулан шинэ мэдээлэл олж авах явдал чухал юм.

Иймд, төслийн хүрээнд “Багш” сонинд цуврал нийтлэл хэвлүүлэх замаар загвар сургуулиудын хичээлийн судалгаа болон сайн хичээлийн хөтөлбөрүүдээс танилцуулсан.

Хүснэгт 3-24: Багш сонин

	№	Судлагдахуун	Анги	Хичээлийн сэдэв	З/б-сан сургууль
15/III-ны дугаар	211	Хими	9-р анги	Нэгдүгээр бүлгийн элементийн устай харилцан үйлчлэх урвал	2012 оны 11 сарын 8: 45-р сургууль
30/III-ны дугаар	212	Дунд ангийн Математик	8-р анги	Параллелограммын талбайг олох нь	2011 оны 2 сарын 28: Сэлэнгэ сумын сургууль
15/IV-ны дугаар	213	Бага ангийн Математик	4-р анги	Сая хүртэлх тоо	2012 оны 9 сарын 19: Завханмандал сумын сургууль
30/IV-ны дугаар	214	Хүн байгаль	4-р анги	Яагаад өдөр шөнө болдог вэ?	2011 оны 11 сарын 14: Хан-Уул ЦС
15/V-ны дугаар	215	Физик	7-р анги	Дулааны мэдрэмж	2012 оны 11 сарын 12: Чандмань-Эрдэнэ ЦС
30/IV-ны дугаар	216	Төсөлт ажил	5-р анги	Малын ашиг шим	2013 оны 4 сарын 21: Тосонцэнгэл сумын 1-р сургууль
15/VI-ны дугаар	217	Хүн орчин, Мэдээлэл зүй	3-р анги 9-р анги	Монгол орны дархан цаазат ан амьтад Үүрэн холбооны технологи	2011 оны 2 сар: Чандмань-Эрдэнэ ЦС 2013 оны 4 сар: Чандмань-Эрдэнэ ЦС

(б) Үр дүн 2-той холбоотой үйл ажиллагаа: “Загвар аймаг, дүүрэгт хичээлийн судалгааны загвар бий болно”

2012 оны 12 сарын 11-ны БШУ-ны Сайдын А/175 тоот тушаалаар сурагчдын өвлийн амралтыг сунгах болснын улмаас, загвар сургуулиудын хичээлийн судалгааны мониторингийг төлөвлөгөө ёсоор 2013 оны 2 сард зохион байгуулахад хүндрэл учирсан.

Нөгөө талаас, хичээлийн судалгааны мониторинг нь БМДИ-ийн мэргэжилтнүүдийн хувьд хичээлийн судалгаанд суралцах нэгэн боломж бөгөөд сургуулиудын бодит байдалтай танилцан, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулахад хэрэг болохуйц мэдээлэл олж авах бас нэгэн боломж юм. Ингээд 2013 оны 3-4 сард, БМДИ-ийн арга зүйчдийг мэргэжлийн багийнхантай хамт явуулах байдлаар тав дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийг зохион байгуулсан.

Хүснэгт 3-25: Тав дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийн товч танилцуулга /2013/

Загвар аймаг, дүүрэг	Хөтөлбөр	баг 1		баг 2	
СХД	3-5/IV 23-29/IV	Сургууль бүр 8 судлагдахуунаар тус бүр 1 удаа			
Булган	24-29/III	Сэлэнгэ, 1-р сургууль, Хутаг-Өндөр	Бага ангийн Математик, Дунд ангийн	Гурванбулаг, Хишиг-Өндөр, 1-р сургууль	Физик, Хими, Хүн орчин,

			Математик, Мэдээлэл зүй, Төсөлт ажил, Удирдлага		Хүн байгаль, Удирдлага
Завхан	15-22/IV	Чандмань-Эрдэнэ, Сонгино, Баянтэс	Физик, Хими, Хүн байгаль, Мэдээлэл зүй, Удирдлага	Шилүүстэй, Завханмандал, Тосонцэнгэл	Хүн орчин, Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Төсөлт ажил, Удирдлага

(7) Үр дүн 4-тэй холбоотой үйл ажиллагаа: “Багш бэлтгэх шатанд Багш бэлтгэх шатанд суралцахууд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх орчин боловсронгуй болно”

1) Хичээлийн судалгааны олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцохыг дэмжив

Төслийн явцын үнэлгээний баг болон төслийн эцсийн шатны үнэлгээний багийн зөвлөмжид тусгагдсаны дагуу Монгол Улсад хичээлийн судалгааг түлхүү зохион байгуулах орчин бүрдүүлэхийн тулд, боловсролын салбарын холбогдох хүмүүсийн хамтын ажиллагааг хөгжүүлэн, хичээлийн хөтөлбөр болон хичээлийн судалгааны тэргүүний жишээ туршлагаа хуваалцах орчин нөхцлийг бий болгох нь чухал юм.

Төслийн хүрээнд, мэргэжлийн багийн гишүүдийн хичээлийн судалгааны олон улсын эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөнд оролцох явдлыг дэмжиж ажилласан. Үүний үр дүнд, 8 сарын 10-11-нд, Японы Хоккайдо мужид зохиогдсон “Японы байгалийн ухааны боловсролын 63 удаагийн эрдэм шинжилгээний хурал”-д Физикийн баг²⁸, Хүн орчин баг²⁹-аас тус бүр нэг гишүүн оролцож, Монгол дахь үйл ажиллагааны талаар илтгэл тавьсан юм.

2) “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (Mongolian Association of Lesson Study)” байгуулна

2013 оны 8 сарын 15-16-нд зохион байгуулагдсан “Хичээлийн судалгааны эрдэм

²⁸ M.Ganbat, J.Dulguun, Kamata Masahiro “Education Problem Curriculum-Study in Physics Lesson and Teacher’s Development” and T.Amartaivan, J.Dulguun, Fukuchi Akiteru “Education problems, curriculum –What we know from the black box experiment?”

²⁹ E.Munguntulga, Fukuchi Akiteru “The Problems of Teaching and Learning Process of Natural Science at the Elementary School in Mongolia (Монголын бага ангийн байгалийн ухааны боловсролын багшлахуйн болон суралцахуйн тулгамдсан асуудлууд)” and G.Punsalpaamuu^A, A.Perlee-Oidov, Ts.Khongorzul, E.Batchuluun, Ts.Ser-Od, E.Munguntulga “The Issues of Preparing Teacher of Natural Science in Mongolian State University of Education (МУБИС-ийн багш бэлтгэх сургалтын өнөөгийн байдал)”

шинжилгээний анхдугаар бага хурал” дээр “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (Mongolian Association of Lesson Study)”-ийг байгуулах тухай зарласан. 9 сард тус нийгэмлэгийг ТББ хэлбэрээр байгуулах хүсэлт гаргахаар төлөвлөсөн бөгөөд 8 сарын 27-нд удирдах зөвлөлийн хурлаа хийн, удирдах зөвлөлийн гишүүн болон байгууллагын дүрмийн талаар ярилцсан. Удирдах зөвлөлийн хурал дээр тохиролцсон үйл ажиллагааны чиглэлийг доор үзүүлэв.

- Нийгэмлэгийн нэр: “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг” (Mongolian Association of Lesson Study)
- Нийгэмлэгийн үүрэг: Судалгаанд суурилсан хичээл, суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил
- Нийгэмлэгийн зорилт: Хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх замаар суралцахуйн чанарыг дээшлүүлэх явдалд дэмжлэг үзүүлэх.
- Нийгэмлэгийн үйл ажиллагааны чиглэл:
 - 1) Боловсролын судалгаа, суралцахуйн судалгаа
 - 2) Багш бэлтгэдэг их дээд сургууль болон ЕБС-ийн багш нар, судлаачдын хамтын ажиллагаа
 - 3) Ажлын байран дээр багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа
 - 4) Сургалт, судалгаа, мониторинг, зөвлөгөө, туршлага солилцоо
 - 5) Гадаадын улс орнуудтай харилцах, хамтран ажиллах

Нийгэмлэг байгуулахтай холбогдуулан БМДИ нь ажлын байраар хангах, төслийн нэг ажилтныг гүйцэтгэх захирлаар ажиллуулах тал дээр хамтран ажиллах тухайгаа илэрхийлсэн.

Нийгэмлэг байгуулагдахыг төслийн эхний шатны ажлын хэсэг (Одоогийн мэргэжлийн баг) хүсэн хүлээж байсан юм. Мэргэжлийн багийн гишүүд янз бүрийн байгууллагад ажилладаг бөгөөд төсөл дуусахад хамтын ажиллагаа та сарна. Цаашид хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд ийм зохион байгуулалт хийх шаардлагатай гэж үзэж иржээ. Мөн, ЕБС болон их дээд сургууль, судалгааны байгууллагын уялдаа холбоо бий болсон нь төслийн эхний шатны үр дүн гэдгээрээ олонд танигдсан бөгөөд уг нийгэмлэг үүнийг үргэлжлүүлэн, дунд сургуулийн багш болон их дээд сургуулийн багш нарын хамтарсан судалгааг дэмжиж ажиллах юм. Ингэснээр, багшийн мэргэжил мэргэшлийн ур чадвар дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахын хамт, судлаачдын хувьд сургуулийн талаар мэдлэг мэдээлэлтэй байж, боловсролын стандарт, хөтөлбөр, сурах бичиг боловсруулахад тусгах боломжийг бий болгоно.

БҮЛЭГ IV БУСАД

4.1 Хамтарсан зөвлөлийн хурлыг (ЖСС) зохион байгуулав

(1) Анхны Хамтарсан зөвлөлийн хурал

2011 оны 5 сарын 26-нд, төслийн удирдагч болох БСШУЯ-ны Дэд сайд, БСШУЯ-ны төслийн зохицуулагч, ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Мэргэжлийн багийн гишүүд цуглан “Анхны Хамтарсан зөвлөлийн хурал”-ыг зохион байгуулсан. Энэхүү хурлаар, эхлээд төслийн эхний жилийн үйл ажиллагааны танилцуулга хийн, сургалтын багц материал боловсруулах талаар санал бодлоо солилцон, Монголын талын хариуцах дотоод дахь зардал төсвийн талаар ярилцаж, мэргэжлийн багийн гишүүдийг танилцуулсан. Дараа нь, төсөл эхлэх үед тодорхой тоон үзүүлэлт тавигдаагүй байсан төслийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хэлэлцэн, тоон үзүүлэлт оруулсан. Үр дүн 4-ийн шалгуур үзүүлэлт болох “Багш нарын ур чадварын уралдааны нэг шалгуурт, Багшлахуйн арга зүйг хэрэгжүүлэх гэж оруулах” гэсний тухайд, өнөөг хүртэлх багшийн ур чадварын уралдаан нь багш нарын хамтын ажиллагаанд саад учруулж байгаагийн зэрэгцээ, шагнал авахын тулд арга зүйгээ хөгжүүлэх нь суралцахуйд суурилсан багшлах арга зүйн үзэл санаанд үл нийцнэ гэх мэт санал гарсан тул, энэ шалгуур үзүүлэлтийг хасах болсон (Төслийн хүрэх үр дүнгийн хураангуй²-г Хавсралт 10-аас үзнэ үү). Мөн, хоёр дахь жилийн үйл ажиллагааны тухай танилцуулсны дараа, төслийн үр дүнгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх аргын талаар хэлэлцсэн.

(2) Хоёр дахь удаагийн Хамтарсан зөвлөлийн хурал

2011 оны 9 сарын 21-нд, төслийн дунд хугацааны үнэлгээ судалгааны үр дүнг хэлэлцэх зорилгоор “Хоёр дахь удаагийн хамтарсан зөвлөлийн хурал”-ыг зохион байгуулав. Төслийн дунд хугацааны үнэлгээ судалгааны үр дүнг дараах байдлаар танилцуулья.

Энэхүү төсөл нь төслийн зорилго болон эрхэм зорилгыг биелүүлэхийн тулд амжилттай хэрэгжиж байна. Ялангуяа, тус төслийн гол цөм болсон мэргэжлийн багийн боловсон хүчнийг бэлтгэх ажил амжилттай явагдан, маш өндөр ур чадвар эзэмшсэн. Түүний үр дүнд, тэдний чиглүүлгээр загвар аймаг, дүүргийн багийн гишүүд болон загвар сургуулийн удирдлага, багш нарын хүсэл эрмэлзэл дээшилж, “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй”, “Хичээлийн судалгаа”-г маш идэвхтэй зохион байгуулах болсон.

Гэвч, төслийн үйл ажиллагааны хүрээнд эрхэм зорилгыг биелүүлэх нь хүндрэлтэй гэж үзэж буй тул, цаашид бодлого, төсөв санхүү, боловсон хүчин гэсэн 3 асуудлаар дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэн, түүнийг бэхжүүлэх шаардлагатай байна. Мөн, загвар болон загвар бус сургууль, загвар болон загвар бус аймаг, дүүргийн уялдаа холбоог ч улам бүр дэмжиж ажиллах шаардлагатай юм.

Төслийн дунд хугацааны үнэлгээ судалгааны үр дүнд тулгуурлан, төслийн үлдсэн

хугацаанд шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын талаар 6 зөвлөмж гаргасан. Зөвлөмжийн агуулга болон төслийн үйл ажиллагааг доорх хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 4-1: Зөвлөмжийн агуулга ба төслийн үйл ажиллагаа

	Зөвлөмжийн агуулга	Төслийн үйл ажиллагаа
1	<u>Цөм боловсон хүчнийг (Мэргэжлийн баг) ашиглах:</u> БШУЯ нь эдгээр боловсон хүчнийг ялангуяа төсөл дууссаны дараа ч Монгол Улс дахь багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын чухал боловсон хүчин хэмээн үзэж ашиглахын зэрэгцээ, тодорхой зохион байгуулалтад оруулах нь зүйтэй. Мөн, тэдний цалин хөлсийг (Орон нутагт томиллолтоор явах үеийн томилолтын хөлс, буудаллах зардал зэрэг) сайжруулах, тус төсөлд оролцсон туршлагыг нь албан тушаал, зэрэг хэргэм ахиж дэвшихэд нь харгалзан үзэх.	<ul style="list-style-type: none"> • БМДИ нь шинээр бүрдүүлэх “Үндэсний сургагч багш нарын баг”, түүний зөвлөхөөр мэргэжлийн багийг ашиглах шийдвэр гаргав. • 2013 оны 8 сард, төслийн хүрээнд тодорхой шалгуурт үндэслэн мэргэжлийн багийн гишүүдэд “Эксперт”, “Зөвлөх”, “Үндэсний сургагч багш” гэсэн батламж, аймаг, дүүргийн багийн гишүүдэд “Бүсийн сургагч багш” гэсэн батламж гардуулсан.
2	<u>Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн арга хэмжээ:</u> (1) БШУЯ болон мэргэжлийн баг - БГ - Сургуулийн холбоо харилцааг бэхжүүлэх, (2) Загвар аймаг, дүүрэг - Загвар бус аймаг, дүүргийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, (3) Загвар сургууль - Загвар бус сургуулийн хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай. Ялангуяа, зорчход брхшээлтэй бүсийн сургууль болон нийслэл, аймаг, дүүргийн холбоо харилцаанд Мэдээлэл харилцааны технологи (Skype гэх мэт) ашиглах нь үр дүнтэй.	<ul style="list-style-type: none"> • (2)-ын тухайд, гурав дахь жилээс загвар аймаг, дүүргийн зүгээс загвар бус аймаг, дүүрэгт зориулсан сургалт, хичээлийн судалгааны мониторингийг зохион байгуулсан. Үр дүнд нь эрхэм зорилго биелэгдэх магадлал өндөрсөн. • Мэргэжлийн баг болон загвар аймаг, дүүрэг, загвар сургуульд Skype ашиглах хэрэгсэл (Вебкамер, чихэвч) олгосон боловч, Skype ашиглаж дасаагүй, орон нутагт интернетэд холбогдоогүй сургууль байсны улмаас тийм ч үр дүнтэй ажил болж чадаагүй
3	<u>Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг багш бэлтгэх сургалтад нэвтрүүлэх нь:</u> Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг багш бэлтгэх сургалтад нэвтрүүлэх зорилгоор багшлах дадлагыг загвар сургуулиуд дээр зохион байгуулах, эсвэл хичээлийн судалгааг багш бэлтгэх сургалтад хичээл болгон оруулах зэрэг системтэй үйл ажиллагааг зохион байгуулах.	Багш бэлтгэх сургалтад хичээлийн судалгааны хичээл оруулах зорилготой “Хичээлийн судалгаа: Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр”-ийг боловсруулсан.
4	<u>Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтаар сурагчийн түвшинд үр дүн гаргах:</u> Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын эцсийн зорилго нь өндөр чанар, үр дүнтэй хичээлийг сурагчдад зориулан зохион байгуулах явдал юм. Мэдээж, сурагчдад үзүүлсэн үр нөлөөг хэмжихэд цаг хугацаа шаардахын зэрэгцээ, олон янзын хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай бөгөөд ийм оролдлогуудыг туршиж хэрэгтэй. БШУЯ-ны удирдлага санаачлагаар, сурагчийн өөрчлөлтийг хэмжих туршилт хийх нь зүйтэй.	2011 онд Завхан аймгийн БСГ-аас зохион байгуулсан суралцах чадвар төстийн үр дүнг загвар бус 25 сургууль болон загвар 6 сургуулиар ялан, сурагчдын суралцах чадварыг харьцуулж үзсэн.
5	Хөрш зэргэлдээ Азийн орнууд болон бусад улстай мэдлэг мэдээлэл хуваалцах: ЖАЙКА нь хөрш зэргэлдээ Азийн орнуудтай хамтран мөн адил техникийн хамтын ажиллагааны	• 2012 оны 5 сард Индонези Улсад айлчлан, ЖАЙКА-гийн “Анхан шатны дунд боловсролын чанарыг дээшлүүлэх төсөл”-ийн холбогдох хүмүүстэй туршлага

	төслүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр улстай технологи солилцох нь Монголын талд үр дүнгээ өгөх юм. Мөн, хичээлийн судалгаагай холбоотой Монголын дэвшилттэй үйл ажиллагаагаа бусад улс оронд танилцуулснаар, Монголын талын өөрийн санаачлагыг дээшлүүлэх, ур чадварыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж чадна.	солилцсон. Үүний үр дүнд, Монголын талын гол хамтран ажиллагчдын дунд өөрсдийн үйл ажиллагааг танилцуулах уулзалт зохион байгуулан, бусад оронд таниулах хүсэл эрмэлзэл нь дээшилсэн. • Хичээлийн судалгааны олон улсын бага хуралд гол хамтран ажиллагч оролцох явдлыг хөхүүлэн дэмжсэн.
6	<u>БШУЯ, холбогдох байгууллага, бусад донортой мэдлэг мэдээлэл хуваалцах:</u> Энэхүү төслөөр олж авсан шинэ мэдлэг мэдээлэл, туршлага сургамжаа БШУЯ-ны газар хэлтсүүд, холбогдох байгууллага болон бусад доноруудтай хуваалцах нь туйлын чухал юм. Мөн, төслийн сүүлийн жилд “Мэдлэг мэдээллээ хуваалцах ажлын хэсгийн уулзалт семинар”-ыг зохион байгуулах нь зүйтэй.	2013 оны 8 сард “Хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал”-ыг зохион байгуулсан бөгөөд энэхүү хуралд БШУЯ болон холбогдох байгууллага, бусад доноруудын төлөөл оролцсон.

Мөн, энэхүү хурал дээр төслийн хүрэх үр дүнгийн хураангуйд өөрчлөлт оруулах санал хүлээн авсан. Өөрчлөгдсөн зүйлүүдийг доорх хүснэгтэд нэгтгэв (Хавсралт 11-ийг үзнэ үү).

Хүснэгт 4-2: Төслийн хүрэх үр дүнгийн хураангуйд оруулах засвар

Өөрчлөлт оруулах зүйл	Өөрчлөлт оруулсан шалтгаан	Өөрчлөлт оруулсны дараа
Хэтийн зорилго дэвшүүлэх	Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтаар, ирээдүйд хүүхэд сурагчдын өөрчлөлтийн (Сурлагын амжилт, анги дэвшилт, сургууль завсардалт, төгсөлт) үр нөлөө, өөрчлөлт, үр дүнгийн талаар тайлбар өгөх хариуцлага хүлээсэн. Мөн, “Мянганы хөгжлийн зорилт (Millennium Development Goals: MDGs), Бүх нийтийн боловсрол (Education for All: EFA)”-д хувь нэмэр оруулахыг уг хэтийн зорилгод тусгасан.	Хэтийн зорилго: Бага болон дунд сургуулийн сурагчдын сурлагын амжилт дээшилсэн байна. (Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлэхэд хувь нэмэр оруулна)
Эрхэм зорилгын шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах	“Шалгуур 1: Загвар бус аймаг, дүүргийн сургуулиудын 50-иас доошгүй хувь нь жилд 2-оос дээш удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан байх”, “Шалгуур 2: Загвар аймаг, дүүргийн сургуулиудын 50 хувь нь суралцахууд суурилсан багшлах арга зүйн сургалт зохион байгуулсан байх” гэдэг үндэсний хэмжээнд хамаарахгүй байсан. 50 хувь нь зохион байгуулсан гэх биелэлтээр эрхэм зорилго биелэгдсэн гэхэд бэрх.	Шалгуур 1: Монгол улсын бүх сургуулийн 60 хувь нь жилд 2-оос доошгүй удаа “Хичээлийн судалгаа” зохион байгуулсан байх. Шалгуур 2: Багшлах арга зүйн сургалтыг бүх аймаг, дүүрэгт зохион байгуулсан байх.
Төслийн зорилгын шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах	Чанарыг хангах болон тогтолцоо бий болгох шалгуур байхгүй байсан тул шалгуур үзүүлэлтийг нэмэх. Мөн, шалгуур 2, 3-т “Загвар аймаг, дүүргийн загвар бус сургуулиудын 50-иас доошгүй хувь нь жилд 2-оос доошгүй	Шалгуур 1: Загвар сургуулиудын 8 судлагдахууны багшлах арга зүй сайжирсанаар хичээлийн чанар дээшилсэн байх. Шалгуур 2: Загвар аймаг, дүүргийн сургуулиудын 70-аас доошгүй хувь нь

	удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан байх”, “Загвар бус аймаг, дүүргийн БСГ-уудын 50-иас доошгүй хувь нь багшлах арга зүйн сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан байх” гэсэн бөгөөд төслийн зорилго биелэхтэй холбоогүй байсан тул тоо үзүүлэлт нэмж оруулсан.	жилд 2-оос доошгүй удаа “Хичээлийн судалгаа” зохион байгуулсан байх. Шалгуур 3: Бүх аймаг/дүүргийн БСГ/БХ-үүд багшлах арга зүйн сургалтын төлөвлөгөө боловсруулах. Шалгуур 4: БШУЯ нь бодлого, санхүү, хүний нөөцийн дэмжлэг үзүүлэх хүчин чармайлт гаргасан байх (Суралцахууд суурилсан багшлах арга зүй түгээн дэлгэрүүлэх Сайдын тушаал гаргах).
Үр дүн 3-ын шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах	Дээрх өөрчлөлтөд нийцүүлэн Үр дүн 3-ын шалгуур үзүүлэлтийг өөрчлөх.	Шалгуур 1: Загвар аймаг, дүүргийн сургуулиудын багш, удирдлагын 70-иас доошгүй хувь нь багшлах арга зүйн модульт сургалтад хамрагдсан байх. Шалгуур 2: Загвар аймаг, дүүргийн сургуулиудын 80-иас доошгүй хувь хичээлийн судалгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан байх.
Үр дүн 4 болон шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах	Үр дүн 4 нь төслийн зорилго, агуулгатай давхцаж байгаа, улмаар багш бэлтгэх сургалтад суралцахууд суурилсан багшлах арга зүйг нэвтрүүлэхэд зохион байгуулалтын ажлууд шаардлагатай тул Үр дүн 4 болон шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах.	Үр дүн 4: Багш бэлтгэх сургалт дахь Үр дүн 3-ын суралцахууд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх орчин боловсронгуй болно. Шалгуур 1: Багш бэлтгэдэг их дээд сургуулиудад сургалтын модулийн “Багшлах арга зүй”-г нэвтрүүлсэн байх.

(3) Гурав дахь удаагийн Хамтарсан зөвлөлийн хурал

2012 оны 10 сарын 18-нд, Төслийн эцсийн шатны үнэлгээ судалгааны үр дүн тайнлцуулах зорилгоор Гурав дахь удаагийн Хамтарсан зөвлөлийн хурлыг зохион байгуулсан. Төслийн эцсийн шатны үнэлгээ судалгааны багийн дүгнэлтийг доор дурьдав.

- Төслийн зорилго их төлөв биелэгдсэн. Багш нарт үзүүлсэн үр дүн нь хичээлийн судалгаагаар дамжуулан багш нарын багаар ажиллах чадварыг дээшлүүлсэн, үр дүнтэй самбар төлөвлөлтийн арга, хүүхдийн төлөв байдлыг харгалзсан хичээлийн хөтөлбөр боловсруулалт, багш нар өөр хоорондоо хичээлийнхээ талаар харилцан хэлэлцэх соёл бий болж байна. Мөн, мэргэжлийн баг болон аймаг, дүүргийн БГ/БХ (Ялангуяа мэргэжилтэн) хичээлийн судалгаанд тохиромжтой санал, зөвлөгөө өгч чаддаг болсныг дурьдаж болно.
- Мөн, БШУЯ нь 2012 оны 9 сард байгуулагдсан БМДИ дээр үндэсний хэмжээний багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулахаар төлөвлөсөн. Үүнтэй холбогдуулан, суралцахууд суурилсан багшлах арга зүй түгээн дэлгэрүүлэх үндэс суурь бүрджээ гэж болно.
- Эрхэм зорилгын тухайд, тооцоолсноос илүү үр нөлөө ажиглагдсан. Төслийн зорилгот 8 хичээлээс бусад хичээлээр ч загвар болон загвар бус аймгуудад хичээлийн судалгаа хийж байгаа, хичээлд идэвхтэй оролцох, сурч мэдэх хүсэл эрмэлзэл дээшилсэн зэргээр сурагчдад үр нөлөө үзүүлсэн, төслийн үйл ажллагаа бараг хүрээгүй зарим

загвар бус аймаг, дүүрэгт ч бие даан суралцахууд суурилсан багшлах арга зүйг сургалт, хичээлийн судалгааг зохион байгуулж байгааг дурьдаж болно.

- Гэвч, суралцахууд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны талаарх ойлголт, өөрөөр хэлбэл хичээлийн судалгааны чанар багш нар болон аймаг, дүүргийн БГ/БХ-т харилцан адилгүй байна. Мөн тогтолцоо, төсвийн тогтвортой байдлын хувьд ч БМДИ дээр суралцахууд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө боловсруулна гэж байгаа ч тодорхой боловсруулчихсан зүйл ажиглагдахгүй байна.

Эдгээрээс улбаалан, БШУЯ нь Төслийн эцсийн шатны үнэлгээ судалгааны багт хандан, суралцахууд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх зорилго бүхий төслийг сунгах хүсэлт гаргасан бөгөөд ЖАЙКА нь төслийн дараах тогтвортой байдлыг хангахын тулд төслийн хугацааг 6 сараар сунгах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан. 2013 оны 1 сард, ЖАЙКА болон Монгол Улсын БШУЯ нь гэрээнд өөрчлөлт оруулах асуудлаар санал нэгдсэн.

(4) Дөрөв дэх удаагийн Хамтарсан зөвлөлийн хурал

2013 оны 8 сарын 26-нд, төслийн биелэлтийг танилцуулахын зэрэгцээ, цаашид Монголын талын тогтвортой үйл ажиллагааг судалж үзэх зорилгоор дөрөв дэх удаагийн Хамтарсан зөвлөлийн хурлыг зохион байгуулав.

Энэхүү хурлаар, төслийн зорилго биелэгдэж, эрхэм зорилго ч зарим хэсэг нь биелэгдсэн болохыг дурьдсан. Мөн, БМДИ-ийн дэд захирлын зүгээс БМДИ-ийн арга зүйч нар, мэргэжлийн баг, БГ, орон нутгийн сургуулийн удирдлагаас бүрдсэн “Үндэсний сургагч багш нарын баг” бүрдүүлэн, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах тухай төлөвлөгөөг танилцуулсан. Уг төлөвлөгөөнөөс үзвэл, 2015-2016 оны хичээлийн жил хүртэл Монголын бага, дунд ангийн багш нарын 64% нь болох 17600 багшид зориулан багшлахуйн арга зүйн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд БМДИ-ийн үндсэн сургалтад хичээлийн судалгааг идэвхтэй ашиглахаар болжээ. Жишээлбэл, 5 дахь жилийн сургалтын хугацаа 7 хоног байсныг 10 хоног болгон өөрчилж, түүний 3 хоногийг хичээлийн судалгаанд зориулахаар төлөвлөснөө тайлагнасан (БМДИ-ийн багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг Хавсралт 9-өөс үзнэ үү).

БШУЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газраас Монголд хэрэгжиж буй боловсролын шинэчлэлийн хүрээнд зарим журамд өөрчлөлт оруулж байгаа ч, багшийн үнэлгээний нэг үзүүлэлтэд хичээлийн судалгааг оруулах төлөвлөж байгаа тухай, багш бэлтгэх сургалтад ч “Хичээлийн судалгаа: Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр”-ийг ашиглахыг хүсч буйгаа илэрхийлсэн.

Улмаар, төслийн хэрэгжилтийн зохицуулагчийн зүгээс мэргэжлийн багийн гишүүд хичээлийн судалгааг дэмжих эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах зэрэг үйл

ажиллагааг хариуцах байгууллага болгон “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (Mongolian Association of Lesson Study) ТББ”-ыг байгуулах болсон тухай, удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулах, ТББ-ыг бүртгүүлэх ажлыг төлөвлөж байгаа тухайгаа тайлагнав.

Дөрөв дэх удаагийн Хамтарсан зөвлөлийн хурлын протоколыг Хавсралт 10-аас үзнэ үү.

4.2 Төслийн анхны болон эцсийн төлөв байдлын судалгаа хийв

Төслийн Before/After болон With/Without өөрчлөлт, үр нөлөөг судлах зорилгоор “Төслийн анхны төлөв байдлын судалгаа”, “Төслийн эцсийн төлөв байдлын судалгаа”-г зохион байгуулсан билээ. Энэ тухай доор дэлгэрэнгүй танилцуулав.

(1) Төслийн анхны төлөв байдлын судалгаа хийв

2010 оны 9 сараас 2011 оны 3 сард “Мон-Эдюк Консалтинг” ХХК-д итгэмжлэн “Төслийн анхны төлөв байдлын судалгаа”-г зохион байгууллаа. Энэхүү судалгаагаар, бүх загвар аймаг, дүүрэг, загвар сургуулиас гадна төслийн хэрэгжилтийн With/Without өөрчлөлтийг харьцуулах зорилгоор Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг болон Увс, Хөвсгөл аймгуудыг сонгон, дараах чиглэлээр асуулга судалгаа, ярилцлага явуулан, хичээлийн ажиглалт зохион байгуулсан.

Хүснэгт 4-3: Үндсэн судалгаа

БСГ	Сургууль
Аймаг, дүүргийн боловсрол сургалтын талаархи үндсэн мэдээлэл	Сургуулийн талаархи үндсэн мэдээлэл
БСГ-ын тогтолцоо зохион байгуулалт	Сургуулийн удирдлага үйл ажиллагаа
БСГ-аас хэрэгжүүлэх сургалт	Сургуулийн соёл
Суралцахуйд суурилсан багшлах арга зүйн талаархи ойлголт мэдлэг	Суралцахуйд суурилсан багшлах арга зүйн талаархи ойлголт мэдлэг

Энэхүү судалгаагаар тодорхой болсон зүйлүүдийг доор дурьдав.

- Загвар болон загвар бус аймаг, дүүрэг, загвар болон загвар бус бусад сургуулиудын төлөв байдалд бараг ялгаа байхгүй.
- Хот болон орон нутаг, аймгийн төв, сумын хооронд янз бүрийн ялгаа харагдаж байна. Жишээлбэл,
 - СХД болон ЧД нь хүн амын нягтрал ихтэй, сурагч тоо олон. Нөгөө талаар, суманд нэг ээлжээр хичээллдэг сургууль ч байна.
 - Орон нутгийн сургуулиуд боловсролын чанарыг дээшлүүлэхэд идэвхтэй ажиллаж байгаагийн нөгөөтэйгүүр санхүү болон материаллаг баазын хувьд хотын сургуулиудаас хүнд байдалтай.
- Мэргэжилтнүүдийн 6.7 хувь нь багшийн ажлын туршлага 1-ээс дээш жил, 23.3 хувь нь 2-5 жил байна.

- Хотын сургуулиудад мэргэжилтнүүд жилд 2 удаа л ажиллаж байгаагийн нөгөөтэйгүүр орон нутагт жилд нэг ч удаа очиж ажиллаагүй газар ч байх юм.
- Мэргэжилтэн болон сургуулийн удирдлагын 50 орчим хувь, багш нарын 70 хувь нь төслийн эхний шатанд боловсруулсан зөвлөмжийн заримыг уншсан, ач холбогдлыг нь ойлгосон гэж хариулсан. Гэвч, уг зөвлөмж дутмаг, нааш цааш зорчиход бэрхшээлтэй байдаг, мөн зөвлөмжүүд сурах бичигтэйгээ авцалдахгүй байгаагаас хэрхэн ашиглахаа мэдэхгүй байна гэцгээж байв.
- Багшлахуйн арга зүйн тухайд, энэхүү судалгаагаар мэргэжилтэн, сургуулийн удирдлага, багш нараас асуулга судалгаа авснаас гадна хичээлд ажиглалт хийсэн. Ингээд судалгааны баг дараах анхаарвал зохих зүйлийг дурьджээ.
 - Багш сурагчдыг багаар ажиллуулан, сурагчдад асуулт тавьж байна. Гэвч, сурагчдын зүгээс ангийн бусад хүүхдүүд болон багшид хандан бараг асуулт гарахгүй байна.
 - Судалгаанд хамрагдсан багш нарын бараг тэн хагас нь “Сурагчдад юу болох буйг таамаглах, алдсан шалтгаанаа эргэцүүлэх, “Яагаад” гэдгийг сайтар бодох боломж олгодоггүй” гэж хариулжээ. Үүний шалтгааныг олонх багш “Хичээлээр заах агуулга их, бүгдийг нь заах цаг хүрэлцдэггүй” гэж тайлбарласан.

Төслийн хүрээнд ашиглаж буй хичээлийн судалгаа нь бүс болон сургуулийн онцлогтоо нийцүүлэн багшлахуйн арга зүйгээ хөгжүүлэх боломжтой арга хэрэгсэл юм. Энэхүү судалгаагаар тодорхой болсон бүсийн ялгаа нь хичээлийн судалгаагаар дамжуулан багшлахуйн арга зүйг хөгжүүлэхэд саад болохгүй гэж таамагласан. Төслийн эхний шатанд боловсруулсан зөвлөмжийг ашиглах аргын тухайд, төслөөр зохион байгуулах загвар аймаг, дүүрэгт зориулсан сургалт зэргээр дамжуулан шийдвэрлэж болох асуудал гэж үзсэн.

Нөгөө талаар, төслийн хүрээнд бүх аймаг, дүүргийн БГ/БХ-ээс зохион байгуулж ирсэн багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоог ашиглахаар тооцсон боловч, мэргэжилтнүүдийн 30 орчим хувийнх нь багшийн ажлын туршлага 5-аас доош жил байгаа байдалд, мэргэжилтнүүд сургууль дээр ажиллаж буй тоог бодоод үзвэл, БГ-аар дамжуулахад тоо чанарын аль аль нь хүндрэлтэй гэж үзсэн. Мөн, багшлахуйн арга зүйг судалсан судалгааны баг тэмдэглэснээс үзэхэд, багш хүүхдүүдийг багаар ажиллуулан, хааяахан асуулт тавихыг суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэж ойлгосон байдал харагдсан.

(2) Төслийн эцсийн төлөв байдлын судалгаа хийв

2012 оны 4-12 сард “Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг”-г итгэмжлэн даатгаж “Төслийн эцсийн төлөв байдлын судалгаа”-г зохион байгуулсан. Энэхүү судалгаа нь загвар аймаг, дүүрэг, загвар сургууль сонгосноос хойш дөнгөж жил хагасын дараа зохион байгуулсан хэдий ч, загвар аймаг, дүүргийн БГ/БХ, загвар сургуулийн холбогдох хүмүүсийн ойлголт, үйл ажиллагаанд өөрчлөлт гарсан болохыг тайланд тэмдэглэсэн байна.

Төслийн анхны төлөв байдлын судалгаагаар асуудалтай гэж үзсэн БГ-ын тухайд, загвар аймаг, дүүрэгт дараах өөрчлөлтүүд гарчээ.

- Хичээлийн судалгаа хийхийг БГ-ын үйл ажиллагааны нэг хэсэг гэж ойлгох болсон.
- Төслийн зорилтот судлагдахуун төдийгүй, бүх багш нарт зориулсан хичээлийн судалгааны сургалт зохион байгуулагдаж байна. Мөн, загвар сургуулийн багш нарыг ашиглах замаар загвар бус сургуулийн багш нарт сургалт зохион байгуулах болсон.
- Мэргэжилтнүүдийн 62 орчим хувь нь сургууль дээр ажиллахдаа багш нарт арга зүйн чиглүүлэг, зөвлөгөө өгөх цаг гаргах болсон. (Төслийн анхны төлөв байдлын судалгааны үед бараг тэн хагас нь арга зүйн талаар огт ярьдаггүй байжээ.)

Мөн, төслийн эхний шатанд боловсруулсан зөвлөмжийг загвар аймаг, дүүргийн сургуулиуд бусдаас илүү идэвхтэй ашиглаж буй байдал тодорхой болсон (Зөвлөмж уншиж судалсан мэргэжилтэн Завхан аймагт 83 хувь байсан бол, загвар бус ЧД-г дөнгөж 30 орчим хувь байв). Судалгаанд хамрагдсан багш нар “Зөвлөмжийг ашиглахтай уялдсан хүндрэлийг төслөөс зохион байгуулсан сургалтын ачаар шийдвэрлэсэн” гэж хариулсан.

Сургууль түвшний өөрчлөлтийг төслийн анхны иөлөв байдлын судалгааны үеийнхтэй харьцуулахад, олонх загвар сургуулиуд “Сургуулийн удирдлага болон багш нар багшлахуйн арга зүйн талаар нэгдмэл ойлголттой болсон” (Хутаг-Өндөр сумын сургууль дээр бүх хүн асуултад ингэж хариулсан) гэсэн байна. Харин, загвар бус сургуулиуд дээр хариулт өөр өөр байсан бөгөөд төсөл эхлэх үеийнхээс өөрчлөгдөөгүй. Мөн, загвар сургуулиуд дээр хичээл ажиглах боломж нэмэгдэн, арга зүйгээ судлах үйл ажиллагаа идэвхжсэн байдал ажиглагдсан. Тайланд дараах бусад өөрчлөлтүүдийг тэмдэглэжээ.

- Хичээлийн судалгаа нь сургуулийн бүх төрлийн төлөвлөгөө, үнэлгээнд тусгагдах болсон.
- Сургуульдаа аймаг болон бүсийн сургалтад сургагч багшаар ажиллаж чадахуйц багштай байх нь сургуулийн нэр хүндийг дээшлүүлэх, сургуулийн удирдлага болон багш нарын хариуцлагыг дээшлүүлж байна.
- Сурагчдын суралцах чадвар ч дээшилж байна. Хичээлийн судалгаа нь багшийн заах аргад эерэг нөлөө үзүүлж, энэ нь сурагчдын суралцах чадварт ч сайнаар нөлөөлж байгаа бололтой. Жишээлбэл, Булган аймгийн талаас илүү сурагчид Математик /суурь/, Физик, Химийн хичээлээр А, В (5 шатны үнэлгээний эхний 2 шат) үнэлгээ авах нөхцөл болсон.
- Загвар сургуулиуд дээр хамгийн ихээр онцолсон үр дүн бол, багш нар хамтран ажилладаг болсон, багаар ажиллахын чухлыг ойлгодог болсон явдал юм.
- Загвар сургуулиуд болон бусад сургуулиудыг харьцуулж үзэхэд, загвар сургуулиудын “Сурагчид сургуульдаа ирэх дуртай болсон” гэж хариулсан багш 40-өөс дээш хувийг эзэлжээ.

4.3 Сурталчилгааны үйл ажиллагаа

(1) Цахим хуудас

Эхний жилд, ЖАЙКА-гийн техникийн хамтын ажиллагаа төслийн цахим хуудсанд төслийн булан (<http://www.ЖАЙКА.go.jp/project/mongolia/004/index.html>) байрлуулж, нийтлэл оруулсан. Мөн, БШУЯ-ны цахим хуудсанд (<http://www.edu.gov.mn/article-406.mw>) төслийн агуулгын талаар мэдээлэл оруулсан.

Хоёр дахь жилд, ЖАЙКА-гийн техникийн хамтын ажиллагааны төслийн цахим хуудсанд мэдээлэл оруулснаас гадна, БШУЯ-ны цахим хуудсанд ч төслийн эхний шатанд боловсруулсан зөвлөмж болон хичээлийн видео материалыг оруулах бэлтгэл ажлыг хийсэн.

Гурав дахь жил мөн адил ЖАЙКА-гийн техникийн хамтын ажиллагаа төслийн цахим хуудсыг шинэчлэснээс гадна, БШУЯ-ны төсвөөр бүтээсэн “Хичээлийн судалгааны цахим хуудас”-анд мэдээлэл оруулсан.

(2) Төслийн мэдээлэл

Төслийн хугацаанд дараах байдлаар “Төслийн мэдээлэл”-ийг (Хавсралт 12) гаргав. Мөн, эхний жилд “Төслийн танилцуулга”-ыг Монгол хэл дээр 1000 хувь, Япон хэл дээр 200 хувь хэвлүүлсэн.

Хүснэгт 4-4: Төслийн мэдээлэл

	Дугаар	Хувь	Хэвлүүлсэн хугацаа
Эхний жил	№1: Монгол хэл	1000	2011 оны 3 сар
	№1: Япон хэл	100	
Хоёр дахь жил	№2: Монгол хэл	1000	2011 оны 8 сар
	№2: Япон хэл	100	
	№3: Монгол хэл	1000	2011 оны 12 сар
	№3: Япон хэл	100	
Гурав дахь жил	№4: Монгол хэл	1000	2012 оны 6 сар
	№4: Япон хэл	100	
	№5: Монгол хэл	1000	2012 оны 11 сар
	№5: Япон хэл	100	
Гурав дахь жилийн сунгасан хугацаа	№6: Монгол хэл	1000	2013 оны 2 сар
	№6: Япон хэл	100	
	№7: Монгол хэл	1000	2013 оны 8 сар
	№7: Япон хэл	100	

(3) Сонины нийтлэл

Эхний болон хоёр дахь жилд, Монголын өдөр тутмын гол сонин болох “Өнөөдөр” сонин болон “Багш” сонинд төслийн үйл ажиллагааны танилцуулгыг нийтэлсэн.

Гурав дахь жилд, Булган аймгийн БГ-ын сонинд нийтлэл хэвлүүлсэн. Төсөл сунгасан хугацаанд, “Багш” сонинд цуврал нийтлэл хэвлүүлсэн (Хавсралт 13).

4.4 ЖАЙКА-гийн бусад төсөл болон хөгжлийн бусад түнштэй уялдсан нь

(1) ЖАЙКА-гийн сайн дурын гишүүдтэй уялдсан нь

Төслийн эхний жилд боловсролын салбар дахь сайн дурын гишүүдээс бүрдэх “Ажил хэрэгч холбоо”-ныхонтой санал солилцох уулзалт зохион байгуулж, уг уулзалтын гол агуулгыг ярилцахын зэрэгцээ, төслийн талаар танилцуулан, ЖАЙКА-гийн сайн дурын гишүүдийн төсөлтэй уялдаатай ажиллах боломжийн талаар хэлэлцэв. “Сайн дурын гишүүд нь тус тусын үйл ажиллагаагаа тэргүүнд тавина” гэсэн уг уулзалтын чиглэлд үндэслэн, төслийн талаас сайн дурын гишүүдийн оролцох боломжтой сургалт, хичээлийн судалгааны мониторингийн хөтөлбөр зэргийг танилцуулан, хамтын ажиллагааны боломжийг эрэлхийлж ирсэн. Энэ үйл ажиллагаанд зарим сайн дурын гишүүд “Төслийн зүгээс мэдээлэл авах нь сайн дурын гишүүн бидний үйл ажиллагаанд нэн ач холбогдолтой юм. Зөвхөн нэг замаар л урагшлах бус, сайн дурын гишүүдээс ч төсөлд мэдээлэл дамжуулах боломж олдоосой гэж хүсч байна”, “Төслийн мэдээллээс суралцахуйд суурилсан хичээл гэж ямар хичээл болох, сайн хичээл, самбар төлөвлөлт гэж юу болох талаар олон сайн санаа оноо авч байна” гэх зэргээр эргэх холбоотой болжээ.

Гэвч, “Ажил хэрэгч холбоо” нь янз бүрийн байгууллагад томилогдон ажиллаж буй хувь хүмүүсийн цугларал бөгөөд туршлага, томилогдон ажиллаж буй байгууллага дахь байр суурь, хэлний чадвар, сонирхол нь ч өөр өөр тул, уг цугларлыг нэг байгууллага гэж ойлгон хамтрахад хүндрэлтэй байсан. Мөн, төслийг ашиглан, томилогдон ажиллаж буй байгууллагынхаа хүссэнээс илүү үйл ажиллагаанд оролцох гэсэн сайн дурын гишүүн ч байсан бөгөөд харилцахад төвөгтэй байдал ч үүсч байсан билээ.

Тус төсөл болон сайн дурын гишүүдийн уялдаа холбоог дараах 4 хэлбэрт хувааж болно.

Хүснэгт 4-5: ЖАЙКА-гийн сайн дурын гишүүд хоорондын уялдаа

Уялдаа холбооны хэлбэр	Хэрэгжүүлсэн хугацаа	Агуулга
Мэдээлэл солилцоо	2010 оны 9 сар	“Ажил хэрэгч холбоо”-тай санал солилцов.
	2010 оны 12 сар	Сэлэнгэ аймгийн 4-р сургуульд томилогдон ажиллаж байсан сайн дурын гишүүнтэй нөхөрсөг уулзалт хийв.
	2011 оны 3 сар	“Ажил хэрэгч холбоо” гишүүнтэй санал солилцов. Сэлэнгэ аймгийн 4-р сургуульд томилогдон ажиллаж байсан сайн дурын гишүүнтэй нөхөрсөг уулзалт хийв.
	2012 оны 4 сар	“Ажил хэрэгч холбоо”-тай санал солилцов
Төслийн үйл ажиллагаанд дахь хөндлөнгийн ажиглагчийн оролцоо	2010 оны 11 сар	СХД-ийн загвар сургуульд зориулсан сургалтад сайн дурын 2 гишүүн оролцов. ЖАЙКА-гийн сайн дурын гишүүн семинар сургалчлав.
	2011 оны 2-3 сар	СХД, Завхан аймгийн хичээлийн судалгааны мониторингт сайн дурын 5 гишүүн оролцов.
	2012 оны 9-10 сар	СХД, Булган аймгийн хичээлийн судалгааны мониторингт сайн дурын гишүүн оролцов.
	2012 оны 11 сар	Булган аймагт зохион байгуулагдсан Хангайн бүсийн аймгийн багуудад зориулсан сургалтад сайн дурын 4 гишүүн оролцов.

	2013 оны 3-4 сар	СХД, Булган аймгийн хичээлийн судалгааны мониторингт сайн дурын 3 гишүүн оролцов.
Хичээлийн ажиглалт	2011 оны 11 сар	Багануур дүүргийн Боловсрол ЦС-д томилогдон ажиллаж байсан сайн дурын гишүүний зохион байгуулсан “Хүн байгаль” хичээлтэй СХД-ийн загвар сургуулиудын багш нар танилцав.
	2011 оны 12 сар	БГД-ийн Сэтгэмж ЦС-д томилогдон ажиллаж байсан сайн дурын гишүүн зохион байгуулсан Физикийн хичээлтэй СХД-ийн загвар сургуулиудын багш нар танилцав.
	2012 оны 4 сар	БЗД-ийн 97-р сургуульд томилогдон ажиллаж байсан сайн дурын гишүүн, мэргэжлийн багийн гишүүний Биологийн хичээлтэй СХД-ийн загвар сургуулийн багш нар танилцсан.
	2013 оны 5 сар	Япон дахь сургалтад оролцогчид нутаг буцсан сайн дурын гишүүний ажилладаг сургуульд зочлон, Байгалийн ухааны хичээлтэй танилцсан.
Сургалт	2012 оны 6 сар	МУБИС, Сэтгэмж ЦС, 97-р сургуульд томилогдон ажиллаж байсан сайн дурын гишүүдийн туслалцаатайгаар “Хичээлийн судалгааны тайлангийн хурал”-ын үед судалгаат хичээл зохион байгуулав.
	2012 оны 11 сар	Бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтад сайн дурын 2 гишүүн мэргэжлийн багтай хамт сургагч багшаар оролцов.
	2013 оны 1-6 сар	Сайн дурын 3 гишүүний туслалцаатайгаар Математикийн /бага/ хичээлийн бэлтгэл судалгааны хэлэлцүүлэг сургалт зохион байгуулав.

Эдгээрээс, “Хичээлтэй танилцсан” явдал нь Монгол багш нар болоод сайн дурын гишүүдийн хэн хэнд нь таатай боломж байсан. Монгол багш нарын хувьд, өөрсдийн урьд өмнөх арга зүйгээр боловсрол эзэмшсэн тул, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг чухам ямар зүйл болохыг төсөөлөхөд амаргүй юм. Японд багшийн баялаг туршлага хуримтлуулсан сайн дурын гишүүдийн хичээлтэй Монгол багш нар танилцсанаар, ямар хичээл зохион байгуулах ёстой талаар тодорхой төсөөлөл авч чадсан. Мөн, сайн дурын гишүүдийн хувьд ч гаднаас хүмүүс хичээлтэй нь танилцсанаар, ажилалж буй сургуулийнх нь багш нарт “Сайн дурын гишүүний хичээлээс суралцаж болох юм байна” гэдгийг анзаарч ойлгуулах давуу талтай.

Сургалтуудын дотроос 2012 оны 6 сарын “Хичээлийн судалгааны тайлангийн хурал”-ын үед зохион байгуулсан судалгаат хичээл, 2012 оны 11 сарын бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтаар сайн дурын гишүүн өөрийн ажиллаж байсан сургуулийнхаа багштай хамтран сургагч багшаар ажилласан. Сургалтад оролцогчдын хувьд Япон багшийн арга зүйг ойроос харах боломж болсон нь мэдээжийн хэрэг, мөн сайн дурын гишүүнээс Монгол багшид технологи шилжүүлэх боломж ч болсон юм.

Сайн дурын гишүүн бүрийн зорилго, үйл ажиллагаа нь харилцан адилгүй тул, “Ажил хэрэгч холбоо”-ныхонтой мэдээлэл хуваалцаж явсаар эцсийн бүлэгтэй сайн дурын хувь гишүүдтэй төсөл уялдаатай ажиллах гэдэг хэлбэрийг буй болгосон. Эдгээрээс сайн дурын гишүүдийн үйл ажиллагааны хүрээнд боломжтой уялдаа холбоог бий болгох нь сайн дурын гишүүд болон төслийн аль алинд нь ачаалал багатай үр дүнтэй арга гэж хэлж болно.

(2) ЖАЙКА-гийн бусад төсөлтэй уялдсан нь

ЖАЙКА-гийн “Өвсний үндэс” техникийн хамтын ажиллагааны төсөл болох “Монголын орон нутгийн бага сургуулийн багш нарын чанарыг дээшлүүлэх: Бүсийн онцлогт тохируулан мэдээлэл харилцааны технологи ашиглан хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх нь” төслийн 2 ажилтан 2012 оны 2 сард Завхан аймгийн хичээлийн судалгааны мониторингт оролцсон. Мөн, уг “Өвсний үндэс” төсөл нь 2012 оны 9 сард Улаанбаатарт зохион байгуулагдсан бүх аймгийн Мэдээлэ зүй, бага боловсрол хариуцсан мэргэжилтнүүдийн сургалтад төслөө танилцуулсан.

(3) Хөгжлийн бусад түнштэй уялдсан нь

2013 оны 8 сард зохион байгуулагдсан “Хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал”-д Дэлхийн банкны “Түргэн үр дүнд хүргэх санаачлага” төсөл болон “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцсон.

БҮЛЭГ V ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГАРСАН САНАЛ САНААЧЛАГА, ТУРШЛАГА СУРГАМЖ БА ЗӨВЛӨМЖ

5.1 Төслийн хүрээнд гарсан санал санаачлага

Энэхүү төслийн зорилго нь “Бүх аймаг, дүүргийн БГ/БХ нь хуучин багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоог ашиглан, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” явдал билээ. Хуучин багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоо гэдэг нь 2008 оны БСШУ-ны Сайдын 72 тоот тушаалд заасан үндсэн сургалт (Эхний болон 5, 10 дахь жилийн сургалт) юм. Төслийн эхний шатанд боловсруулсан зөвлөмжтэй хамт ашиглах боломжтой сургалтын багц материал (Сургалтын хөтөлбөр, хичээлийн материал) боловсруулахын зэрэгцээ уг багц материалыг ашиглан сургалт зохион байгуулах чадвартай боловсон хүчин бэлтгэн, тэднийг сургалтад ашиглахаар төлөвлөжээ.

Гэвч, бодит байдал дээр зохион байгуулалт, төсвийн асуудлын улмаас тус төсөл эхэлсэн 2010 онд үндсэн сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулаагүй юм. Тиймд, тус төсөл нь БШУЯ болон загвар аймаг, дүүрэг зэрэг холбогдох байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэхийн тулд дараах санал санаачлагыг гаргасан.

(1) Загвар аймаг, дүүрэгт түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн санал санаачлага

Анх мэргэжлийн багаас аймаг, дүүргийн багт, аймаг, дүүргийн багаас загвар сургуулийн багт, загвар сургуулийн багаас загвар бус сургуульд гэсэн шаталсан хэлбэрээр багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэхээр тооцоолж байсан. Гэвч, хязгаарлагдмал хугацаанд аймаг, дүүргийн сайн баг бүрдэх баталгаа байхгүй юм. Мөн, дөнгөж 5 хоногийн сургалтаар аймаг, дүүргийн багийг бэлтгэх нь хүндрэлтэй. Иймд, тус төслийн хүрээнд мэргэжлийн багийн зүгээс аймаг, дүүргийн баг болон загвар сургуулийн багуудад шууд үйл ажиллагаа явуулах боломжийг ихэсгэхээр шийдсэн. Мөн, Япон дахь сургалтыг ч идэвхтэй ашигласан.

1) Сургалтад оролцогчдын тоог нэмэгдүүлэв

Эхний жилд зохион байгуулсан загвар аймаг, дүүргийн багт зориулсан сургалтаар, сургалтад оролцогчдыг загвар аймаг, дүүргийн баг төдийгүй, бүх загвар сургуулийн баг (Тус бүр 11 хүн) байхаар бодсон. Ингэснээр, загвар сургуулийн баг ч мэргэжлийн багийн шууд үйл ажиллагааг авах боломжтой болсон.

Гэвч, олонх загвар сургуулийн хувьд эхний жилийн сургалтад оролцсон багш нар болон бусад багш нарын хооронд багшлахуйн арга зүйн хөгжлийн тхай ойлголтын зөрүү үүслээ. “Хичээлийн судалгаа бол төсөлд оролцож байгаа багш нарын ажил” гэсэн ташаа ойлголт дэлгэрэх магадлал ажиглагдсан тул, хоёр болон гурав дахь жилийн бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтад өмнө нь сургалтад оролцож байгаагүй загвар

сургуулийн багш нарыг хамруулсан (Хоёр дахь жилд тус бүр 11 хүн, гурав дахь жилд тус бүр 10 хүн).

Загвар аймаг, дүүргээс аль болох олон оролцогч хамруулснаар багшлахуйн арга зүйн хөгжлийг манлайлан ажиллах хүмүүс нэмэгдсэний үр дүнд, загвар сургуулиудад хичээлийн судалгаа сургуулийн хэмжээний үйл ажиллагаа болж чадсан юм. Мөн, эхний жилээс зэргэлдээ сургуульдаа түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Завхан аймаг “Аймгийн баг”-аа 11 хүнээр хязгаарлалгүй олон тооны мэргэжилтнүүдийг оролцуулсан тул, аймагтаа тойрон явж сургалт зохион байгуулах зэргээр БГ нь нэгдэн ажиллаж, багшлахуйн арга зүйгээ хөгжүүлэх болсон.

Шаталсан хэлбэр нь түгээн дэлгэрүүлэх үр өгөөжтэй арга юм. Гэвч, зарим нэг хүмүүсийг тусгайлан авч үзэх нь бусад хүмүүсийн үйл ажил, хүсэл эрмэлзэлд сөргөөр нөлөөлөх аюултай учир үүнийг анхаарахгүй бол болохгүй.

2) Мэргэжлийн багийн мониторингийг ашиглав

Жилд нэг удаа 2-3 сарын үед, мэргэжлийн багаас загвар сургуулиудад мониторинг хийхээр төлөвлөсөн. Загвар сургуулиуд нь загвар аймаг, дүүргийн баг болон бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтаас сурч мэдсэнээ хэрхэн хичээлийн судалгаанд ашиглаж буйг судлах явдлыг гол зорилгоо болгосон тул, мониторингт оролцсон гишүүд, хүлээн авсан загвар сургууль, хамт явсан мэргэжилтнүүд ч энэхүү мониторингийг загвар сургуулийг үнэлэх гэж байна гэж ойлгож байсан юм. Гэвч, орон нутгийн сургуульд мэргэжилтнүүд цөөн очдог, гаднаас арга зүйн зөвлөгөө авах боломж тун хязгаарлагдмал байдаг. Тиймээс, энэхүү мониторингийг хичээлийн судалгааны хэрэгжилтийг нь судлах төдийд хязгаарлалгүй, загвар сургуулиудын үйл ажиллагааг дэмжих боломж хэмээн үзэж, мэргэжлийн багийн гишүүдэд загвар сургуулийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөхийг хүссэн. Үүний үр дүнд, загвар сургууль болон мэргэжилтнүүд мониторингийн ач холбогдлыг ойлгох болсноор мониторингийг жилд 2 удаа зохион байгуулж, төслийн хугацаанд нийт 5 удаа мониторинг зохион байгуулжээ.

Олонх загвар сургуулиуд мониторингоор үед зэргэлдээ сургуулийнхаа багш нарыг урин оролцуулах болж³⁰, ингэснээр загвар аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйг хэрэгжүүлэх ур чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсан юм.

Хичээлийн судалгааг ашиглавал, багш ажлын байран дээрээ арга зүйгээ хөгжүүлэх боломжтой. Гэвч, зөвхөн сургууль дээрээ дахин давтан зохион байгуулахад, онолын алдаагаа олж харахгүй, шинэ санаа оноо төрөхгүй зэрэг шалтгаанаар үр дүн нь бүдгэрэх магадлалтай гэсэн тулгамдсан асуудал ч байдаг. Ийм асуудлыг шийдвэрлэхийн тулд загвар сургуулиуд сургуулийнхаа бага болон дунд ангийн багш нарыг хамтран

³⁰ Завхан аймгийн хичээлийн судалгааны мониторингт Говь-Алтай (2012 оны 3 сар), Ховд аймгийн (2012 оны 9 сар) төлөөлөл ирж оролцсон.

ажиллуулах, өөр мэргэжлийн багш нарыг оролцуулах, зэргэлдээ сургуулийн багш нарыг урьж оролцуулах зэрэг арга хэмжээ авч ирсэн байна. Харин, ном гарын авлага зэргээс шинэ мэдээлэл авах боломж хязгаарлагдмал ийм байдал дунд их дээд сургуулийн багш нар болон мэргэжилтнүүд сургуулиудаар очиж ажиллан, чиглүүлэг өгөх нь хамгийн үр дүнтэй арга гэж хэлж болно.

Их дээд сургууль зэрэг судалгааны байгууллага болон БГ-тай сургуулиудын уялдаатай ажиллах шаардлагатай. Орон нутагт бол замын зардал зэрэг төсөв санхүү асуудал чухал юм.

3) Япон дахь сургалтыг ашиглав

Тус төсөл загвар аймаг, дүүргийн холбогдох хүмүүст зориулан 2 удаа Япон дахь сургалтыг зохион байгуулсан. Мөн, залуучуудын хөтөлбөр болох “Суурь боловсрол (2010 он)”, “Бага, дунд боловсрол (2011 он)”, “Бага, дундын Байгалийн ухааны боловсрол (2012 он)”-нд ч холбогдох хүмүүсийг оролцуулах боломж олдсон. Төслийн хугацаанд, бүх БГ-аас 2-4 хүн, загвар сургуулиас 3 хүн Японд очиж, бодит хичээлтэй танилцан, лекц сонссон.

Монголд “Зуун удаа сонсохоор, нэг удаа үз” гэсэн зүйр үг байдаг. Бүх загвар сургуульд Японы боловсролын бодит байдлыг нүдээр үзсэн багш 3 бий болсноор суралцахуйд суурилсан боловсролын талаарх төсөөллөө хуваалцахад дөхөм болж, загвар сургуулиудын хичээлийн судалгааны загвар бий болоход үр дүнгээ өгсөн. Ялангуяа, сургуулийн удирдлага нь Япон дахь сургалтад оролцсоны дараа, сургуулиудын багшлахуйн арга зүйгээ шинэчлэх үйл ажиллагаа идэвхжсэн байна. Японд сурч мэдсэнээ ажилдаа хэрэгжүүлэх ухамсар нэн түргэн бий болсны ач гавъяа юм.

Мөн, Япон дахь сургалтаар дамжуулан сургууль нийтээрээ “Сургуульд суурилсан хичээлийн судалгаа” зохион байгуулах явдал загвар сургуулиудад түгээмэл болсон, самбар төлөвлөлтийг сонирхон, сургуульд суурилсан хичээлийн судалгааныхаа сэдвээр сонгох болсон нь ч загвар аймаг, дүүргийн хичээлийн судалгааны загвар бий болох, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг хэрэгжүүлэх ур чадвар дээшлүүлэхэд дэмжлэг болсон.


(2) Үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн санал санаачлага

Загвар аймаг, дүүргийн үйл ажиллагаанд тулгуурлан багшлахуйн арга зүйг шинэчлэх ажлыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулагдсан. Загвар аймгийн түгээн дэлгэрүүлэх загварыг (Аймгийн баг бүрдүүлэн, аймгийн баг нь аймгийнхаа бүс бүрийн түшиц сургуульд үйл ажиллагаа явуулан, түшиц сургууль нь бүсийнхээ сургуулиудад түгээн дэлгэрүүлэх) олонх аймагт хэрэгжүүлэх боломжтой юм. Улаанбаатар хотын хувьд, анх тооцоолсон шиг бүсийн хамтын ажиллагааны тогтолцоо нь сайн ажиллахгүй байгаагаас төслийн хоёр дахь жилээс үйл ажиллагааны арга барилаа өөрчилсөн.

1) Аймгуудад түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа

Хоёр дахь жилээс эхлүүлсэн бүх “Аймаг, дүүргийн баг”-т зориулсан сургалтыг төслийн хоёр дахь шатны загвар аймаг, дүүргээс гадна БЗД, төслийн эхний шатны загвар аймаг болох Сэлэнгэ, Дорнод аймаг зэрэг 6 газарт зохион байгуулж, “Аймаг, дүүргийн баг”-ийг бэлтгэхэд анхаарч ажилласан. Сургалтад тус бүрт бүсийн онцлогоороо төстэй 3-5 аймгийн төлөөллийг оролцуулснаар, тус бүрийн байдалд нийцүүлсэн сургалтыг үр дүнтэй зохион байгуулж чадсан.

Аймаг бүрт түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг баруун талын зурагт үзүүлсэнчлэн, аймгийн баг бэлтгэн, аймгийн баг нь аймгийнхаа бүх бүсийн түшиц сургуульд үйл ажиллагаа явуулж, түшиц сургууль нь бүсийнхээ сургуулиудад түгээн дэлгэрүүлэх гэсэн хэлбэрээр зохион байгуулах боломжтой гэж үзсэн. Гэвч, Дорнод аймаг болон говь бүсийнх шиг сургуулиуд нь алслагдмал байгаа тохиолдолд, аймгийн төв дээр бүх сургуулийн төлөөллийг цуглуулан зохион байгуулах нь үр дүнтэй юм.



Анхны төлөвлөгөөгөөр бол, хоёр болон гурав дахь жилд тус бүр 1 удаа сургалт зохион байгуулах замаар загвар бус аймаг, дүүргийн “Аймаг, дүүргийн баг”-ийг бэлтгэх ёстой байсан. Гэвч, төслийн дунд хугацааны үнэлгээ судалгаагаар тэрхүү үйл ажиллагаа төдийхнөөр эрхэм зорилго биелэхэд хүндрэлтэй гэж үзээд, загвар аймаг, дүүрэг болон загвар бус аймаг, дүүргийн хамтын ажиллагааг бэхжүүлэхийг санал болгосон. Үүнтэй уялдан, гурав дахь жилд загвар аймаг, дүүргийн багаас загвар бус аймаг, дүүрэгт зориулсан сургалт, хичээлийн судалгааны мониторингийг зохион байгуулсан. Үр дүнд нь эрхэм зорилго биелэгдэх магадлал өндөрссөн.


Тодорхой бүсэд загвар бий болгосныхоо дараа, бусад бүсүүдэд түгээн дэлгэрүүлэх нь түгээмэл байдаг. Гэвч, тус төсөл нь загвар аймгуудын багшлахуйн арга зүйгээ шинэчлэх алдаа оноотой үйл ажиллагаа хэрэгжүүлж буй явцын дундаас загвар аймгаас загвар бус аймгуудад түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Ингэснээр, загвар аймгийн өөрийнх нь ур чадварыг дээшлүүлэхэд тус болохын зэрэгцээ, загвар бус аймгийн хувьд ч сайн нөлөө үзүүлж, багшлахуйн арга зүйг шинэчлэлд сонирхол хандуулахад дөхөм болсон.

2) Улаанбаатар хотод түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн санал санаачлага

Эхний жилд, Улаанбаатар хотын загвар дүүрэг болох СХД-ээс бусад 8 дүүрэгт түгээн дэлгэрүүлэхээр зорин, дүүргийн багийг бүрдүүлсэн. Гэвч, тус дүүргийн БХ нь хүчин чадал багатай, багшлахуйн арга зүйд чиглүүлэх үүрэг гүйцэтгэж чадахгүй байсан тул СХД-ийн багаас бусад дүүрэгт чиглүүлэх үйл ажиллагаа явуулах нь хүндрэлтэй болж

ирсэн.

Тиймд төслийн 2, 3 дахь жилд НБГ-тэй хамтран ажиллаж, СХД-т түшиглэн нийслэл дэх сургалтыг зохион байгуулсан. Улаанбаатар хотод дүүргээр бус, судлагдахуунаар хуваан сургалт зохион байгуулагддаг. Цаашид, Улаанбаатар хот дахь багшлахуйн арга зүйг шинэчлэлийг баруун талын зурагт үзүүлсэнчлэн зохион байгуулах нь бодит байдалд нийцэх болов уу.



НБГ нь төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтаас гадна, сайн дурын үндсэн дээр хийгдэх сургуульд суурилсан хичээлийн судалгааг дэмжсэн сургалтуудыг зохион байгуулж иржээ. Гэвч, сургуулийн тоотой нь харьцуулахад (Улсын хэмжээний нийт сургуулийн 25 орчим хувь нь Улаанбаатарт оршдог) мэргэжилтний тоо цөөн, сургалт болон сургууль дээрх үйл ажиллагаанд оролцох цаг муутай, дүүргүүдийн БХ нь тодорхой эрх мэдэлгүй зэрэг асуудлууд ч байсан.

5.2 Монголын тал өгөх зөвлөмж

Төслийн хугацааны сургамжаас гадна, 2013 оны 7 сард зохион байгуулагдсан багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн уулзалтын үеэр оролцогчдоос өгсөн саналд үндэслэн, цаашид багшлахуйн арга зүйг хөгжүүлэхэд чиглэсэн чиглэсэн зөвлөмжийг доорх байдлаар нэгтгэв.

(1) Багшийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд өгөх зөвлөмж

1) Мэргэжилтэн томилох

Мэргэжилтэн нь БГ-т харьяалагдан, хариуцсан сургуулийнхаа сургалт, менежментийн асуудлуудыг чиглүүлэх үүрэг бүхий ажил юм. Мөн, 2013 оны 8 сарын 9-ний өдрийн БШУ-ны Сайдын А/287 тоот тушаалаар Боловсролын газар тухайн аймгийнхаа багш нарт зориулсан 2, 3, 4 дэх жилийн сургалтуудыг зохион байгуулах тухай шийдвэр гаргасан бөгөөд эдгээр сургалтад чиглүүлэх үүрэгтэйгээр оролцдог. Ялангуяа, орон нутагт үндэсний түвшний сургалтын байгууллага болон их дээд сургууль зэрэг судалгааны байгууллагаас чиглүүлэг болон зөвлөгөө авах боломж хязгаарлагдмал байдгаас, мэргэжилтнүүд тухайн аймгагтаа багшлахуйн арга зүйг хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Эдүгээ, Монголд Нийслэлийн боловсролын газар болон аймгуудын БГ-ын даргын тогтоосон нөхцөлд (Суралцсан байдал, багшийн ажлын туршлага гэх мэт) үндэслэн

мэргэжилтнийг томилдог бөгөөд тус төслийн анхны төлөв байдлын судалгаагаар, судалгаанд хамрагдсан аймаг, дүүргийн мэргэжилтнүүдийн 30 орчим хувь нь багшийн ажлын туршлага 5-аас доош жил байгаа болохыг тогтоосон. Мөн, сургуулийн зүгээс зарим мэргэжилтнүүдийн судлагдахууны мэргэжлийн чадвар болон хичээл сургалтын талаар зөвлөгөө өгөх чадварт сэтгэл дундуур байгаагаар илэрхийлэх явдал хааяагүй тохиолдож байсан зэргээс үзэхэд, тэдний чанар, ур чадварыг хангалттай гэх аргагүй юм.

Үүнээс үзэхэд, БШУЯ нь мэргэжилтэн томилохтой холбогдсон тодорхой чиглэлийг илтгэн, бүх БГ-ууд нөхцөл шалгуурыг хангасан боловсон хүчнийг томилон ажиллуулах шаардлагатай болж байна. Мөн, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх асуудлыг судалж үзэх нь зүйтэй. Японд, мэргэжилтний ажлын байр нь байнгын ажил бус, удирдах ажилтан бэлтгэх сургалтын хүрээнд, эсвэл багш нарыг тодорхой хугацаанд сурган бэлтгэн туршлагажуулах зорилготой ажлын байр гэж үзэх ба сургуулиудтай уялдаатай ажиллан ур чадвараа дээшлүүлэх боломж гэж үздэг байна.

Залуу боловсон хүчнийг томилон ажиллуулах тохиолдолд, ажил үүргийнх нь зорилго, ач холбогдолыг тодорхой ойлгуулж өгөх хэрэгтэй. Жишээ нь, Токио хот 2000 онд мэргэжилтэн зэрэг боловсролын салбарын удирдах ажилтан томилон ажиллуулах тогтолцоондоо өөрчлөлт оруулж, залуучуудын (Багшийн ажлын туршлага 7-оос дээш, нас 32-оос дээш) А хувилбар, дунд насны (Багшийн ажлын туршлага 12-оос дээш, нас 39-өөс дээш) В хувилбарыг бий болгосон. А хувилбарын нь “Зохион байгуулах авьяастай, боловсролын өргөн мэдлэгтэй удирдах ажилтан бэлтгэх” зорилготой бөгөөд тэнцсэн хүнийг удирдах ажилтны туршилтын хугацаанд (5 жил) мэргэжилтнээр ажиллуулж болно гэж заажээ³¹.

Мөн, Улаанбаатар хот бол 1 сая 200 гаруй мянган хүн амтай том хот бөгөөд энд 206³² бага, дунд сургууль байдаг. Гэтэл, эдгээрийг хариуцан ажиллаж буй НБГ-ын мэргэжилтний тоо 13-аас хэтрэхгүй байна. 2016 он хүртэлх хугацаанд НБГ-ын орон тоо 35 байгааг 47 болгон өргөжүүлэх шийдвэр гарсан гэж байгаа боловч, цөөн тооны мэргэжилтнүүд өөрсдийн хариуцсан бүх сургуульд мэргэжлийн чиглүүлэг, зөвлөгөө өгөх боломжгүй юм. Дүүргүүдийн БХ-т зарим ажил үүргийг шилжүүлэх нь хүндрэлтэй байгаа тохиолдолд, НБГ-ын хүчин чадлыг улам өргөжүүлэх явдлыг нэн тэргүүний шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал гэж хэлж болно.

2) Хичээлийн судалгааны мониторинг зохион байгуулах

Тус төслийн хүрээнд, мэргэжлийн багаас загвар сургуулиудын хичээлийн судалгаанд

³¹ Боловсролын салбарын удирдах ажилтан томилох, бэлтгэх ажлыг судлах хороо “Цаашид боловсролын салбарын удирдах ажилтан, мэргэжилтэн сонгон шалгаруулах, бэлтгэх тогтолцооны талаар: Боловсролын салбарын удирдах ажилтан томилох, бэлтгэх ажлыг судлах хорооны үйл ажиллагааны эцсийн тайлан” 2008 он

(<http://www.metro.tokyo.jp/INET/KONDAN/2008/07/DATA/40i7o901.pdf>, 2013 оны 9 сарын 5)

³² Ministry of Education, Culture and Science “Statistical Year Book Education, Culture, Science and Technology”, Ulaanbaatar, 2012.

мониторинг хийж, загвар аймгийн багаас загвар бус аймгийн хичээлийн судалгаанд тус тус мониторинг хийсэн билээ.

Сургуулиудын хувьд, судалгаат хичээл зохион байгуулахдаа бага болон дунд ангийн багш нар хамтран ажиллаж, өөр мэргэжлийн багш нарыг оролцуулах, зэргэлдээ сургуулийн багш нарыг урьж оролцуулах үэрэг арга хэмжээ авснаар хичээлийн судалгааг улам идэвхжүүлж байна. Гэхдээ, хэдхэн багшийн хүрээнд хичээлийн судалгааг үргэлжлүүлэхэд онолын алдаа мадаг гарахад үл анзаарах, шинэ санаа оноо төрөхгүй байх зэрэг асуудал гарч болно. Тиймээс, төслийн хүрээнд зохион байгуулсан хичээлийн судалгаа мониторингийг ялангуяа орон нутгийн сургуулиуд тухайн судлагдахууны мэргэжилтнүүдээс шууд зөвлөгөө авах нэг чухал боломж хэмээн ойлгож талархан хүлээн авч байсан.

Хичээлийн судалгааны мониторингийг зохион байгуулахад, замын зардал, томилолтын хөлс зэрэг төсөв санхүүгийн асуудлыг шийдэх шаардлагатай болно. Харин, сургууль дээр байрлах үеийн хоол, байрны зардал зэргийг сургуулийн тал тодорхой хэмжээнд л хариуцах боломжтой юм. Мөн, мониторингийн дашрамд зэргэлдээ сургуулийн багш нарыг урьж оролцуулбал, илүү олон багш нарт суралцах боломж олгодог.

Төсөл дууссаны дараа ч, мэргэжилтнүүд болон их дээд сургуулийн багш нар, ЕБС-ийн туршлагатай багш нар зэрэг мэргэжлийн мэдлэг өндөртэй гадны хүмүүсээр хичээлийн судалгааны мониторингийг тогтмол хийлгэх нь зүйтэй.

3) Эрэлт хэрэгцээ ихтэй сургалт

